



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-23
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	24-119

1. Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	24-25
2. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	25-43
3. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай	43-73
4. “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	73-80
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	80-98
6. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлын санал хураалт	98-100
7. “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалт	100
8. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	101-119

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, П.Батчимэг, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан, Д.Мөнхтулга, Р.Сэддорж, Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Д.Ганмаа, Л.Оюун-Эрдэнэ, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, З.Мэндсайхан, С.Одонтуяа, Б.Тулга, Д.Энхтүвшин;

Тасалсан: Ц.Туваан;

Хоцорсон: О.Амгаланбаатар-07 минут, Ч.Анар-01 минут, М.Бадамсүрэн-23 минут, Э.Бат-Амгалан-14 минут, Ж.Батсуурь-05 минут, Б.Батцэцэг-11 минут, Ш.Бямбасүрэн-06 минут, Ж.Галбадрах-03 минут, С.Ганбаатар-43 минут, П.Ганзориг-11 минут, Т.Доржханд-59 минут, Б.Жавхлан-23 минут, Б.Жаргалан-05 минут, С.Замира-1 цаг 10 минут, Б.Заяабал-05 минут, Ж.Золжаргал-1 цаг 26 минут, Ч.Лодойсамбуу-05 минут, С.Лүндэг-04 минут, Ц.Мөнхбат-24 минут, Т.Мөнхсайхан-07 минут, Ц.Мөнхтуяа-28 минут, Ч.Номин-07 минут, Н.Номтойбаяр-03 минут, Б.Пунсалмаа-05 минут, Д.Пүрэвдаваа-02 минут, О.Саранчулуун-20 минут, А.Ундраа-12 минут, Н.Учрал-50 минут, Г.Уянгахишиг-09 минут, Ж.Энхбаяр-1 цаг 19 минут, Д.Энхтуяа-16 минут, С.Эрдэнэбат-13 минут, Р.Эрдэнэбүрэн-16 минут.

Нэг.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 34

Бүгд: 75
54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 31
Бүгд: 75
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 29
Бүгд: 76
61.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 30
Бүгд: 78
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 32
Бүгд: 81
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал хураалтаар үргэлжлэв.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр дагнан ажилладаг хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, У.Отгонбаяр, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27¹.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

27¹.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах хариуцлага оногдуулах;

27¹.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

27¹.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

27¹.2.4.гомдол, маргааныг урьдчилан сэргийлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүрэг.

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 34
Бүгд: 88
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 28
Бүгд: 91
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 33.3.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 29
Бүгд: 92
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.3 Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах бөгөөд ажлын 30 өдрийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг, Д.Цогтбаатар, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 46
Бүгд: 96
52.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 41
Бүгд: 96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бүлэг, дэд бүлэг, зүйлийн” гэснийг “бүтцийн” гэж өөрчилж, “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний урд “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал агуулгад нийцүүлэн” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 34
Бүгд: 96
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтын “сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан” гэснийг “сонирхол, хууль тогтоомжид нийцэх эсэхийг дүгнэн оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 40
Бүгд: 97
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 17.1 дэх хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар” гэснийг “хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 39
Бүгд: 97
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 18.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 36
Бүгд: 97
62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 38.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 37
Бүгд: 97
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 38.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 36
Бүгд: 97
62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 49.2 дахь хэсгийн “Засгийн газраас үүрэг болгосны дагуу” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 41
Бүгд: 97
57.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “15.7.1 дэх заалтын “иргэн, захиргаа,” гэснийг, 28.3.9, 28.8.6 дахь заалтын “шаардлагатай бол” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 40
Бүгд: 97
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, мөн төсөлд “**6 дугаар зүйл**.Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай гэсэн зүйл нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг 4 дүгээр зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2.2.17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, П.Сайнзориг, О.Номинчимэг, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.3 дахь заалтын “, жендерийн мэдрэмжтэй” гэснийг болон 17.3.2 дахь заалтыг тус тус хасаж, 17.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.3.4.хязгаарлалтыг нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийн 17.3.2 дахь заалтыг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	72
Бүгд:	97

25.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	67
Бүгд:	98

31.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.1 дэх заалтын “бусад” гэснийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	58
Бүгд:	98

40.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 58
Бүгд: 98
40.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 43
Бүгд: 99
56.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 40.1.11, 40.1.12 дахь заалтыг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, гаргасан саналаа татан авсан тул санал хураалт явуулаагүй болно.

8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

9.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 54

Бүгд: 100
46.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эрх, эрх чөлөөг” гэсний өмнө “хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 45
Бүгд: 100
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 2 дахь дэд заалтын “холбогдох хуулиудын төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан” гэснийг “судалгаа хийж, холбогдох хуулиудын төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд” гэж өөрчилж, энэ заалтад дор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд дор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгасугай:

1/Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;

2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж, дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг, сонирхлын зөрчил, авлига гаргах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 44
Бүгд: 100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг нийтийн эрх зүйн этгээдэд зөвлөсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Хэлэлцэж буй асуудалтай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Л.Золзаяа, Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Төрийн албаны зөвлөлд нэр дэвшүүлэх саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, Д.Амарбаясгалан, Ж.Баясгалан, Б.Бат-Эрдэнэ, Б.Уянга, Б.Бейсен, Л.Энхнасан, Э.Болормаа, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Ж.Баярмаа, Б.Хэрлэн, Б.Заяабал, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад нэр дэвшигч Л.Золзаяа, Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /12:58/

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Дөрөв. “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Ц.Баатархүү, Б.Жаргалан, Д.Амарбаясгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /14:32/

Тав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн Я.Цэлмэн, Улсын

ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Монголын Өмгөөлөгчдийн холбооны тэргүүн Л.Данзанноров, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга П.Оростогоо, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Сандаг, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэшлийн хорооны дарга Д.Батсүх, мөн холбооны Нийслэлийн өмгөөлөгчийн зөвлөлийн дарга Т.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, О.Номинчимэг, Л.Соронзонболд, С.Замира, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Энхбаяр, С.Замира нар үг хэлэв.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Да.Цогтбаатар /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	44
Бүгд:	100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 5 дахь хэсгийн “бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар” гэснийг “материалтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 43

Бүгд: 100

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 44

Бүгд: 100

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 44

Бүгд: 100

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14 дэх хэсгийн “шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 44

Бүгд: 100

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 5 дахь хэсгийн “гомдлыг” гэсний дараа “энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 40

Бүгд: 100

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/16.14 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9 дэх хэсэг:

“5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо

хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч, мэргэжилтний хийсэн үйлдэл, үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болно.

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	41
Бүгд:	100

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 8 дахь хэсгийн “зохих” гэснийг, мөн хэсгийн “тухай бүр” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалтын 3 дахь хэсгийн “оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг” гэснийг “оруулсан тогтоолыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	39
Бүгд:	100

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “хамаарах хэсгийг нууцлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын “бусад баримтыг” гэсний дараа “энэ хуульд заасан журмын дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 1.8 дахь заалтын “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 43
Бүгд: 100
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж, мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалтын 8 дахь хэсгийн “хавсаргуулна” гэснийг “хавсаргаж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 42
Бүгд: 100
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 15 дахь заалтын 9 дэх хэсгийн “оролцогч” гэсний дараа “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төлөөлж болно” гэснийг “төлөөлнө” гэж”, гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 40
Бүгд: 100
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 38
Бүгд: 100
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн, 3 дугаар зүйлийн “зүйл” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийн “заасны” гэснийг “заасан журмыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 39
Бүгд: 100
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шинжээч” гэсний дараа “сэжигтэн,” гэж” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 37
Бүгд: 100
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын “2.12” гэснийг “2.13” гэж, мөн зүйлийн 7 дахь заалтын “5” гэснийг “6” гэж, мөн зүйлийн 13 дахь заалтын 6 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 38
Бүгд: 100
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17” гэснийг “2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16” гэж, мөн зүйлийн “31.2 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.2 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа” гэснийг” гэж, мөн зүйлийн “31.3 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.3 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах” гэснийг” гэж тус тус өөрчлөх өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 38
Бүгд: 100
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 34.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг хасах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, П.Сайнзориг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулж, төрийн нууцад хамаарах хэсгийг нууцлан гардуулан өгнө.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар” гэснийг,” гэснийг хасаж, 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10/16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж тайлбар, мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан тайлбар, мэдүүлэг, бусад нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд тайлбар, мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болохгүй.” гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Хоёр.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	40
Бүгд:	101

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлын санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Бадамцоогийн Идэрчулууныг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	43
Бүгд:	101

57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Должингийн Баатарсайханыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	38
Бүгд:	101

62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 37

Бүгд: 101

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:46/

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 42

Бүгд: 101

58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 45

Бүгд: 101

55.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Бадамдоржийн Төгсцэнгэлийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 40

Бүгд: 101

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс

асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:48/

“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 34
Бүгд: 101
66.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, хуулийн төслийн талаарх Засгийн газраас гаргасан дүгнэлтийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг, О.Цогтгэрэл, Д.Амарбаясгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Засгийн газраас өргөн мэдүүлэх Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хүртэл хугацаанд хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 44
Бүгд: 96

54.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулав/17.04/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 52 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая 66 гишүүн бүртгэгдэж, ирц 52,4 хувьд хүрсэн байна 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 19-ний нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар нийт 6 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

2 дугаарт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

3 дугаарт Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойш “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

5 дугаарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

6 дугаарт Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нарын 41 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

Хэлэлцэх асуудалд оръё.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд суудлаа эзэлъе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Ирцэд бүртгэгдсэн гишүүдээс 44 гишүүн санал хураалтад оролцсон байна. Гишүүдийг танхимд орж ирэхийг дуудъя. Санал хураалт эхлүүлъя. Ердийн олонхоор санал шийдэгдэнэ. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн буюу 54,7 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 44 гишүүн буюу 58,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 47 гишүүн буюу 61,8 хувиар санал дэмжигдлээ.

4.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 48 гишүүн буюу 61,5 хувиар санал дэмжигдлээ.

5.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 49 гишүүн буюу 60,5 хувиар санал дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.06 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Хууль, тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 30 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр дагнан ажилладаг хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Ажлын хэсгийн дарга Одсүрэнгийн Номинчимэг гишүүнд үг өгье.

О.Номинчимэг: Бүгдэд өдрийн мэнд хүргэе. Энэ санал дээр жоохон дахиж найруулгыг нь илүү ойлгомжтой болгохоор байгаа. Ер нь зорилго нь нэг боловч үг, үсэг дээр дахиж найруулаад, тодорхой болгох асуудал байгаа учраас дахин боловсруулах чиглэл өгөхийг Улсын Их Хурлын даргаас хүсье.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27¹.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

27¹.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах хариуцлага оногдуулах;

27¹.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

27¹.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

27¹.2.4.гомдол, маргааныг урьдчилан сэргийлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүрэг.

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд, /цаашид “ажлын хэсэг” гэх/Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд үг өгье.

Б.Пүрэвдорж: Би нэг асуудал дэвшүүлчхээд, тэрний дараа яг энэ асуудлаар ярина. Тэр тэтгэврийн зээлийн асуудлаар нэлээн олон хүмүүс над руу мессеж ирүүлж байгаа. Үүнийх нь дагуу бүтэн сайн өдөр би Хархорины бүтээн байгуулалтын нээлт дээр явж байхад Хаан банкны захирал болон Монголбанкны Ерөнхийлөгч

Лхагвасүрэн нартай уулзаж, асуудлыг тодруулсан. Тэд нар бол хуучнаараа болгосон л гэж байгаа юм. Гэвч ахмадууд банк дээр очихоор нөгөө 50/50 хэвээрээ, хугацаа нь богино хэвээрээ. Дээрээс нь шинээр зээл авахад шимтгэл дахиж авах хэвээрээ. Тэгээд ийм л нөхцөл байдалтай байна.

Тийм учраас 1 дэх өдөр Монголбанкны Ерөнхийлөгч, Хаан банкны захирал болон хамгийн их зээл олгодог Төрийн банкны захиралтай сууж байгаад, яг энэ асуудлуудаар яаж яаж шийдвэрлэсэн юм бэ, доошоо яаж үүрэг өгсөн юм бэ гэдгээ хэвлэлийн хурал хийчихгүй бол болохгүй байна. Тийм учраас дарга ч гэсэн та бас энэ талаар Их Хурлын дарга Амарбаясгалан бид 2 нэлээн сайн ярилцсан. Тэгээд энэ талаар бас чиглэл өгнө гэж Амарбаясгалан дарга бас хэлсэн байгаа.

Хоёрдугаарх нь бол зээл тэглэсэн. Зээл тэглээд 700 тэрбум төгрөгийн зээл тухайн үед байсан юм байна лээ. Тэгээд тэрийг тэглэсэн. Гэвч өнөөдрийг хүртэл тэр тэглэсэн зээл Монголбанк дээр өр хэвээрээ. Тэр нөгөө компаниас Эрдэнэ Силвер гэдэг компаниас төлөгдсөн 1 сохор зоос ч байхгүй, өртэй хэвээрээ байгаа.

Гэтэл үүнээс хойш яасан бэ гэхээр маш их олон хүмүүс өндөр зээлтэй байж байгаад, тэрийгээ тэглүүлчихлээ гээд манай ахмадууд зээлийнхээ хэмжээг нэмэгдүүлж эхэлсэн. 700 тэрбум төгрөгийн зээл байсан бол одоо 2,1 их наяд болчихсон байж байгаа. 3 дахин ихэссэн. Яаж байна гэвэл бид нар байж байгаад жоохон шахалт үзүүлэх юм бол зээл тэглэхчхэн гэдэг ийм хоосон тийм зүйлээр зээлээ ихэсгээд, энэ хугацаандаа асар их хүү 17 хувийн хүүтэй. Уг нь бол зээл авахгүйгээр амьдрах зөндөө олон ахмадууд байгаа. Тэд нар Монголын банкнуудад, арилжааны банкнуудад өндөр хүүтэй хамаг мөнгөө өгөхгүйгээр, хуримтлал үүсгэхгүй юмаа гэхэд өөрсдийнхөө асуудлаа шийдээд явах боломжтой.

Гэтэл энийг ингээд зээл тэглэхчх байх гэдэг итгэл найдвараар асар их зээл аваад, тэгээд тэрийгээ үр дүнгүй зарцуулдаг, үр хүүхдэдээ хамаа намаагүй өгдөг ийм зүйл байгаад байна. Тэгэхээр би нэлээн олон сайд нар, Ерөнхий сайд энэ тэрнээс асуусан. Ойрдоо зээл тэглэх юм уу гэхээр огт тийм юм байхгүй шүү гэж байгаа юм. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд бас яг энэ асуудал дээр ойрын үедээ манай Засгийн газар зээл тэглэхгүй гэдгээ хэлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ ахмадууд чинь баахан зээл авдаг. Тэгж байгаад Монголын төр зээл тэглэхчх байх гэж найдаад ингээд 3 дахин зээлээ ихэсгэчихсэн байна шүү дээ. Тийм учраас энэ дээр тодорхой хариулт өгөхгүй бол 2,3 банкны л өндөр хүүг төлдөг ийм иргэд болж хувирч байна шүү. Тийм учраас энэ зээл дээрээ жоохон бодолтой зээлээ аваарай гэж ахмадууддаа хэлмээр байна.

Тэгээд энэ саяын энэ заалтыг дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн ажлын хэсгээс гаргасан саналыг дэмжиж үг хэллээ. Өөр гишүүд байна уу. Тэгэхээр санал хураалт. 54 гишүүн буюу 61,4 хувиар санал дэмжигдлээ.

Би бас нэг зүйлийг хэлье гэж бодож байна. Гишүүд маань яг Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу ажлаа явуулна. Яг дэгээр ямар эрх хэмжээ олгогдсон яг тэр хэмжээгээрээ. Сүүлийн үед мэдээж Улсын Их Хурлын олонх, цөөнх, тэгээд Улсын Их Хурлын гишүүдийн бас байр суурь, үзэл бодлоо илэрхийлж байгаад нь илүү нээлттэй, чөлөөтэй хандах байдлаар шаардагдах минутыг нэмж өгөхөөс өгсүүлээд олон асуудлаар бас уян хатан ажиллаж байгаа. Гэхдээ энэ нь бас ингээд

нөгөө боломжийг бүгд хавтгайруулах хэлбэр лүү ороод байгаа. Тийм учраас энийг хавтгайруулахгүй, яг зарчмынхаа дагуу, Дэгийн хуулийн дагуу явж байх юм дээр гишүүд бид анхаарлаа хандуулж ажиллана. Ер нь тэгээд Улсын Их Хурал гэдэг байгууллага дээрээ хөлөө олж байвал, дороо гүйдлээ олно гэдгийн адилаар бид эмх цэгцтэй, зарчимтай, нээлттэй, ил тод байх юм бол олон нийт илүү их тийм сэтгэл хангалуун байх нөхцөл бүрдэх учраас энэ Дэгийн тухай хууль дээрээ бүгдээрээ анхаарлаа хандуулж ажиллана гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Дөнгөж 2 хоногийн өмнө энэ урд талаар дүүрээд суугаад байсан хүмүүс маань өнөөдөр орж ирэхгүй болоод эхэлж байна. Энэ бол Засгийн газрын гишүүнээр томилогдсоны маргаашийнх нь хурал. Тийм учраас энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шадар сайд, Тэргүүн Шадар сайд гэх мэт албан тушаалтнууд 4 дэх өдөр, 5 дахь өдрийн чуулганы хуралдаанд оролцож байх учиртай. Ядаж өглөө ирцдээ ирээд, чөлөө авах шаардлагатай, өөр ажил давхардаж байгаа бол учир байдлаа тайлбарлаад, явдаг байх шаардлагатай гэдгийг бас хариуцлагатайгаар анхааруулж, хэлж байгаа.

Улсын Их Хурлыг олон нийт хариуцлагатай идэвхтэй ажиллахыг байнга шаарддаг. Энэ шаардлагыг хангуулж ажиллах нь бас миний хувьд, хурал даргалагчийн хувьд үүрэг гэж бол харж байгаа. Тийм учраас сонгогдсон, шинээр томилогдсон сайд нарыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хүндэтгэлтэйгээр, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж оролцож байхыг үүрэг болгож хэлж байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63 гишүүн буюу 69,2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 33.3.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 гишүүн буюу 68,5 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.3 Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах бөгөөд ажлын 30 өдрийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Пүрэвжавын Сайнзориг гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Энэ заалтыг яах вэ өөрчлөн найруулж байгаа юм. Тэгэхдээ орж ирсэн заалт маань ч гэсэн яах вэ зүгээр ийм тодорхой Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүхэд хянан

шийдвэрлэхтэй холбоотой процессын хууль гээд нэр заагаад л энэ хуулиудыг заавал Дээд шүүх, прокуророос авна гээд байгаа. Бусад хуулийг ч гэсэн бүгдийг нь авах ёстой байхгүй юу. Яагаад ингээд нэр заагаад ийм хуулиудыг авна гээд байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа. Ерөөсөө аливаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэрэглэх байгууллагуудаас бүгдээс нь авах ёстой хууль тогтоомжийн хуулиар. 39.1 дүгээр зүйл дээр байгаа.

2 дугаарт практикийн хувьд бол нэг ийм юм байдаг юм. Бас яах вэ, зүгээр практикийн хувьд гэж ярьж байгаа шүү. Улсын Дээд шүүх бол үндсэндээ яг 20 хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байдаг. 7 сараас бараг 9 сарын сүүл хүртэл ерөнхийдөө бүрэлдэхүүн бараг байдаггүй. Амарчихдаг. Тэгээд энэ хугацаанд ингээд хууль тогтоомжийн хууль яахаар 30 хоног боллоо гээд л Улсын Дээд шүүхийн саналгүй, тусгайлан өгөх саналгүй гэдэг л баахан хуулиуд орж ирэхээр байна. Орж ирэхээр байна. Тэгэхээр ийм зүйлүүдийг уг нь ийм хуулиудаар ингэж бараг Улсын дээд шүүх, прокурорын саналгүй орж ирэх бололцоог бүрдүүлж байгаа ийм хуулийн заалт орж ирж байгаад жоохон харамсаад байгаа юм.

Тэгээд нэр заагаад л ийм хуулиудыг л авна. Бусдуудыг нь авахгүй гэдэг логикоор ингээд өөрчлөн найруулчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энийг уг нь бол гүйцээн боловсруулах чиглэл аваад, ажлын хэсгийн ахлагчийн уг нь явчихмаар байгаа юм. Тэгээд харахад санал авна гэдэг тийм сайн заалт юм шиг боловч яг эцсийн дүндээ бас дараа нь бол сөрөг үр дагавар гарч болзошгүй л гэдэг зүйлийг би протоколд хэлье дээ.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Үндсэн хуулиар хүний үндсэн эрхийн асуудал хөндөгдсөн байдаг. Тэгэхээр энэ үндсэн эрх зөрчигдөхгүй байх асуудлыг хууль тогтоож байгаа байгууллага мэдээж хэрэг онцгой анхааралтай хандуулж ажиллаж байх шаардлагатай. Энэ утгаараа Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Хүний эрхийн комисс дагнаж мэргэшиж ажиллаж байгаа байгууллага өөрөө аливаа хуулийн төсөлд тодорхой санал өгдөг байх нь зарчмын хувьд зөв юм л гэж үзэж байгаа юм.

Ер нь аливаа төрөөс гарч байгаа шийдвэрт эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын саналыг тусгаж, шийдвэр гаргаж чадах юм бол тухайн шийдвэр илүү амь бөхтэй, урт наслах боломж нь бүрдэх тийм л талтай. Тийм учраас зүгээр энэ саналыг хураагаад явчихвал зөв болов уу. Ажлын хэсгийн дарга Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ санал бол илүү бас тодотгож, яг энэ хамгийн чухал хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжоос заавал Хүний эрхийн комиссоос санал авах процессыг хуульчилж өгч байгаа юм. Яах вэ Сайнзориг гишүүний хэлж байгаа 39.1 дээр ер нь хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төсөлдөө түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагаас санал авна гээд ерөнхий зохицуулалт байгаа. Тэгээд үүний дагуу бол янз бүр практик харахаар зарим нь бол Засгийн газар луу санал аваад л явуулчихдаг. Засгийн газар тэр үедээ Хүний эрхийн комисс руу явуулах уу, үгүй юу. Хууль санаачлагч өөр этгээд байх юм бол эндээс санал авах уу, үгүй юу гэдэг маань өөрөө практик дээр харилцан адилгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр яг хүний эрхтэй холбоотой асуудлыг заавал Хүний эрхийн комиссоос авъя. Процессын, шүүхийн процесстэй холбоотой суурь хуулийг бол заавал

хэрэгжилтийг хэрэглэж ашигладаг шүүхээсээ авъя гэдэг зүйлийг илүү тодотгож өгч байгаа. Ажлын 30 хоног гэдэг энэ бол угаасаа ч одоо хэрэглэгдэж байгаа практикт хэрэглэгдэж байгаа юм. Энийг хугацаагүй байлгана гэдэг нь өөрөө хууль санаачлагчид хэрвээ Дээд шүүхээс ч юм уу, Комиссоос юу гэдэг юм 3 сар, 4 сар санал ирэхгүй байх юм бол хууль санаачлах бүрэн эрхэд нь халдана гэж үзэж байгаа. Одоо ч практикаараа Засгийн газраас хууль санаачлагч жишээ нь санал авахад ажлын 30 хоногийн процесс байдаг. Засгийн газар маань ч гэсэн өөрсдөө санал авахдаа 30 хоногоороо ингээд хязгаарлаад явдаг ийм байгаа. Тэгэхээр Дээд шүүхийнхний бүрэлдэхүүн амрах цагаар гэдэг зүйлээр энэ Дээд шүүх бол байнгын ажиллагаатай ажиллаж байх ёстой. Тэд нарын амралтад зориулж бид нар хууль батална гэсэн юм байхгүй. Энэ бол зарчмын асуудал байгаа гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар гишүүнд үг өгье.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Бид нар ер нь төрийн байгууллагууддаа бол хүндэтгэлтэй хандаж байх ёстой. Төрийн байгууллага нэгэнт ажиллаж байгаа бол амралтын хугацаанд ч үйл ажиллагаа нь үргэлжлээд явж байдаг. Хэзээ ч тасардаггүй. Тийм учраас бид нар ч Их Хурал тарлаа гээд шинэ Их Хурал бүрдэхэд дараагийн хүн тангаргаа өргөх хүртэл нөгөө Улсын Их Хурлын гишүүд байж байгаа шүү дээ. Бүр тэрнээс 1 цагийн өмнө гэнэтийн асуудал гарах юм бол өмнөх Их Хурал нь хүрч ирээд, хууль тогтоомж ямар нэгэн онцын шаардлагатай юмаа гаргаад явна шүү дээ. Тэгэхээр төрийн ажиллагаа 1 ч цагаар тасардаггүй. Тэр амарч байх үед нь тэр нь таарлаа гэхэд тэрийг хариуцсан хүмүүс 1 дүгээрт байдаг. Тэгээд саяын би энэ ажлын хэсгийн даргатай яг санал 1 байна. Энэ дээр бол төрийн ажиллагаа тасрахгүй, тэр 30 хоногт тааруулна гэж 1 дүгээрт байж болохгүй.

2 дугаарт өнөөдөр иргэн аливаа нэгэн асуудал яахад захиргааны байгууллагууд эргээд хариу өгөхдөө угаасаа тэр хугацаа байж байгаа. 30 хоногийн дотор байна уу хариугаа өгөөд явах үүрэгтэй байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр тэр амралт бол ярина гэж ерөөсөө байж болохгүй. Энд тааруулж хууль гаргана гэх юм бол ерөөсөө ямар ч хууль явахаа болино гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл гишүүн үг өгье.

О.Алтангэрэл: Яах вэ нөгөө асуудлыг нь мэдэхийн хувьд үгүй ээ, яг үнэндээ бол Монгол Улсын дээд шүүх чинь 7 сар гэж амраад, 10 сард орж байгаа шүү дээ. Олон жил ингэж явж байгаа. Ерөөсөө буруу биш. Шүүгч нар нь маш олон жил ажиллаж байгаад шүүгч болдог. Хуулиараа ажлын маш олон хоног амардаг. Тэр дунд нь 7 сар таардаг. Үгүй ээ, бид нар бодитой байгаа байдлаа ярих л ёстой байхгүй юу. Улсын Дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаа хийгээд, хуулийн төсөлд санал өгдөг. Дээд шүүх бол сайн санал өгдөг. Тэгэхдээ нийт шүүгчдийн хуралдаан гэдэг чинь байнга өдөр болгон, байнга болоод байдаггүй юм. Жилийн бүтэн 3 сар амардаг. Харин Дээд шүүхээс бол ямар санал тавиад байгаа вэ гэхлээр бид нар Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжуудад өөрсдөө саналаа заримдаа эсрэг байр суурьтай юм уу байвал бид нар Улсын Их Хурлын чуулганд уншиж сонсгодог байдлаар та нар өөрчлөх боломж бололцоо байна уу гэдэг асуудал тавьдаг. Тэгээд бид бол ямар байхыг ярих нь нэг хэрэг. Би бол энэ санал дэмжигдээд явбал Сайнзориг гишүүний хэлснээр харин ч одоо байгаа харилцааг хязгаарласан шинжтэй болно гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Юу шүү дээ, Алтангэрэл гишүүн ээ. Дээд шүүх чинь байнга амраад байхгүй шүү дээ. Алтангэрэл гишүүн Дээд шүүх чинь байнга амраад байхгүй биз дээ. Тэр Дээд шүүхийн амарч байгаа ганц сарын хугацаанд хууль зохицуулалт өргөн барилт тэгээд зохицуулж болох л зүйл л дээ. Тэгээд Дээд шүүхийн амралттай зохицуулаад Монгол Улсын хууль санаачлах, өргөн барих хуульд хүний эрхийн зөрчил байгаа эсэхтэй холбоотой асуудлыг дүгнэлт хийх, зөвлөмж өгөх эрх хязгаарлагдаж болохгүй л гэж ингэж бодож байна. Яах вэ тэгээд гишүүд маань санал хураалтаар асуудлаа шийднэ биз. Санал хураалт. 5 дахь асуудал. Санал хураалт. 50 гишүүн буюу 52,1 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Сайнзориг гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Гишүүдийг энэ саналыг дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм. Ямар заалт орж ирж вэ гэхээр хууль өргөн мэдүүлэхээс өмнө хууль санаачлагчийн бүрэн эрхэд бас тодорхойгүй байдал үүсгэхээр ийм заалт байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны асуудал эрхэлсэн хүрээлэн энэ хуулийн 17.2-т заасан хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг ажлын 5 хоногийн дотор хийнэ гэж байгаа юм. Тэгэхээр өргөн барихаас өмнө ийм зүйлүүдийг хийж болохгүй. Одоо ч практикаараа хийж байгаа. Энэ төслийн үр нөлөөгөөр хийдэг. Харин уг асуудлыг агуулгын хувьд цаашдаа Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд оруулж өгөөч гэж би хүсэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол өргөн баригдаад, хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа ажлын хэсгээс магадгүй Улсын Их Хурлын даргаас, Байнгын хорооноос чиглэл өгсний дагуу өргөн барьсан төсөл дээр бас энэ судалгааны хүрээлэн ийм зүйлийг дүгнэлт гаргаадахаач гэвэл болдог байх ёстой. Өргөн барихаас нь өмнө ийм маргаан хууль санаачлагчийн эрхийг хязгаарлаж байгаа ийм зүйлүүд байж болохгүй.

Ингээд парламентын эксперт гэдэг юм уу, судалгааны хүрээлэнгийнхэн 1 юм бичнэ. Бөөн маргаан гарна. Тэгээд сүүлдээ энэ хуулиа өргөн барьж чадах эсэх асуудлууд үүсэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлүүдийг анхаараад, би зүгээр агуулгын хувьд энэ хууль тогтоомжийн хууль дээр байх ёсгүй юм байна. Цаашдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр энэ асуудлыг оруулъя гэдэг агуулгаар бас энэ саналыг гаргаж, хасуулж байгаа шүү гэдэг зүйлийг гишүүддээ хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг, Байнгын хороо дэмжихсэн санал тийм үү. Санал хураалт. 55 гишүүн буюу 57,3 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар зүйлийн “бүлэг, дэд бүлэг, зүйлийн” гэснийг “бүтцийн” гэж өөрчилж, “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний урьд “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал агуулгад нийцүүлэн” гэж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 гишүүн буюу 64,6 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56 гишүүн буюу 58,3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтын “сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан” гэснийг “сонирхол, хууль тогтоомжид нийцэх эсэхийг дүгнэн оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин. Санал хураалт. 57 гишүүн буюу 58,8 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 17.1 дэх хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар” гэснийг “хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58 гишүүн буюу 59,8 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 18.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 62,9 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 38.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 гишүүн буюу 61,9 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 38.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-д заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 62,9 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 49.2 дахь хэсгийн “Засгийн газраас үүрэг болгосны дагуу” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56 гишүүн буюу 57,7 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 5 дугаар зүйлийн “15.7.1 дэх заалтын “иргэн, захиргаа, ” гэснийг, 28.3.9, 28.8.6 дахь заалтын “шаардлагатай бол” гэснийг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57 гишүүн буюу 58,8 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, мөн төсөлд “**6 дугаар**

зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай гэсэн зүйл нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг 4 дүгээр зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2,2.17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Номинчимэг гишүүнд үг өгье.

О.Номинчимэг: Түрүүн төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 буюу Сайнзориг гишүүний санал дэмжигдсэнтэй холбоотойгоор энийг бас дурдсан Тамгын газрын бүрдэл хангах чиг үүрэг дээр энэ дурдагдсан байгаа учраас найруулгын санал дээр гүйцээн боловсруулах чиглэл аваад, төслийн бусад зүйл заалтыг нийцүүлэх шаардлагатай байгаа учраас гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан. Санал гаргасан гишүүн Жаргалан гишүүнд үг өгье.

Б.Жаргалан: Энэ ямар учиртай заалт вэ гэхээр Засгийн газраас хүсэлт гаргаад, аливаа хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх нөхцөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан төслийн үр нөлөөний үнэлгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ шаардлагагүй гэсэн ийм заалт ороод ирчихсэн байгаад байгаа юм. Тэгэхээр миний санал юу вэ гэхээр хэдий аливаа хуулийн төслийг яаралтайгаар оруулж ирэх болох боловч хууль тогтоомжийн хуульд заасан энэ төслийн үр нөлөөний үнэлгээ, бусад холбогдох бүрдүүлбэрүүд бол бас зайлшгүй хангагдах ёстой гэсэн агуулгаар энэ заалтыг хасъя гэсэн санал оруулсан байгаа юм. Тэгэхээр та бүхэн маань хасах агуулгаар нь дэмжээд өгөхийг хүсье. Битгий хүрээрэй.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би яг Жаргалан гишүүний саналтай адилхан байна. Битгий кноп дээрээ хүрээрэй гэж хүсэж байгаа юм. Энэ ажил гацаана. Яаралтайгаар өргөн барих хуулийн төслүүдийг хүсэлт гаргаад, энэ судалгаануудаас чөлөөлдөг байсан юм. Яах вэ, судалгааг хийлгэж болно. Судалгаа хийлгэж болно. Хийлгэхдээ зөвхөн тандан судалгааг хийлгэнэ гэхчихсэн. Гэтэл яаралтайгаар өргөн барьж байгаа бүх хуулиуд чинь яг ийм шинэ харилцааг зохицуулах гэж байгаа асуудал биш. Хэрэгжиж байгаа

энэ харилцаан дээр дүгнэлт өгөөд, болохгүйг нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгээд бас орж ирэх бололцоотой байхгүй юу.

Гэтэл энэ яаралтай өргөн барих хуулиуд чинь зөвхөн шинэ харилцаа байна шүү. Тандан хийнэ. Зардлын үр нөлөө хийнэ гэхихсэн. Хэрэвзээ бид нар үүгээр ингэх юм бол Засгийн газар сая Биржийн тухай хуулийг оруулж ирээд, хэрэгжиж байгаа хууль дээрээ дүгнэлт өгөөд, энэ заалт болохгүй байгаа юм гээд орж ирэх бололцоогүй болгож байгаа байхгүй юу. Амьдрал баян шүү. Өнөөдөр улс орны эдийн засгийн нөхцөл байдал янз янзын асуудлууд гарлаа гэхэд хэрэгжиж байгаа хуулийнхаа асуудлыг дүгнээд, энэ заалтыг ингэж сайжруулмаар байна, яаралтай хэлэлцээд өгөөч ээ гэхээр бид нар боломжгүй болгоод хураах гэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ дээр бас илүү тодруулж хэлье. Жаргалан гишүүний санал яаралтай горимоор өргөн барьж байгаа хуульд энгийн горимоор өргөн барьж байгаа хуультай яг адилхан зардлын тооцоолол, хэрэгжилтийн үнэлгээ, тандан судалгаа, бүгдийг нь хийж хийх ёстой гэсэн зарчмын санал байгаа. Тэгж энэ санал нь орж ирсэн. Сайнзориг гишүүн бол өмнөх журмаараа буюу энэ их олон юмыг хийх юм гацаана. Тийм учраас энийг нь хасъя гэсэн. Та бас Төрийн нарийн бичгийн дарга байхдаа энэ асуудлыг ингэж оруулж ирж байсан учраас хэлж байна. Энэ хуулийн төсөлд бол энэ төсөл боловсруулж орж ирэхдээ яаралтай горимоор өргөн барьж байгаа хуульдаа тандан судалгаа болон зардлын судалгааг хийнэ гэж байгаа юм.

Та бүхэн мэдэж байгаа ковидын хууль янз бүрийн хуулийг бид нар оруулж ирдэг. Анхны харилцаа байдаг. Энэ дээр үнэхээр судалгаагаар тандан судалгаа хийгээд хэрэгцээ шаардлага нь юун дээр байна гэдгийг чиглүүлэхэд энэ чухал. Дээр нь ямар зардал гарах юм бэ гэдэг бол түргэн хугацаанд хийх боломжтой гэж үзээд, хууль санаачлагчийн зүгээс энэ 4 шаардлагынх нь 2-ыг нь яаралтай горимоор өргөн барих энэ хууль дээр хийе гэдэг энэ шаардлагыг тавьж орж ирсэн байгаа юм.

Д.Амарбаясгалан: За байз энэ Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Манайхан маргалдаад яах вэ, би гишүүддээ хэрэгтэй, бас яг энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой 1 мэдээлэл дуулгах гэсэн юм. Одоо энэ Хууль тогтоомжийн тухай хууль бид нар ярьж байна. Тэгээд хуулийн харьцуулсан судалгаа их чухал байдаг. Бусад улс орнууд тухайн харилцааг яаж зохицуулж байна. Ямар эрх зүйн актаар зохицуулж байна. Яаж зохицуулдаг юм байна гэдэг асуудал их чухал байдаг.

Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тендер зарлаад, энэ 5 дугаар сард НҮБ-ын үндсэн 5 хэл дээр дэлхийн улс орнуудын хуулийг харьцуулсан судалгаа хийх хиймэл оюуны платформын тендер зарлагдаад, Чимэгэ систем гэдэг компани шалгараад ажилдаа орсон. 11 дүгээр сараас манай Улсын Их Хурлын гишүүд манай Их Хурлын Тамгын газрынхны утсан дээр хиймэл оюунаар тухайн гишүүний санаачилж байгаа хууль болон сонирхож байгаа асуудлаар дэлхийн улс орнуудын туршлага, харьцуулсан судалгаа хийдэг ийм платформ нэвтэрч байгаа шүү гэсэн энэ мэдээллийг дуулгая. Тэгээд Жаргалан гишүүний саналыг дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Энэ чинь тэгээд яаралтай горимоор өргөн барьдгийн ач холбогдол үлдэх үү. Энэ яаралтай горимоор өргөн барихтай холбоотой асуудал. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Үгүй ээ, Сайнзориг гишүүн, Жаргалан гишүүн 2 нэг санал хэлээд байгаа юм шиг мөртөө 2 өөр үндэслэл яриад байгаа байхгүй юу. Сайнзориг болохлоор яг ажил гацаана гэж яриад хүний толгой эргүүлээд манипуляц хийгээд байх юм. Тэгээд Хууль зүйн байнгын хороон дээр, мэргэжлийн байнгын хороон дээр яриад шийдчихсэн юман дээр Алтангэрэл сайд бас сайдын ажлаа хийхээ больчихоод бас яагаад байр суурь илэрхийлээд байгаа юм. Би санаачлагчийн хувьд байр суурь илэрхийлж байна.

Д.Амарбаясгалан: Энэ асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.3 дахь заалтын “, жендерийн мэдрэмжтэй” гэснийг болон 17.3.2 дахь заалтыг тус тус хасаж, 17.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.3.4.хязгаарлалтыг нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Одсүрэнгийн Номинчимэг гишүүнд үг өгье.

О.Номинчимэг: Энэ ингээд 2, 3 санал нэг багцад болчихсон явж байгаа юм. Тэгээд энэ хамгийн анхны Хууль зүйн байнгын хорооны хурлаар гишүүд ирцдээ орсон боловч, санал хураалтад оролцохгүй байдлаас үүдээд, ажлын хэсгийн санал уначихсан байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө нөгөө хууль боловсруулагч, санаачлагч маань хүний эрхтэй холбоотой асуудал оруулж ирэхдээ заавал шалгуур үзүүлэлтээр анализ, дүн шинжилгээ хийж оруулж ирэхтэй холбоотой бас ийм заалт байгаа. Тэгэхээр гүйцээн боловсруулах чиглэл аваад, энийг Байнгын хороо дээрээ дахиж ярилцаад, оруулж ирэх саналтай байна.

2 дугаарт түрүүний Алтангэрэл сайд бас гишүүний хувиар санал илэрхийлж байх шиг байна. Гэхдээ ажлын дэд хэсэгт Хууль зүйн яамнаас таныг сайд байх үед ороод, тэр Дээд шүүхтэй холбоотой, хугацаанд санал авах асуудал дээр Хууль зүйн яамныхан маань бүр ажлын 30 биш энгийн 30 болгоё гэдэг саналыг бас оруулж ирээд явж байсан зүйл байгаа шүү. Одоо салбарын сайд байж байсан хүн маань өөрийнхөө яамныхаа гаргасан бодлого саналтай зөрчилдсөн бас зүйл хэлээд байна гэдгийг анхааруулж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Манай 126-тай парламентын бас нэг том онцлог нь маш олон мэргэжлийн хуульчид бас энэ парламентад орж ирсэн байгаа. Нийт гишүүдийн 25 орчим хувь нь хуульчид байгаад байгаа юм. Тэгээд хуульч гишүүд маань харах өнцгөө зөвхөн өөр өөрийн өнцгөөс биш, улс орны эрх ашгийн өнцгөөс нь харж, байр сууриа бас нэгтгэх газраа нэгтгэж, зөрөх газраа зөрж, Улсын Их Хурал дээр хоёрдмол байдал үүсгэхгүй байх дээр их сайн анхаарахгүй бол мэргэжлийн хуульчдын үгийг бусад мэргэжлийн Улсын Их Хурлын гишүүд сонсож, саналыг нь үндэслэж санал өгч байгаа. Тэгэхээр ингээд чуулганы танхимд ажлын хэсэг, Байнгын хороогоор дамжиж дамжиж орж ирчхээд тэгээд эсрэг, тэсрэг байр суурь илэрхийлээд байхаар энэ гишүүд чинь шийдвэр гаргаж чадахгүй болно шүү. Гишүүд эцсийн бүлэг дээр мэргэжлийн

хүмүүсийг сонсох хандлага илүү байдаг гэдгийг бас та бүхэн бодож байгаарай. Тэгээд 2 хуульч 3 саналтай гэдэг үг яваад байдаг юм байна лээ. Та бүхэн маань тийм байдлыг битгий үүсгээрэй гэдгийг бас хүсэж байна. 2 дахь санал хураалт гүйцээн боловсруулах чиглэл авсан.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийн 17.3.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан. Санал хураалт. 25 гишүүн буюу 25,8 хувиар санал унасан байна. Үндсэндээ гаргасан санал нь үлдэж байна гэсэн үг.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Санал хураалт. 31 гишүүн буюу 31,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.1 дэх заалтын “бусад” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин. Санал хураалт. 40 гишүүн буюу 40,8 хувиар санал уналаа. Энэ Засгийн газрын гишүүд танхимд орж ирж санал хураалтад оролцъё.

5 дахь асуудлаар санал хураалт явагдана. Пүрэвдорж гишүүн үг авч байна.

Б.Пүрэвдорж: Ардын намын 2, 3 гишүүн бас хоорондоо зөрчилдөөд байгаа юм. Юунаас болсон бэ гэхээр Сайнзориг гишүүн бас 1 юмны учрыг нь мэдэхгүй, өөрөөр хэлбэл нөгөө Улаанбаатар хот руу орж ирдэг хөдөөгийн хүмүүсийн төлбөрийг авах тухай асуудлыг үүгээр ингээд байхгүй болгож байна гэж үзээд баахан явсан юм шиг байна лээ. Гэтэл яг тэр нөгөө хөдөөгөөс орж ирэх тэр автомашины хураамжийн шийдвэрийг яг хуулийн дагуу Иргэдийн хурал гаргасан. Гэтэл жишээ нь энэ хуулиар бол Иргэдийн хурлаар гарч байгаа шийдвэрт бол ерөөсөө ямар ч тийм нөлөөлөл үзүүлэхгүй. Энэ чинь бүрэн нутгийн өөрөө удирдах ёсны бүрэн эрхийн асуудал. Тэр татвар хураамжийг ногдуулах асуудлыг эндээсээ цаашлуулаад хотын даргад өгч болохгүй л гэдэг ийм л асуудал байгаа юм. Тийм учраас эхнээсээ ингээд нөгөө Нямбаатартаа бас үнэнч царайлах гэж явж байгаад, тэгээд түүнийгээ хамгаалж баахан давхиад, тэгэнгүүт тэрийг нь Номинчимэг нарын гишүүд эсэргүүцэхээр л ингээд энэ хууль дээр бас янз янзын юм яриад л яваад байгаа юм. Тэгээд наадах энэ Номинчимэг энэ тэр чинь бас олон жил хууль юугаар явчихсан бас зарим юман дээрээ нэлээн гайгүй шүү. Тэгээд эмэгтэйчүүд рүү битгий янз бүр бол.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга Пүрэвдорж хариуцлагатай байхыг танаас шаардаж байна. Өнөөдөр зөвхөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал татвар тогтоодоггүй юм Пүрэвдорж дарга аа. Нийслэл тогтоодоггүй юм. Малын хөлийн татварыг та байж байхдаа батлалцчихсан. 330 сумын чинь эрх байхгүй болох гээд байгааг л би хэлсэн юм. Газрын төлбөрийг орон нутаг өөрөө тогтоодог юм Пүрэвдорж дарга аа.

Та бол ерөөсөө зүгээр парламентад бол алиалагч хийдэг хүн шүү дээ. Намын дарга болохын тулд битгий 2-ын хооронд ийм юм хийж бай за юу. Та намын даргынхаа сунгаанд орчхоод, битгий 2-ын хооронд ийм хогийн юм хийж бай. Номинчимэг та 2 ямар харилцаагаараа гайгүйг мэдэхгүй байна. Тэгэхдээ та хуулийг

буруу хэлж миний гаргаагүй саналыг ингэж тайлбарлаж байгаа бол битгий андуураад байгаарай гэж би танд хэлье. Пүрэвдорж гэдэг нэг нөхөр намын дарга болох гээд бүх зүйл дээр нэг ийм хоосон пи ар хийдэг. Зүгээр байгаарай гэж би танд хэлье.

Д.Амарбаясгалан: 5 дугаар санал 40,8 хувиар дэмжигдээгүй байна.

Ерөнхийдөө зүгээр гишүүддээ нэг зүйлийг анхааруулж хэлье. Ажлын хэсэг яах гэж гарч ажилладаг юм, мэргэжлийн Байнгын хороо яах гэж ажилладаг юм бэ гэдэг дээр бид жоохон төвлөрч, анхаарч хандахгүй бол энэ танхимд орж ирээд 2, 3 хүний зөрчлөөс болоод нэгнийгээ хорлох гэж байгаа хэлбэрээр мэргэжлийн Байнгын хорооны дэмжээгүй саналыг босгоод байна гэдэг бол цаашдаа энэ хууль батлагдаад, хэрэгжихгүй байх үндсийг тавьж байна гэдэгтэй гишүүд өөрсдөө ухамсартай хандаарай. Яах гэж мэргэжлийн Байнгын хороо байгуулагдаж, мэргэжлийн хүмүүс орж, мэргэжлийн хүмүүс зөвлөж ажилладаг юм гэдгийг ч бас бодох хэрэгтэй. Тэгэхгүй тэгээд орж ирээд Байнгын хороо дэмжээгүй саналыг нь гаргасан хүнийх нь лоббигоор юм уу, саналаар нь заавал унагаах гээд энэ тэр танхим дотор ажилладгаа ч болих хэрэгтэй. Одоо жоохон ёс зүйтэй байцгаа. Та бүхний ард Монголын ард түмний эрх ашиг байгаа гэдгийг бодож бай. Өнөөдөр энэ Хууль тогтоомжийн хуулийн үндсэн зорилго Монгол Улсад хүний эрхийг зөрчөөд байгаа, хүнд суртал үүсгээд байгаа авлигын үндэс нь болоод байгаа энэ олон журмуудыг цэгцлэх зорилгоор л явж байгаа. Гэтэл энийг нь дунд нь сааруулах нэг байгууллагын, нэг яамны 20, 30 жил тогтчихсон хэв маягийг нь өөрчлүүлэхгүй, эвдүүлэхгүй гэдэг ийм арга барилаар ажиллаж болохгүй. Энэ Их Хурал өөрчлөлт, шинэчлэлт хийхийн төлөө сууж байгаа. Түүнээс биш байгаа зүйлийг байгаагаар нь хадгалахын төлөө, косметик засвар өөрчлөлт хийхийн төлөө энд суугаагүй. Бид стратегия хүний эрхийг дээдэлсэн хууль эрх зүйн орчныг бий болгоё гэж гаргасан. Тэгвэл хүний эрхийг хөндөөд байгаа, энэ хүнд суртал үүсгээд байгаа, энэ авлига авах үндсийг нь бий болгож өгөөд байгаа энэ олон журмуудыг л эрхийг нь тасалъя л гэж байгаа шүү дээ.

Малын хөлийн татварын журам л гэж байна. Тэр чинь сумандаа очоод л бас л авлигын асуудал болчихсон шүү дээ. Мал тооллогоос өгсүүлээд л асуудал ярина. Сум, орон нутгийн хэмжээнд энэ дээр ямар хэлбэрээр шийдвэр гаргах вэ гэдэг нь хүртэл тус тусдаа үздэг асуудал болчихсон. Тэгэхээр ингэж ялгаатай ханддаг, ялгавартай байдаг энэ байдлуудыг нэг мөр хуулиар нарийвчлан зохицуулж өгдөг больё л гэдэг зүйлийг бид өнөөдөр энд хөнд хөндөөд явж байгаа гэдгийг та бүхэндээ хариуцлагатай хэлье. Тэгээд санал хураалтдаа хариуцлагатай оролц.

Энэ Засгийн газрын гишүүд хаачсан. Сандагийн Бямбацогт хаана байна. Болдын Жавхлан, Жадамбын Энхбаяр, Сайнбуянгийн Амарсайхан, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Борхүүгийн Дэлгэрсайхан, Тилеуханы Аубакир, Энхтайвангийн Бат-Амгалан, Ням-Осорын Учрал. Энэ сайд нар хаачив. Тэгээд санал хураалтад орж ирэхгүй. Цаашдаа Улсын Их Хурал дээр яах юм ингээд санал хураалт дээр олонх, цөөнхөөрөө ялгарч сууж байгаад орж ирсэн санал нь унаад сууж байдаг болох юм уу. Одоо энэ дээрээ жоохон хариуцлагатай хандана шүү.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Санал гаргасан гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Гишүүд ээ, ийм байгаа юм. Уг нь яах вэ үндэслэл бүхий ингээд тайлбараа яривал хэн ч ярина. Тэгэхээр худлаа ингэж хэлээд байхаар бас хэцүү юм. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.6 дахь заалтыг нэмэх гэж орж ирсэн юм. Энэ дээр юу орж ирж байгаа вэ гэхээр асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад байгууллагын үйл ажиллагаа явуулах журам бүрэн эрх гэж байгаа юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хууль тогтоомжийн хуулийн яг дээд талынх нь заалт 28.3.5 дээр иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх үүрэг гээд байж байгаа. Хуулийн этгээдэд төрийн байгууллага өөрөө ордог байхгүй юу. Хуулийн этгээдийн статустай. Тэгээд энэ байгаа юмыг ингээд давхцуулах хэрэггүй гэдэг байдлаар давхцал үүсэх юм байна. Хасчихъя гэдэг саналыг дэвшүүлж байгаа юм. Ерөөсөө л энэ.

Түрүүн Жаргалан, Сайнзориг 2 зөрж, 1 юмаар яагаад зөрөөд байна гэж байгаа юм. Жаргалан гишүүн бол энэ заалтыг хасчихъя гэж байгаа бол би сайжруулаад, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг нь хийдэг болгооч гэдгийг л хэлсэн. Аргыг нь зааж өгөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр авахгүй. Асуудлууд сүүлдээ гацчих вий гэдэг дээр л болгоомжлоод л байгаа юм. Тэгээд энэ хууль тогтоомжийн хуулийг бол үндсэндээ над мэт шиг ч юм уу анх сонгогдсон гишүүд гэхээсээ уг нь хэд хэд сонгогдсон хүмүүс ярих байсан юм уг нь. Тэгээд нээрээ сүүлдээ ингээд төрийн үйл ажиллагаа, хууль санаачлах эрхээ ингээд гацаагаад хаячих вий дээ. Тэгээд би Хурлын даргын хэлж байгаа зүйлийг ерөөсөө эсэргүүцээгүй. Үнэхээр тэр малын хөлийн татвар, Хог хаягдлын хураамжийг 330 сум, 9 дүүрэг батлаад асуудал үүсээд байгаа бол бид нар тэр хууль дээр нь өөрчлөлт оруулаад, аймаг нь баталдаг юм уу, эсвэл энэ дээрээсээ асуудал эрхэлсэн Засгийн газар нэгдсэн нэгдсэн байдлаар баталдаг ч юм уу ингээд шийдэж болно шүү дээ. Тэр хууль дээрээ ярихгүй мөртөө ямар ч хамаагүй юман дээр ингээд асуудлуудыг бас хүндрүүлчих вий дээ л гэдэг болгоомжлолын үүднээс би бас энэ саналуудыг хэлж байгаа шүү гэдэг зүйлийг л хэлье.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Ажлын хэсгийн дарга.

О.Номинчимэг: Ажлын хэсэг яагаад энэ заалтыг хасах шаардлагагүй гэж үзсэн болохоор ерөөсөө энэ зүйл заалт бол хуулийн төслийн бүтэц чинь ямар дэс дараалалтайгаар байх юм бэ гэж байгаа. Тэгээд бид нар бүгдээрээ мэднэ шүү дээ. Хуулийн төсөл эхлээд л нэг нийтлэг зорилго байж байснаа төрийн байгууллагын бүрэн эрх, төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг гэдэг юмнаас эхэлдэг. Тэгэхээр бид нар нөгөө хүн төвтэй, хүн рүүгээ чиглэсэн, хүн дээрээ ямар эрх, үүрэг тэ гарч ирэх гээд байгаа юм гэдэг юмаа илүү тодотгохын тулд эхлээд иргэн, хуулийн этгээдтэй холбоотой юмаа оруулъя. Түүний дараа төрийн байгууллага тэр нөгөө эрх, үүрэг яах гэж байгаа юм, хэн нь юугаа хариуцах гэж байгаа юм гэдэг юмаа оруулъя л гэдэг энийг тодотгож дэс дарааллыг нь төрийн байгууллага нь хүн, хуулийн этгээдийнхээ дараа байх юм шүү л гэдэг ийм тодотгосон заалт байгаа юм. Тэгэхээр энэ давхардсан агуулга биш. Дэс дарааны хувьд иргэдийнхээ аж ахуйн нэгж, хуулийн этгээд, төрийн бус байгууллага юу байдаг юм эд нар дээрээ байгаа юмнуудаа эхлээд хуульчилдаг, хууль дээрээ оруулдаг болъё гэсэн ийм дэс дарааны юм байгаа шүү гэдгийг тайлбарлаж, тодотгож хэлье. Тэгэхээр энийг та бүхэн кнопоороо дэмжиж, Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: 6 дахь санал. Санал хураалт. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Энэ хуулиар бүр тоглож дууслаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүнд үг өгье.

М.Бадамсүрэн: Энэ дэгийн хуульд өөрчлөлт оруулах саналтай байна Хурлын дарга аа. Яагаад гэхээр энэ олон давтагдаж байна. Байнгын хороо дээр дэмжээгүй саналыг дэмжинэ гэдэг томъёоллыг одоо болих хэрэгтэй. Дэмжээгүй болон дэмжсэн саналыг хоёуланг нь чуулганаар дэмжсэн эсэхээр хураахгүй бол чуулганд ирцээ бүртгүүлчхээд, гараад явчихсан гишүүд эс үйлдэхгүйгээрээ энэ саналыг чинь дэмжигдээд боссон гэдэг томъёололтой олон зохицуулалтаар ингэж яваад байгаа шүү дээ. Энэ чинь ерөөсөө гол хямрал болоод байгаа байхгүй юу. Тийм учраас энийг өөрчлөх саналыг гаргаж байна. Тэгээд энэ бол энэ гацаанаас гарах нэг чухал зүйл болно гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Танхимд хангалттай гишүүд байгаа. Санал хураалтад би энэ 6 дахь саналыг хүчингүй болгох горимын саналыг өөрөө гаргаж байна. Горимын санал. 6 дахь санал хүчингүй боллоо.

6 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт, Байнгын хороонд шилжүүллээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 40.1.11, 40.1.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё. Санал гаргасан гишүүн Сайнзориг үг өгье.

П.Сайнзориг: Дарга аа, ийм юм байгаа юм. Яах вэ, найруулгын хувьд нөгөө Хууль тогтоомжийн хуулийн хүчин төгөлдөр хуулийн 40.1.1 дээр хийгддэг ажлууд байхгүй юу. Ингээд задалж бичээд байгаа. Тэгэхдээ яах вэ зүгээр ажлын хэсгээс илүү нарийвчилж оруулж ирэх гэж байгаа гэж л юм хэлж байгаа. Яах вэ, зүгээр агуулгын хувьд бол байгаа зүйл шүү гэдэг зүйлийг хэлье. Тэгээд саналаа татаж авч байна. Асуудлыг зүгээр протоколд бас үлдээж байгаа юм. Давхцалууд их гараад байна шүү л гэдэг зүйлийг хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: 7 дахь санал татагдлаа. Ер нь Сайнзориг гишүүн ийм шүү. Мэдээж хэрэг хуулиуд ерөнхий байдлаар зохицуулалтаа хийж ирсэн цаг үе байна. Одоо цаашдаа Улсын Их Хурал ямар зорилго тавиад байгаа вэ гэхээр журмын тоог цөөлөх буюу хууль өөрөө иж бүрэн зохицуулалтыг нарийвчлан хийж чаддаг болъё л гэдэг зорилгыг Улсын Их Хурал тавьж байгаа юм. Тэгэхээр мэдээж хэрэг өмнөх арга барил энэ өөрчлөгдөж байгаа арга барил 2-ын хооронд зөрүүтэй байдал ойлголт үүсээд байгааг ойлгож байна.

Гэхдээ бид илүү дэвшиж урагшилж байх ёстой гэдэг агуулгаараа нарийвчилсан зохицуулалтыг оруулж ирж байгаа л гэдэг дээр та бүхэн минь анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй. Тэгэхгүй бол өнөөдөр энэ өргөн баригдаад хэлэлцэгдэж байгаа хууль чинь сэглэгдэж дуусах гэж байна шүү дээ. Авах ч биш, хаях ч биш юм руу оруулах гэж байна. Тэгэхээр энийгээ ойлгож асуудлыг ярих нь зүйтэй гэж бодож байна.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Сайнзориг гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Ингэчихсэн юм дарга аа, бид хэд уг нь баталсан хуулийг 5 жил тутам хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг нь хийж байж Улсын Их Хурал

танилцуулаад яах вэ гэдэг зүйлээ шийдэх ёстой. Сайжруулах уу, үгүй юу. 5 жил тутам шүү. Тэгсэн чинь бид нар тэр заалт нь хүчин төгөлдөр хуулийн 51.1 дээрээ байж байгаа байхгүй юу. Гэтэл 51.5-аар 5 түүнээс дээш жил гээд бид хэд ерөөсөө 5 жилээ шууд үгүйсгэчихэж байгаа юм. Энэ заалт юу байж болох вэ гэхээр дагаж мөрдөх журмын зохицуулалт дээр 5 жил дотроо орж ирээгүй хуулиудыг энэ жилдээ багтаагаад ч гэдэг юм уу оруулж ир гээд 1 л удаагийн үйлчлэлээр чиглэл өгч болох байсан байхгүй юу. Би хэлээд дарга аа, энэ ерөөсөө ингээд ойлголцохгүй байна. Энэ ингээд бид хэд 5 жил тутам хийгээд, энийг Амарбаясгалан дарга өөрөө ч гэсэн Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа дэмждэг. Хууль тогтоомжийн агентлаг байгуулаад Ерөнхий сайдын үндсэн чиг үүрэг болох 5 жил тутам бүх хуулиуддаа дүгнэлт өгөөд, Улсын Их Хуралдаа танилцуулаад сайжруулах уу, хүчингүй болгох уу, нэмэлт, өөрчлөлт оруулах уу гэж ярьдаг. Одоо болохоор 5 түүнээс дээш, 20 жилийн дараа ч хийж болно. Ийм байдал руу ингээд оруулаад ирээд байгаа учраас би санаа зовоод хэлээд байгаа байхгүй юу.

Тэгээд ийм зүйлийг хэлэхээр чи юугаа мэддэг юм гээд ингээд яг үнэндээ хэлэхэд дарга аа, би зүгээр энэ дээр ямар ч хувийн юм яагаагүй, хуучны арга барил яриагүй. Энэ сайжруулах саналуудыг бүгдийг нь дэмжиж байгаа боловч асуудлууд ингээд улам зарчмыг алдагдуулаад байгаад л асуудал байгаа шүү дарга аа. Тэгээд би энийг бол мэдэхгүй байна. Тэгээд уг нь энэ санал дээр хүрэхгүй байж байгаад босгоод, энэ 5 жил тутам заавал хийж байх ёстой. Тэгээд энийг хийлгэхийн тулд уг нь хууль тогтоомжийн агентлаг байгуулаач гээд сая шинэ Ерөнхий сайд ч бас саналаа хэллээ. Өөрөө Хурлын дарга бас Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа энийг ярьдаг байсан. Одоо болохоор ингээд 5 түүнээс дээш гэдэг чинь 20 жил, 30 жил ч хийхгүй гэсэн үг шүү дээ. Хэдүүлээ энийгээ л ойлгоё.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүний хэлээд байгаа шиг юм болохгүй юм. Энэ бас нарийвчилж тайлбарлахгүй бол ганц юман дээр буруу тайлбарлаад байх юм. Энэ 5 жил тутамдаа дүн шинжилгээ хийж байна гэдэг заалт нь хэвээрээ байгаа. 51.3 дээр хууль тогтоомжид мөрдөж эхэлснээс нь хойш 5 жил тутамдаа хийнэ гэдэг нь бол байгаа юм. Яагаад энд нэмэлтээр 51.5 дээр 5 болон түүнээс дээш жил хэрэгжиж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа энийгээ заавал хийгээч л гэдэг шаардлагыг нь хийгээд байгаа. Тэгэхгүй бол одоо ингээд хууль тогтоомж дээр ажиллаж байгаа яг үнэндээ 5 жил тутамдаа хийгдэхгүй байгаа байхгүй юу. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ чинь. Ерөөсөө хийгдэхгүй байгаа. Тэгээд дараа нь бид нар Улсын Их Хурлын гишүүд тамхины хууль дээр би нэмэлт, өөрчлөлт оруулъя гэсэн чинь 5 жил тутамдаа ямар ч хэрэгжилтийн үр дүнгийн шинжилгээ хийгээгүй. Тэгэхээр би энийг хийхгүйгээр хууль санаачлаад явахгүй шүү. Энийг бол заавал хэрэгжилтийн үр дүнгийнх нь хийгээд, хэлэлцүүлээд, тэгээд хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулна шүү гэдгийг нь тодотгож өгч байгаа заалт юм. Тэрнээс 5 жил тутамдаа хийх нь угаасаа хуулиараа байгаа болохоор 20, 30 жилээр ингээд болчихож байгаа юм шиг ийм юм биш байгаа шүү гэдгийг гишүүддээ хэлье.

Д.Амарбаясгалан: Бас нэг нэмэлт тайлбар хийгээд явчихъя. Ер нь зүгээр яах вэ энэ бусад улс орны жишгээр хуулийг 3-5 жил тутамд цаг үетэй нь, нөхцөл байдалтай нь нийцүүлэх ажлыг авч хэрэгжүүлж байдаг юм байна лээ. Хууль өөрөө цаг хугацааны хувьд хоцрогдоод ирэхээрээ л хүний эрхийн зөрчил үүсэж байдаг. Нийгэмд шинэ тутамд бий болж байгаа харилцааг зохицуулж чадахгүй болоод ирэхээрээ хууль өөрөө хүний эрхийг зөрчөөд байгаа юм. Тэгэхээр хууль цаг

хугацаанаасаа хоцрогддоггүй байх энэ үүргийг Улсын Их Хурал өөрөө хэрэгжүүлж байх, хэрэгжилтэд нь хяналт тавьж байх үүрэг хүлээж байдаг.

Саяын Номинчимэг гишүүний хэлж байгаагаар заавал хийдэг энэ зохицуулалт нь орж ирж байж нөхцөл хангагдана л гэж үзэж энэ ажлын хэсэг хууль санаачлагчид бол энэ төслийг өргөн барьсан гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийн саналыг уг нь дэмжмээр байгаа юм. Эсвэл та бүхэн маань Байнгын хороо, ажлын хэсэг дээрээ дахиж сайн ярилц. Гүйцээн боловсруулах чиглэл өгчих үү. Тэгье. 8 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. Сайнзориг гишүүнд үг өгье.

П.Сайнзориг: Энэ заалт маань гишүүдтэй шууд хамаатай болно. Тэгээд та хэд маань бас анзаарвал ерөнхийдөө тодорхой бүтцийн асуудал дээр энэ хууль тогтоомжийг яаж оруулж ирэх вэ. Энэ зүйлүүд логикийн хувьд явж байгаа. Тэгэхээр энэ хууль хоорондын зөрчлийг давхардлыг үүсгэх гээд байгаа учраас энэ заалтыг шаардлагагүй юм л гэдэг зүйлээс бас та бүгддээ хэлж байгаа юм. Энэ саналыг бас зарчмын хувьд дэмжээд өгөөч ээ гэж хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: 9 дэх санал дээр бас ажлын хэсгийн ахлагч Одсүрэнгийн Номинчимэг үг үг хэлье гэж байна. Хэлэх гэж байгаа үгийг бараг гадарлаж байна. Тийм учраас 9 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

10.Төсөлд дор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

Ер нь байна шүү дээ нөхөд өө, Сайнзориг гишүүн ээ, мэдээж гаргаж байгаа саналыг чинь хүндэтгээд байгаа юм. Гэхдээ энэ парламент гэдэг зүйл чинь өөрөө асуудлыг хөндөнө, олонхоороо асуудлаа шийдээд явдаг байх ёстой. Түрүүний Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүний хэлж байгаа саналтай санал нэг байгаа юм. Мэргэжлийн Байнгын хороо ажлын хэсэг дээр дэмжигдээгүй саналыг Улсын Их Хурал дээр оруулж ирээд босгочихдог энэ байдал бол яав ч зүйд нийцэхгүй л зүйл болж байна. Тэгэхээр энэ Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал дээр энд бид бас анхаарал хандуулах нь зөв гэдэгтэй санал 100 хувь нэг байна.

9 дэх саналыг гүйцээн боловсруулчих чиглэл өглөө.

10.Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 46 гишүүн буюу 46 хувиар санал дэмжигдсэнгүй.

Энэ тэгээд яах юм, батлагдсан өдрөөсөө хэрэгжих болчхож байна уу.

Хоёр.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эрх, эрх чөлөөг” гэсний өмнө “хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 2 дахь дэд заалтын “холбогдох хуулиудын төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан” гэснийг “судалгаа хийж, холбогдох хуулиудын төслийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд” гэж өөрчилж, энэ заалтад дор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдэж байна. Улсын Их Хурлын гишүүдийн дийлэнх олонх нь ажлын хэсэг, Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжээд байгаа.

2.Тогтоолын төсөлд дор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгасугай:

1/Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;

2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж, дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг, сонирхлын зөрчил, авлига гаргах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг нийтийн эрх зүйн этгээдэд зөвлөсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

11.08 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Гочоогийн Ганболд танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Лхагвасүрэнгийн Золзаяа нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

Тэрээр 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 45 дугаар дунд сургууль, 1997-2001 онд Тагнуулын ерөнхий газрын дээд сургуульд суралцаж төгсөж, эрх зүйч мэргэжил эзэмшсэн. Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Лхагвасүрэнгийн Золзаяа нь ажлын гараагаа Тагнуулын ерөнхий газарт ажилтнаар эхлүүлж, 2001-2005 онд орон нутгийн нэгжид ажилтан, 2005-2011 онд төвийн нэгжид ажилтан, ахлах ажилтан, тасгийн дарга, хэлтсийн орлогч дарга, 2011-2013 онд Авлигатай тэмцэх газарт ахлах ажилтан, 2013-2015 онд Тагнуулын ерөнхий газарт Газрын орлогч дарга, 2015-2019 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа дипломат төлөөлөгчийн газруудад Консул, 2019-2023 онд Тайпэй дахь Улаанбаатарын Худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газарт тэргүүн, 2023-2025 онд Тагнуулын ерөнхий газарт Газрын орлогч дарга, 2025 оны 3 дугаар сараас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газарт ахлах референтээр томилогдон ажиллаж байна.

Лхагвасүрэнгийн Золзаяа нь 2001 оноос хойш Үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны чиглэлээр ажилласан төрийн албаны туршлагатай хэмээн үзэж Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Иймд Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигчийн талаар гаргасан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатарт танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төрийн албаны зөвлөлийн 3 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүнийг, төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүнийг нэр дэвшүүлэх гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Лхагвасүрэнгийн Золзаяаг нэр дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн төлөөллийг сонгосн шалгаруулах журмын 4.1-д заасны дагуу сонгон шалгаруулах комисс байгуулах тухай 2025 оны 4 дүгээр тогтоолыг баталж, төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комисс байгуулагдан ажиллаж, нэр дэвшигчдийг сонгон шалгаруулсан.

Тус журмын 7.1-д комисс үнэлгээг эцэслэн нягталж, онооны дарааллаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчдын нэр, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд сонгон шалгаруулалт дууссанаас хойш 3 өдрийн дотор багтаан хүргүүлнэ гэж заасны дагуу төрийн албан хаагчийн төлөөллөөс Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл нарыг нийт үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан бөгөөд баримт бичгээ бүрдүүлэн Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай 06 дугаар тогтоолыг баталж, 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатарыг томилсон.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонголд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, О.Алтангэрэл, Ж.Баярмаа, Б.Батбаатар, С.Зулпхар, О.Номинчимэг, Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Уянгахишиг, Ө.Шижир, Л.Энх-Амгалан нарын гишүүд оролцсон болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар нэр дэвшигчийн сонголын тайлан болон Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Амарбаясгалан, Б.Баярбаатар, Ц.Сандаг-Очир нар санал хэлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нэр дэвшүүлсэн Лхагвасүрэнгийн Золзаяа төрийн албан хаагчийн төлөөллөөс нэр дэвшсэн Бадамдоржийн Төгсцэнгэл, Цэнддаваагийн Амартөгс нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилуулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Бадамцоогийн Идэрчулуун, Должингийн Баатарсайхан, Цэнддаваагийн Амартөгс нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Лхагвасүрэнгийн Золзаяа, Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл нар хүрэлцэн ирсэн байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна. Энэ эрэмбэлэгдээгүй байна уу. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би Байнгын хороо дээр бас тодорхой байр сууриа илэрхийлсэн. Төрийн албаны зөвлөл бол хэтэрхий асуудалд нэг талдаа ханддаг, үзэмжээр ханддаг ийм байгууллага болчихоод байгаа. Жишээ нь Баянхонгор аймагт аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч нь тусгай ажил үүрэг гүйцэтгэх ёсгүй байтал Тамгын газрын даргаа хийчихсэн явж байгаа шүү дээ. Хэд хэдэн газрын дарга хийж байгаа, төрийн алба хашиж байгаа ийм байдлаар дандаа 2 нүүртэй асуудалд ханддаг ийм байгууллага болчихоод байгаа. Ер нь бол төрийн албаны томилгоо, энэ бүх зүйл залуучууд энэ төрийн албанд ажиллах тэр бүх зүйлүүдийг бүгдийг нь хаадаг. Хэсэг хүмүүсийг оруулж түгжиж авчхаад, тэнд салхи сэвүүлдэггүй тийм

бугширсан бүтцийг бий болгочихсон. Тэндээ асуудал гаргаад л ингээд л явж байгаа. Тэгээд энэ төрийн албаны албан хаагчийг томилох бүх эрхийг бүгдийг нь энд тэндээс булааж авсан. Тэндээ танай томилгоо чинь болохгүй байна, энэ чинь болохгүй байна гээд өөрсдийнхөө тэр гаргаж ирсэн хүмүүсийг заавал оруулахын төлөө явдаг ийм л бүтэц болчихсон.

Тийм учраас энэ байгууллага бол энэ төрийн албан хаагчдыг томилох тэр бүрэн эрхийг бүгдийг нь авсан хэр нь дахиад дээрээс нь төсөв рүү чинь өнгийж эхэлж байна. Жишээ нь, сая саяхан бүх яамнууд Төрийн албаны зөвлөлийн зохион байгуулж байгаа төрийн албан хаагчдын семинар уулзалтыг яамнуудаас 20 сая төгрөг авна гэж ярьсан байгаа юм. Гэтэл бүр аймаг болгоноос 20 сая төгрөг авах. Өөрөөр хэлбэл хэдэн дарга нар төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг хийж, өөрсдөдөө алга ташуулахын тулд төсвийн ерөнхийлөн захирагч та нарын эрх рүү халдаж, бүр дураараа дургидаг юм нь хэрээс хэтэрч байна. Зарим яамд руу танайх 20 сая төгрөгөөр iPad авч өг гэж бичиг явуулсан байх жишээтэй. Ийм байдлаар ийм замбараагүй зүйл тэр нь бичгээр явуулсан юм уу, ил тод хэн нэг нь хэлсэн юм уу, хэлсэн юм шиг байгаа юм. Ийм байдлаар ер нь эн Төрийн албаны зөвлөл бол сүүлдээ томилгооны эрхэд халдаад, бүр сүүлдээ төсөв рүү нь өнгийж эхэлдэг болоод байна. Тэгээд энэ бүх мэдээллүүд бүгдээрээ над дээр ирж байгаа. Ер нь бол Их Хурал дээр энэ үг хэлчих байх гэж над руу маш их олон хүмүүс ханддаг. Олон зүйлүүд байна. Тийм учраас энэ төрийн албаны зөвлөл дээр хэтэрхий нэг талыг барьсан томилгоонууд маш их явагдсан. Тэнд нь .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж байгаа хүмүүст амжилт хүсье. 1 хэлэх үг байна. 2 асуулт байна.

1 дүгээрт Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнд дандаа эрэгтэй хүмүүс сонгогдож байсан. Тэгээд хамгийн анх Амартөгс гишүүн бол анхны эмэгтэй хүн болж ингэж сонгогдсон. Тэгэхээр би сая гүйцэтгэх засаглалын томилгоо дээр ч гэсэн жендерийн асуудал яриад, яг ингээд шийдвэр гаргах ийм томоохон бүтцийн ийм асуудал дээр яг энэ жендерийн эрх тэгш байдал дандаа алдагдаад байгаа. Тэгээд би бас гишүүддээ уриалах гээд байгаа. Ямар нэгэн байдлаар хүйсийн байдлаар нь энэ танхимд хэн нэгнийгээ ялгаварлан гадуурхсан ийм үг хэллэг битгий хэлээч ээ. Хэлсэн хүмүүс нь, бас нэр бүхий хүмүүс нь энэ асуудлаараа уучлал гуйгаасай гэж бодож байна.

Тийм учраас бас Амартөгс гишүүнийг бол дэмжиж байна. Таны араас олон төрийн албан хаагч эмэгтэйчүүд танаас урам зориг авч, дараа дараагийнхаа төрийн албаныхаа карьерыг төлөвлөж болох юм байна. Төрийн албаны зөвлөлийн гишүүн эмэгтэй хүн ажиллаж болох юм байна гэдэг ийм дүр төрхийг та бас бүрдүүлж байгаа. Тэгээд танд бас амжилт тухайлан онцгойлон бас хүсье гэж хэлье.

3 гишүүн гурвуулаа яг Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн хүрээнд төрийн албаны ямар шинэчлэлийг хийх ёстой гэж харж байгаа вэ. Гэхдээ ерөнхий битгий хариулаарай. Ялангуяа төрийн захиргаа дээр, төрийн захиргааны албан тушаалтнуудын энэ асуудлууд дээр ямар шинэчлэлт хийх ёстой гэж та бүхэн харж байгаа вэ. Одоо энэ цомхон төр гэдэг дээр та бүхэн бас энийг холбож өөрсдийнхөө байр суурийг илэрхийлээч ээ гэсэн хүсэлт байна.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. 4 дүгээр индэр. Нэр дэвшигч Амартөгс

Ц.Амартөгс: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн албаны зөвлөл хариуцан хэрэгжүүлж байгаа өнөөдрийн хуулиар 11 чиг үүрэгтэй. Тэгэхээр цаашдаа хийж хэрэгжүүлэх ажлын тухайд бол эхний ээлжид хууль хэрэглээний практик тогтоох, зөв жишиг тогтоох энэ асуудал дээр нэлээн сайн анхаарах асуудлууд бий. Өнөөдрийг хүртэл хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд энэ зөрчил бэрхшээлтэй байдлыг арилгахын тулд хамгийн гол нь хувь хүнээс хамаарсан бус үйл ажиллагааг процессыг илүү нэвтрүүлэх ийм шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ мэдээллийн технологи болон цахим системийг хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, одоогоор бий болгосон байгаа хүний нөөцийн удирдлага, мэдээллийн цахим тогтолцоо, нэгдсэн платформыг бүхий л шат, бүхий л процесст нь ашигладаг, хэрэглэдэг, нээлттэй, мэдээллээ түгээдэг ийм систем болгож хөгжүүлэх нэн шаардлагатай байгаа. Энийгээ цааш нь үргэлжлүүлэх ёстой бай гэж бодож байна.

Төрийн албаны үйл ажиллагаа үр ашигтай байх ёстой, зохистой байх ёстой, хариуцлагатай байх ёстой гэдэг ийм зүйл тэргүүлэх чиглэлд тавигдана. Үр ашгийг бид юугаар тооцох вэ гэхээр иргэнд хүргэж байгаа үйлчилгээ яг зохистой хэмжээндээ стандартын түвшинд хүргэдэг байх нөхцөлийг бүрдүүлэх. Энэ маань 1 дүгээрт төрийн албан хаагч ур чадвартай байх, 2 дугаарт ажиллах нөхцөл бололцоо бүрдсэн байх, 3 дугаарт нь тэрхүү үйлчилгээ нь хүртээмжтэй эерэг байх гэсэн ийм агуулгууд байгаа. Тэгэхээр төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл 2 дугаарт ур чадвар, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ийм агуулгууд байгаа. Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх тогтолцоог илүү боловсронгуй болгох дараагийнх нь асуудал. Яагаад гэхээр орчин цагт технологийн болоод бусад өөрчлөлтүүд маш шуурхай хурдан явагдаж байгаа учраас түүнд нийцсэн байдлаар төрийн албан хаагчид сурч хөгжиж, шуурхай ажиллах, бүтээмжтэй ажиллах ёстой гэж харж байна.

Дараагийн 1 асуудал нь бол зохистой хэмжээнд байлгах, үр дүнтэй ажиллах механизм бол яалт ч үгүй ямар чиг үүргийг төр өөрөө хэрэгжүүлэх вэ, ямар чиг үүргийг мэргэжлийн болон төрийн бус байгууллагууд хэрэгжүүлэх вэ гэдэг дээр ялгаа зааг болон хариуцлага хяналтын механизмаа илүү сайжруулаад цаашаа үр дүнтэй ажиллах ийм зохистой тогтолцоо бий болох ёстой гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Нэр дэвшиж байгаа хүмүүстээ амжилт хүсье. Томилогдох бол нэг хэрэг. Тэгээд томилогдохдоо бас жендерийн эрх тэгш байдлыг бариад явдаг болсон. Энэ сайн боловч очоод энэ боломжийг харин зөв ашиглаарай л гэдэг зүйлийг би хэлмээр байгаа юм. Тэгээд гол асуудал маань ерөөсөө энэ Төрийн албаны хуулийн бас шинэчлэлийг явуулъя гэхээр нэр томьёоноос эхлээд жоохон хүнд байгаа юм. Төрийн албаны ангиллыг зөв болгоё гэхээр энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг зөв хийхгүй болохоор бас болохоо байчихаад байгаа юм. Тэгэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг маш чанартай зөв гаргаад, төрийн байгууллагад нь ер нь ямар, ямар байгууллагууд нь ангиллын хувьд орохоо зөв тодорхойлчихвол тэнд ажиллаж байгаа хүмүүс бол төрийн албан хаагч гэдэг зүйлийг зөв тодорхойлно. Тэндээ зөв ангилал тогтоох бололцоо бүрдэх гээд байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө бас төрийн алба гэж нэрлэхээсээ илүүтэйгээр нийтийн алба гэж нэрлээсэй гэж хүсдэг. Тэгээд ер нь зүгээр энэ төрийн чиг үүргийг бас мэргэжлийн холбоонд шилжүүлнэ. Хуультай зарим нийтийн эрх зүйд шилжүүлнэ гэдэг бол энэ чинь өөрөө бүхэлдээ олон нийтийн өмнө буюу зүтгэж байгаа хүмүүс байхгүй юу. Үүн дотроосоо яам агентлаг дээр ажиллаж байгаа хүмүүс бол төрийн жинхэнэ албан хаагчид байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг ярихын тулд Нийтийн албаны тухай хууль, Төрийн жинхэнэ албаны тухай хууль, магадгүй та нөхдийн эрх зүйн байдалтай холбоотой Төрийн албаны зөвлөлийн тухай хууль гэсэн ийм 3 хууль болгоод ер нь цаашдаа явъя гэж би зүгээр хувьдаа боддог. Тэгээд энэ дээрээсээ гол асуудал нь хуулийг 3 задлахдаа биш. Гол нь төрийн албан хаагчдынхаа ангилал, үүнийгээ дагасан сонгон шалгаруулалт нь зөв явдаг байх, шаардлагууд нь зөв тавигддаг байх. Эргээд энэ төрийн албанд ажилласан жилээр гэдэг юм уу, түрүүн бас хэд хэдэн гишүүн хэлж байна лээ. Энэ зүйл биш. Бүтээмжийг илэрхийлэх. Өөрөөр хэлэх юм бол шинэ залуучууд бас орж ирж салхи эргүүлдэг байгаасай гэж хүсэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол магадгүй НҮБ, түүний төрөлжсөн байгууллага, ОУБ-д тэр байгууллагуудын шаардлагыг даваад орчихсон тэр Монгол залуучуудыг төрийн албандаа урьж ажиллуулахад ажилласан жилээр нь боодог ч юм уу, чи шалгалт өгөөгүй байна ч гэдэг юм уу ийм зүйлээр боомилдог. Тэгэхээр уг нь бид нар манай Монголынхон гэлтгүй бас олон улсын НҮБ-ын ийм байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөөд байгаа тэр экспертүүдийг уг нь төрийн албандаа урьж оролцуулдаг, бүтээмж, шинэ соёл, шинэ хандлага, шинэ мэдлэг, инновацыг авчрах тэр бололцоог нь бас бүрдүүлээч гэж хүсэж байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүд рүү бас жоохон анхаарч ажиллахад та нөхдийн санаачилга, идэвхтэй байгаасай гэж хүсэж байна.

Тэгээд ер нь энэ төрийн албаны хууль тогтоомжийг мэдээж судалж байгаа байх. Ерөнхий маш товчхон та хэд маань өөр өөрсдийнхөө байр суурийг дүгнэж хэлээч. Яг юун дээрээ бас асуудлуудыг илүү их фокусалж, энэ хууль тогтоомжийг сайжруулах ёстой гэж бодож байна гэдэг зүйлээ товчхон үгээр хэлээч гэж би хүсэж байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ төрийн албанд бол маш цөөхөн хүний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 3 нэр дэвшигчээс гурвуулаагаас асуулт асуулаа. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр танилцуулагдсан дарааллын дагуу Лхагвасүрэнгийн Золзаяа 4 дүгээр индэр. 1 минут.

Л.Золзаяа: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Төрийн албаны өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль бол 2017 онд батлагдаад 2019 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа. Энэ хууль дээр бол сонгон шалгаруулалт, хяналт шалгалтын ажил, сургалт, нийгмийн баталгааны асуудлыг бол нэлээн сайн тусгаж өгсөн гэж бодож байна. Энэ хуулийг хэрэгжүүлэх, төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бол 47 захиргааны акт өнөөдөр үйлчилж байгаа. Хуулийн хэрэгжилт, шинэ Төрийн албаны хуулийн хүрээнд бол сонгон шалгаруулалтын асуудал бол нэлээн сайжирсан гэж үздэг юм байна. Сонгон шалгаруулалт бол 2017 оноос бол бүрэн цахимжсан. Хяналт шалгалтын ажлуудын үр дүн бас эерэг үр дүн үзүүлээд явж байгаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль батлагдсантай .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэнддаваагийн Амартөгс 1 минутад багтааж хариулна.

Ц.Амартөгс: Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд шинэчлэх чиглэлүүдийг бол ерөнхийдөө бас судалж байгаа. Юуны өмнө төрийн албаны үйл ажиллагааны хүрээг шинэчлэн тодорхойлох, яг ямар эрх зүйн чадамжтай үүрэг хүлээж ажиллах вэ гэдгийг тодорхойлох Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагч үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой хөдөлмөр эрхлэлт болон эрх зүйн байдалтай нь холбоотой Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад зохицуулалтыг оруулсан ийм хууль тогтоомж болгож илүү сайжруулах саналтай санал нэг байна. Ингэхдээ бас төрийн албан хаагчийг үйл ажиллагааг нь дэмждэг, нөгөө талаар үйл ажиллагаа гүйцэтгэлийг нь үнэлдэг шударга, ил тод систем, дээрээс нь урамшууллын механизмыг илүү сайн болгох тал дээр анхаарах ёстой. Сонгон шалгаруулалтын тухайд бол чиг үүрэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Төгсцэнгэл. 4 дүгээр индэр.

Б.Төгсцэнгэл: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны төв байгууллага нь иргэдэд ойр, уян хатан, санаачилгатай, чадварлаг, манлайлал бүхий төрийн албыг бүрдүүлэхийг бол эрхэм зорилгоо болгосон. Тиймээс төрийн албаны шинэтгэл нь бол зөвхөн байгууллагын бүтэц, хууль эрх зүйн өөрчлөлтөөр хязгаарлагдахгүй. Энэ нь иргэн төвтэй, илүү ухаалаг тогтолцоонд чиглэсэн тасралтгүй хөгжлийн үе шат, үйл явц гэж харж байна. 2025 оноос орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг шинэтгэлийн суурь болгож, мэргэшсэн, тогтвортой, оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий инновацлаг төрийн албыг төлөвшүүлэх шаардлагатай гэж харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууж үг хэлье.

Н.Наранбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн албаны зөвлөлөөс бас асуулт асуух, санал хэлэх байсан. Төрийн албаны зөвлөлийн дарга ирээгүй байх юм. Нэр дэвшигчийн хувьд би дэмжиж байна. Бүрэн шаардлага хангаж байгаа гэж ойлгож байгаа.

Төрийн албаны зөвлөлд хандаж мөн нэр дэвшигч цаашдаа бас миний хэлэх 2, 3 зүйлийг бас бодлого, үйл ажиллагаандаа баримталж ажиллаарай гэсэн ийм зүйл хэлэх гээд байгаа юм. Төрийн албаны зөвлөл бол энэ төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг батлаад байгаа юм. Үүнээс болоод юу болж байна вэ гэхээр зэрэг баахан сумууд төрийн албанд хүн байхгүй. Төрийн үйлчилгээ иргэддээ хүрч чаддаггүй. Ингээд боловсон хүчний хомсдолтой болчихсон. Гэтэл нөгөө талдаа суманд, аймагт баахан ажилгүй хүмүүс яваад байдаг. Уг нь орчихмоор байдаг. Гэтэл гол тээг нь юу байгаа вэ гэхээр зэрэг Төрийн албаны зөвлөлөөс ажлын байрны тодорхойлолтыг нь ингээд батлаад, хатуу тогтоогоод өгчихсөн. Тэгээд тэрэнд нь тохирох хүн олдохгүй. Ингээд баахан орон тоо сул, төрийн ажил, үйлчилгээ гацсан ийм байдалтай байгааг уян хатан болгож, тэр тухайн сумын Засаг дарга юм уу, аймгийн Засаг дарга нь баталдаг ийм байхгүй бол цаашаа явахгүй шүү гэдгийг хэлье.

2-т нь тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөл аваад байх юм. Энийг болимоор байна. Тэр хаа байсан Өмнөговийн Гурван тэс, тэр Ховдын Дарви сумын Тамгын газар, аймгийн Тамгын газар, хэлтэс газрууд ажиллах хүнийг эндээс тусгай шалгалтыг нь авна гэдэг чинь юу гэсэн үг юм. Тухайн аймгийн Засаг дарга нь сонгуулийн дараа мөрийн хөтөлбөрөө боловсруулаад, үйл ажиллагааны чиглэлээ

батлуулаад, бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлээд, тэрэндээ тохирсон боловсон хүчин, хүний нөөцөө бүрдүүлэх гэхээр тусгай шалгалт гэдэг юмыг нь энэ Төрийн албаны зөвлөлөөс авдаг. Тэгээд тэнд нь тэнцдэггүй, унагачихдаг. Ингээд орон нутагт бас боловсон хүчний дутагдал. Бүгдээрээ л ерөөсөө нийслэлд төвлөрчхөөд байгаа шүү дээ. Орон нутагт цаана нь боловсон хүчний дутагдалтай. Хүмүүс нь бүгдээрээ нүүгээд, төв суурин руу явчихсан. Тэгээд төвлөрлийг сааруулах бодлоготойгоо ч гэсэн энэ чинь нийцээд явна.

Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн өөр өөрийн гэсэн тусдаа ажил үүрэг хуваарилаад авчихсан. Тухайлбал сонгон шалгаруулалт хариуцчихсан зөвлөлийн гишүүн, Хяналт шалгалт хариуцсан зөвлөлийн гишүүн гэх мэт хариуцчихсан. Тэгэхээр энэ чинь өөрөө нөгөө хяналт шалгалтыг хэн хариуцах нь тодорхой, сонгон шалгаруулалтыг хэн хариуцах нь тодорхой болчихоор авлига, ашиг сонирхлын асуудал бий болчихож байгаа юм. Тийм учраас Төрийн албаны зөвлөлийн гишүүд жишээ нь гомдол ороод ирэхэд, шууд ороод ирсэн даруйд нь хуваарилдаг л байх ёстой байхгүй юу. Та энэ дээр ажилла, та энэ дээр ажилла, сонгон сургуулийг та хариуц гэхгүй бол өмнөөс мэдэж байгаа тохиолдолд энэ авлига, ашиг сонирхол орж ирэх ийм бололцоотой болно.

Дараагийн дугаарт нь гадаадад тухайлбал өндөр мэргэжил Харвардын их сургууль, дэлхийн нэр хүндтэй топ сургуулиуд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Төрийн албаны зөвлөлийн дарга энэ тэр нь байхгүй байх шиг байна. Тэгэхээр нэр дэвшигчдээсээ л ганц 2 зүйл асууя. Ер нь төрийн албаны ажлыг, ер нь аливаа системийг ажлаа хэмжих гэдэг чухал ойлголт байдаг. Тэгэхээр яг манай төрийн албаны үндсэн хэмжүүр нь юу байдаг юм бэ. Тэр тусмаа ер нь ажил хийж байгаа бол бүтээмж гэдэг ойлголт өөрөө чухал. Дэлхийд өнөөдөр хамгийн баян орон АНУ тэр Дожи гээд төрийн албаны үр дүн, үр нөлөөний тухай, бүтээмжийн тухай асуудлыг асар хүчтэйгээр ярьж байна. Манайх болохоор ийм цомхон чадварлаг гээд амны уншлага болсон үгтэй. Тэр нь яг юу гэсэн үгээ ч тайлбарлаж байгаа юм үнэндээ байдаггүй. Тэгэхээр энэ нэр дэвшигчид товчхон байдлаар ер нь төрийн албаны ажлын хэмжүүр, гол зорилго ер нь яг юу юм. Тэр тусмаа төрийн албаны бүтээмж гэдэг ойлголтыг та бүхэн ер нь юу гэж ойлгож ойлгож байгаа вэ. Бүтээмжтэй байх гэдэг дээр тодорхой бас хариулт хэлж өгөөч.

Дахиад дээрээс нь төрийн албан дээр ийм маш субьектив төрийн албанд гэдэг шинэ залуучууд орж, тэнд үндсэндээ цонх салхи ордоггүй нэг ийм сонин байгууллага болоод хувирчихсан ийм л газар байдаг. Тэгээд төрийн албаны шалгалт гэдэг зүйл өөрөө аймаар субьектив. Тэр тусмаа 40 хувь нь ч байна уу, хэдэн хувь нь ярилцлагаар шийднэ гэдэг. Ярилцлага гэдэг зүгээр л үндсэндээ хэн яаж оноо өгч байгаа, яаж байгаа нь асар үзэмжийн субьектив. Үүний цаана ар өврийн хаалга, үүний цаана нам улс төрийн нөлөө олон зүйл ерөөсөө ганцхан ярилцлагаар асуудлыг шийдчих ийм л боломжтой. Тэр мэргэжлийн шалгалт, тусгай шалгалт, ерөнхий шалгалт дээрээ ямар оноо авч байгаа юм, тестээр хэдэн оноо авч байгаа нь тэнд гарсан зөрүүг ярилцлагын 40, 50 хувь дээр очоод ярилцлагаар шийднэ гэдэг. Тэгэхээр энэ өөрөө Монголын төрийн албаны орж байгаа үүд хаалга, орж байгаа босго шалгуур, орж байгаа улс төрийн нөхцөл байдал олон олон зүйл ингээд нөлөөлчхөөд байгаа юм. Энэ дээр улс төрийн нөлөө. Улс төрийн нөлөө гэдэг нь явсаар явсаар байгаад эрх барьж байгаа МАН-ын улс төрийн нөлөө л энэ дээр асар

ихээр ингээд орчхож байна гэсэн ийм л нөхцөл байдал үүний цаана гардаг. Тэгээд нэр дэвшигчдээс тэр тодорхой төрийн албаны ажлын хэмжүүр, үр дүн, үр нөлөөг та нар ер нь юугаар хэмжих ёстой гэж боддог юм.

Тэр тусмаа бүтээмж гэдэг ойлголтдоо товчхон товчхон хариулт өгөөч. Төрийн албаны бүтээмж гэдэгт юуг ойлгож, яаж хэмжих ёстой гэж боддог вэ.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Лхагвасүрэнгийн Золзаяа 4 дүгээр индэр. 1 минут.

Л.Золзаяа: Төрийн албаны бүтээмж гэдэг нь болохоор төрийн албаны хуулийг мөрдүүлэх асуудалтай шууд холбогдоно. Монгол Улсын хэмжээнд бол хуулийг төрийн бүх байгууллага, албан тушаалтан мөрдөж ажиллах үүрэгтэй. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр бол ажиллана. Бүтээмжийн хувьд бол Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад, процессын дахин инженерчлэлийн аргачлалыг төрийн албанд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа юм байна лээ. Тэгээд энэ процессын дахин инженерчлэлийг нэвтрүүлснээр төрийн албаны шийдвэр гаргалт хурдасдаг, зардал буурдаг, бүтээмж өсдөг, хүнд суртал буурдаг. Тэгээд иргэд олон нийттэй харилцах итгэлцэл нэмэгддэг ийм ач холбогдолтой юм байна лээ. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй төрийн албаны гишүүнээр томилогдсон тохиолдолд бол идэвхтэй хамтарч ажиллах болно гэж төлөвлөж байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Цэнддаваагийн Амартөгс.

Ц.Амартөгс: Төрийн албаны бүтээмжийг энэ тогтолцооных нь хувьд бол 3 түвшинд ангилж ойлголтыг нь авч үзэж болно. Макро түвшинд буюу систем тогтолцооны үр ашгийн түвшинд үнэлдэг. Энэ маань олон улсын болон бие даасан байгууллагуудын үнэлгээгээр засаглалын индекс гэдэг юм уу, Засгийн газрын үр ашгийн индекс, бодлогын үр нөлөө, авлигын индекс гэх мэт бие даасан индексүүдээр энийг хэмжих боломжтой. Мезо түвшинд салбарын үйл ажиллагааны үр дүнгээр хэмжих ёстой. Хийх ёстой, хэрэгжүүлэх ёстой бүтээгдэхүүн, үйлчилгээ иргэдэд хэрхэн яаж зөв очсон бэ. Зарцуулсан төсөв хөрөнгө яг тэр хэмжээндээ иргэдэд хүртээмжтэй очсон уу, үгүй юу үйлчилгээгээр дамжиж гэдэг энэ агуулгаар хэмжигдэнэ. Микро түвшинд буюу төрийн албан хаагчийн хувь хүний хувьд ямар ур чадвараа ахиулаад, тэрхүү бодлого боловсруулах болон үйлчилгээ хүргэх үйл ажиллагаандаа шударга, ил тод ажилласан бэ гэдэг ингэж хэмжээд гүйцэтгэлийн төлөвлөгөө болон .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Бадамдоржийн Төгсцэнгэл.

Б.Төгсцэнгэл: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд төрийн албаны үйл ажиллагаанд бол гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог стратегийн зорилго, зорилт, төлөвлөлттэй уялдуулж чанарт суурилсан хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт Ки Пи Ай бүхий байдлаар байгууллагын гүйцэтгэлийг үнэлэхийн зэрэгцээ хувь ажилтны гүйцэтгэлийг бодитоор үнэлэхийг бол чухалчлах нь зүйтэй гэж харж байгаа. Гүйцэтгэлийг ки пи ай-уулж хэмжиж үнэлснээр ялгаатай чиг үүрэг бүхий албан хаагчийн мэдлэг, ур чадвар, хөгжлийн түвшин, үр дүнг тодорхойлох суурь болж, улмаар бүхий л үе шатыг нээлттэй, хялбар болгох цахим шийдлээр дэмжсэнээр

үнэлгээний цахим системийн суурь тавигдаж, тайлагнах, хянах, дүгнэх боломж бол бүрдэнэ гэж харж байгаа.

Төрийн байгууллагын гүйцэтгэл үр дүнг үнэлэхдээ бол зөвхөн тайлан тоон үзүүлэлтээр зэрэгцэхийн зэрэгцээ иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөө, сэтгэл ханамж зэрэг чанарын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Бүтээмж гэдэг өөрөө шинжлэх ухааны том салбар, том ойлголт болоод явчихсан. Хэмждэг олон олон арга хэлбэрүүдтэй. Та нарын ярьж байгаа хэтэрхий л ерөнхий байна. Тэрэнтэй цаашдаа анхаарч ажиллахад бид нар чинь өөрөө мэдээллийн эрин зуун, мэдээллийн эрин зуун маань явсаар байгаад хиймэл оюун бүхий л түвшинд оччихлоо. Гэтэл манай Монгол Улс цахимжиж байна, төрийн албат цахимжиж байна. И-Монголиа гээд асар олон зүйлүүдийг ярьдаг. Үнэхээр тэнд бүтээмжийн асуудал яригдаж байгаа бол тэнд цахимжиж байгаа, технологижиж байгаа бол нөгөө талд нь орон тооны хэмнэлт, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх хялбаршил олон олон зүйлээр илрэх ёстой. Гэтэл манайд цахимжиж байна гээд асар их мөнгө тавиад байдаг, нөгөө талд нь төрийн алба нь улам томроод байдаг. Тэгэхээр энэ бодлогын үндсэндээ алдаатай бодлого, үр дүнг нь нэг ийм хүсээгүй үр дүн, ялгаатай байдал дээр цаашид та бүхэн илүү тодорхой болгож, шинээр томилогдвол тэгээд ажиллана биз дээ. Энэ салбарт бол хийх ажил асар их байгаа шүү гэдгийг л хэлье.

Д.Амарбаясгалан: Энэ бүтээмжтэй холбоотой асуудал дээр нэгдсэн 1 ойлголттой болмоор юм шиг байгаа юм. Ер нь төрийн бүтээмж яагаад суларчихсан юм бэ гэдэг зүйлээс нь эхлээд бүгдээрээ судалж эхлэх ёстой. Гаднын гоё нэр томьёо ярихаас илүүтэйгээр бид яагаад бүтээмжгүй болсон юм гэж. Төрийн алба данхайсан. Олон 100 мянган төрийн албан хаагчтай болсон. 1 ажлыг 1 хүн гүйцэтгэх нөхцөлийг магадгүй 5 хүн гүйцэтгэдэг хэлбэр лүү шилжчихсэн. Энэ байдал чинь л өнөөдөр төрийн албаны бүтээмжийг сулруулсан гол үндэс шалтгаан гэж харах хэрэгтэй. Жишээлбэл Засгийн газар 50 хүний бүрэлдэхүүнтэйгээр яамнуудын бүтцийг хийж болдог байсан цаг үе саяхан бас байгаа. Гэтэл өнөөдөр захын яам 120-150 ажилтантай болчихсон байгаа байдал нь 1 хүн хариуцаж хийх ажил хэт их цалгардаж байгаагийн л том илрэл.

Монголбанк дээр би жишээ авч хэлье. 15 жилийн өмнө Монголбанк нийтдээ 270 орчим ажилтантай байсан. Өнөөдөр 700 болсон. Бүтээмж нь дээшилсэн үү, дордсон уу гэдэг үнэлгээ гарахаар дордсон гэдэг зүйлийг тэнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид өөрөө хэлээд сууж байдаг. Хяналт шалгалт гэдэг нэртэй газар байж байхад 1-ийг нь хяналтын, нөгөөдхийг нь шалгалтын газар болгож салгаснаас болоод ажил дундаа эзэнгүүддэг нөхцөл рүү оруулснаас болж энэ бүтээмж бодитоор буурчихсан.

Нөгөө талдаа төрийн процесс өөрөө асар олон давхардалтай болсон. 1 жишээ хэлье. Амьдрал дээр болж байгаа зүйл. 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ тогтоолгож группийн мөнгөө авахын төлөө 11 шат дамжлагыг дамждаг. Сардаа 50 мянган төгрөг 2 жилийн хугацаанд сая 200 мянган төгрөгийн группийн мөнгө авахын төлөө тэр иргэн 11 шат дамжлагыг дамжихдаа тэр авч байгаа мөнгөнөөсөө илүү зардал гаргадаг тохиолдол амьдрал дээр байж байгаа. Тэгэхээр ерөөсөө л энэ процессыг цөөлөх, төрийн бүтцэд дахин инженерчлэлийг

хийх, давхардсан энэ ажил хариуцаж байгаа нөхцөл байдлыг хийдэл гаргахгүй болгох гэдэг өнөөдөр бодитоор Монголын нийгэмд бүтээмж дээшлүүлэх үндэс шалтгаан болсон гэдгийг манай Төрийн албаны зөвлөл энэ дээр бодитой дүгнэх ёстой. Нөгөө талдаа би бас өмнө нь Байнгын хороо дээр хэлж байсан. Төрийн албаны зөвлөл Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг. Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлдэг байгуулдаг байгууллага. Гэтэл өнөөдөр Төрийн албаны зөвлөл юуг хийж байна вэ гэхээр төрийн албан хаагчдаас шалгалт авдаг, төрийн албан хаагчдыг хаана ажиллаж болох, болохгүй шийдвэрийг гаргадаг байгууллага болоод хувирчихсан. Цаашдаа төрийн албаны хуульд өөрчлөлт оруулаад, Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг гүйцэтгэдэг. Харин гүйцэтгэх засаглал өөрийнхөө хүний нөөцийн бодлогыг гаргаж, хүнээ сонгож, томилж ажилладаг болох тэр эрх зүйн орчныг бий болгож өгөх ёстой юм байгаа юм. Тэгэхээр энэ бүгд дээр та бүхэн онцгой анхаарч ажиллаарай гэдгийг бас Цогтгэрэл гишүүний асуусан асуулт дээр дайж үгээ хэлье. Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж үг хэлье.

Ж.Баясгалан: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анги, асуудлыг хөндөж ярьсан Улсын Их Хурлын дарга Амарбаясгаландаа их баярлалаа. Тэгээд уг нь Төрийн албаны зөвлөлийн дарга байсан бол асуух асуулт байлаа. 3 нэр дэвшигчээсээ 2 асуулт асууна. Хоёуланд нь маш тодорхой хариулаад өгчхөөрэй.

Төрийн албаны зөвлөл бол ажиллагсдын хувьд бол 100 хувь орон тоо бүрдсэн байгаа. Эмэгтэй 64 хувь гэж байна лээ. Эрэгтэй 37 хувь гэж байна лээ статистик дээр. Тэгээд энэ зөв үү. Ер нь маш их эмэгтэйчүүд ажилладаг юм уу Төрийн албаны зөвлөлд. Энийг бас тодруулмаар байгаа юм. Ер нь бол удирдах албан хаагчид 7,5, гүйцэтгэх албан хаагчид 81,7, туслах албан хаагч 10,7 гэж байгаа юм. Энэ ажиллагсад дунд Төрийн албаны зөвлөлд ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа юу. 1 дүгээрт.

2 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг энэ жил 2025 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн жил болгон зарласан. Халамж биш. Халамжаас илүү хөдөлмөрлөдөг, нийгэмд гардаг хүртээмжийн асуудлыг нь шийдэж өгье гэдэг дээр. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн албаны шалгалт өгөхөд бол хэцүү байдаг. Энэ дээр бол бүх иргэд бол хэлдэг. 2 шатын шалгалт өгнө. Мэдээж тохируулгатай шалгалт авах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс. Та бүхэн сонгогдвол энэ дээр яаж ажиллах вэ. 3 гишүүний намтартай нь танилцахад бол гурвуулаа энэ тал дээр бол ажиллах боломжтой гэж харж байгаа юм. Ардчилсан Монгол Улсын хамгийн эрхэм зүйл бол хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёстой, хууль, шүүхийн өмнө бүгд тэгш эрхтэй. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ тэгш оролцоог хангахын тулд юу хийх ёстой вэ. Энэ дээр та бүхэн бас нэг саналаа хэлээдхээрэй.

Төрийн албаны зөвлөл гэдэг маань ялгаагүй хуулиа биелүүлэх ёстой. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд 25-аас дээш ажиллагсадтай л бол тэр 25 хүн тутмын 1 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх ёстой. Тэгэхээр энэ хуулийг ер нь Төрийн албаны зөвлөл өөрөө биелүүлж байгаа юм уу. Энэ дээр та 3 маань эхлээд яг байр сууриа 2 асуултад тодорхой хариулчхаарай гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Лхагвасүрэнгийн Золзаяа хариулт өгье. 4 дүгээр индэр.

Л.Золзаяа: Баясгалан гишүүний асуултад хариулъя. 2024 оны байдлаар төрийн албанд 5000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байгаа гэсэн тооцоо статистик байгаа. Энэ нь болохоороо өнгөрсөн 2023 оны статистикаас бас 28 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм байна лээ. Тэгээд Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдсон тохиолдолд бол энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн албаны зөвлөлд тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бол ажлын байраар хангах асуудлыг бол бүрэн дэмжиж, санаачилж ажиллах болно гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс хариулт өгье.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя. Нийт төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчдын 64,3 нь эмэгтэй гэдэг тоо статистик байгаа. Энэ бол 2024 оны статистик мэдээлэл гэдгийг тодруулж хэлье.

Төрийн албаны зөвлөлийн аппарат өөрөө 56 орон тоотой. Энд хөгжлийн бэрхшээлтэй иргэн квотынхоо дагуу ажилладаг. Энэ үйл ажиллагааг илүү өргөжүүлэх тал дээр Төрийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд шалгалт зохион байгуулж байгаа болон хөдөлмөрийн тусгай тохируулга хийх үйл ажиллагааг нь дэмжих зөвлөх үйл ажиллагааг хийдэг. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцох, тест бөглөх ийм тохируулга хийгдсэн ийм бүрэн боломжтой кабинеттай Төрийн албаны зөвлөл ажилладаг. 5853 хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн албанд ажиллаж байна гэсэн мэдээлэл байгаа. Тэгэхээр энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Бадамдоржийн Төгсцэнгэл хариулт өгье.

Б.Төгсцэнгэл: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны нэгдсэн тоо бүртгэлээр нийт 4276 төрийн байгууллагад 226.895 албан хаагч ажиллаж байна. Хүйсийн харьцаагаар авч үзэх юм бол эмэгтэй төрийн албан хаагч 145.930 буюу 64,3 хувийг, тэгээд эрэгтэй төрийн албан хаагч 80.965 буюу 35,7 хувийг эзэлж байна. Үүнээс удирдах албан хаагч нь 17095 буюу 7,5 хувь байна. Эндээс хүйсийн харьцаагаар нь үзэх юм бол эмэгтэй төрийн албан хаагч 7917 буюу 46,3 хувийг, эрэгтэй төрийн албан хаагч 9178 буюу 53,7 хувийг бол эзэлж байна. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд бол анхаарах гол асуудал нь жендерийн тэгш бус байдал ба хүний нөөцийн бодлого, үйл явцыг жендерийн мэдрэмжтэй болгож чадавхжуулахад бол хуульд заасан квотыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж бол хувь нэмрээ..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн тодруулж асууя.

Ж.Баясгалан: 3 нэр дэвшигч маань гурвуулаа тодорхой тоо баримттай яг хариуллаа. Тэгээд энэ дээр дахиад яг миний хэлээд байгаа юм бол хуулиа биелүүлээгүй байгаа шүү. Төрийн албаны зөвлөл. Тийм байгаа биз. Ингээд үзэхээр 50 хувьдаа хүрэхгүй байгаа юм. Өнгөрсөн 2023 оны байдлаар бол 42 хувьтай байсан. Энэ удаа бол энэ нь өөрөө 50 хувь руу дөхөж байна. Уг нь бол 9 мянган хүн ажиллах ёстой. Тэгэхээр энэ дээрээ шахаж ажиллуулаарай. Бид нар өөрсдөө хуулиа биелүүлэх ёстой гэдэг дээр л би гол шаардлагыг тавьж байгаа юм шүү. Тэгэхээр хуулиа биелүүлэхийн төлөө та хэд маань сая хэллээ шүү дээ. Монгол Улсад байгаа 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гэр бүл сонслоо. Тэгэхээр

энийгээ ажил болгоод яваарай. Тэгээд та нартаа амжилт хүсье. Гурвуулааг нь дэмжиж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд Лувсанжамц гишүүнийхээ санаачлаад явж байгаа “Дулаан баатар” аяныг дэмжиж байгаа гэдгээ бас илэрхийлье. Агаар орчны бохирдолгүй, эрүүл Монгол хүний төлөө бүгдээрээ хичээх ёстой.

Төрийн албаны зөвлөлд та бүхнийг ороод хамгийн түрүүнд төрийн албан хаагчдын нэр хүндийг хамгаалаасай гэж хүсэж байгаа юм. Энэ төрийн албан хаагчдын нэр хүнд чинь бүр шалаар нэг боллоо. Ний нуугүй хэлэхэд. Ганц нэг авлигачин, хүнд сурталтнаас улбаатайгаар бүх төрийн албан хаагчдын нэр хүнд унаж байна. Төрийн албаны зөвлөл өнөөдрийг хүртэл төрийн албан хаагчдын нэр хүндийг хамгаалах нэг ч ажлыг хийхгүй байна. Монгол төрийн албан хаагчид бол цаг наргүй яг Монгол төрийн төлөө зүтгэж байгаа гэдгийг би бас энд цохон тэмдэглэж хэлмээр байна.

2 дугаарт давхардсан чиг үүрэгтэй холбоотой асуудлыг нэг дор нэгмөсөн цэгцлээсэй гэж хүсэж байгаа юм. Саяын ДЦС-3-тай холбоотой асуудал бол яг ний нуугүй хэлэхэд энэ олон чиг үүргийн давхардалтай холбоотойгоос үүдэлтэй. Дээрээс нь хариуцлагагүйн зуд нүүрлэсэнтэй холбоотой асуудал. Чиг үүргийн давхардлаас улбаатай хариуцлагын асуудал ерөөсөө хөндөгдөхгүй байна. Өнөөдөр Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчис Монгол, Эрчим хүчний үндэсний хороо гээд баахан юм байгуулчихсан. Энэ давхардлын чиг үүргийг цэгцлэхгүй байгаа асуудал бол яалт ч байхгүй Төрийн албаны зөвлөлтэй холбоотой асуудал. Энийгээ та бүхэн маань их сайн олж хараач ээ гэж хүсэж байгаа. Энэ дээр би бас хариулт авмаар байна.

3 дугаарт Төрийн албаны тухай хууль мэдээж Улсын Их Хурал парламент бид нар шийдээд явах ёстой. Гэхдээ манай Төрийн албаны тухай хууль орох орцтой гэхдээ гарах гарцгүй хууль. Өөрөөр хэлбэл ямар ч хүн тэнд төрийн албаны шалгалтаа өгөөд орсон тохиолдолд буцаад тухайн хүнийг гаргах бараг боломжгүй шахуу хууль. Тэнд төрийн албаны тухай хуулиар бамбай хийж ажил албан тушаалаа гүйцэтгэхгүй, эс үйлдэхүй гаргаж байгаа маш олон төрийн албан хаагчид бас нөгөө талдаа байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Тэгээд энэ төрийн албаны тухай хуультай холбоотой мэдээж та бүхэн маань хэрэгжүүлнэ л гэж ярих байх.

Дараагийн нэг асуудал бол энэ төрийн албыг найзын, найз дундаа аман байдлаар хийж явахгүй ээ. Эндээс чинь авлига үүсээд байгаа юм. Энэ найз дундаа явж байгаа энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ. Хууль хэрэгжих ёстой. Энэ хэрэгжүүлэх үүрэг нь ч бас бий. Тэгээд Төрийн албаны зөвлөлд нэр дэвшиж байгаа та бүхэн бас энэ 3 асуултад хариулаад өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 1 санамж уншиж танилцуулъя. Манай Улсын Их Хурлын гишүүд гишүүн болоод шинэ гишүүний сургалтад хамрагдаад, тус бүр санамж бичгийг авсан байгаа. Гишүүн болгонд энэ санамж бичиг өрөөнд нь, хавтсанд нь, цүнхэнд нь, ширээн дээр нь байж байх ёстой болов уу гэж бодож байна. Мэдээж санал санаачилгууд гаргаад тэрийгээ олон нийтэд хүргэх гээд явж байгааг бол цаашаа нь дэмжинэ.

Санамж бичгээр Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын, дэд, түр хорооны хуралдаанд оролцогч дараах санамжийг баримтална гэж байгаа юм.

1 дүгээрт хуралдааны танхимд Үндэсний болон албаны хувцастай нэвтэрч, өөрт хамааралтай хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралдаан зохион байгуулах асуудал хариуцсан албан хаагчийн заасан дугаар бүхий суудалд суух гэдэг ийм санамж бичиг байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Яах вэ гишүүд маань өнөөдөр “Дулаан Улаанбаатар” гэдэг Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой асуудлаар бичигтэй футболк өмсөж байгаа юм байна. Тэгэхээр чуулганы танхимд энэ футболкийг өмсөхийг хориглож байна. Санамж бичиг байгаа.

Бид төрөө хүндлэх ёстой, түмэн олноо хүндлэх ёстой. Олон нийт рүү чиглэсэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж хийж байх учиртай гэдгийг бас та бүхэндээ хэлье. Би дахиад нэг зүйлийг сануулж хэлье.

Төр нь төвшин түмэн олон амгалан байх болтугай гэдэг зүйлийг бид дандаа бодож, ажиллаж амьдрах ёстой. Үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, бодлого, зарчим санал гаргах зүйлийг огт шүүмжлэхгүй. Тэр бол та бүхний хуулиар олгогдсон эрхийн асуудал. Харин төр нь төвшин амгалан байхын төлөөх үйл хэрэгт Улсын Их Хурлын гишүүн, дарга, сайд болгон идэвхтэй, санаачилгатай, хүндэтгэлтэй хандаж байх ёстой гэдгийг бас хариуцлагатай хэлье.

Асуултад хариулъя. Лхагвасүрэнгийн Золзаяа.

Л.Золзаяа: Төрийн албаны нэр хүндийг хэрхэн өсгөх вэ, хэрхэн хамгаалах вэ гэдэг дээр бол тантай санал нэг байна. Төрийн албаны нэр хүнд, шударгаар ажиллаж байгаа төрийн албан хаагчийг хамгаалах, дэмжиж ажиллах ёстой. Төрийн албыг бол хэт сулруулах нь үндэсний аюулгүй байдалд бол сөргөөр нөлөөлнө гэж миний хувьд бол үзэж байна. Тийм учраас Төрийн албаны зөвлөлийн зүгээс томилогдсон тохиолдолд бол төрийн алба болон төрийн албан хаагчийн нэр хүндийг өсгөх чиглэлээр бол өнгөрсөн хугацаанд хийгдээгүй ажлуудыг бол санаачилж хийнэ гэж төлөвлөж байна.

Давхардсан чиг үүргүүдийг бол цэгцлэх ёстой гэдэг байр суурьтай бол 100 хувь санал нэг байна. Энэ төрийн албыг танил тал, найзын хүрээнд явуулж байгаа гэдэг асуудлын хүрээнд бол тодорхой хуулиудын хязгаарлалтууд байгаа. Энэ хуулийн хязгаарлалт, зарчмыг баримталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллан гэж төлөвлөж байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Цэнддаваагийн Амартөгс.

Бат-Эрдэнэ гишүүн энэ нөгөө Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчээс асуулт хариулт явж байгаа. Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн дарга ирэх үүрэггүй байгаад байгаа юм.

Ц.Амартөгс: Төрийн албаны нэр хүндийг өсгөх тал дээр бол санал нэг байна. Яалт ч үгүй чиг үүргээс тогтолцооны үйл ажиллагааны хувьд чиг үүргийг хуваарилах бүрэн эрхийг тодорхой болгох үйл ажиллагаа хийгдээд, энэ маань өөрөө эргээд гүйцэтгэлийн удирдлагын механизмаараа илүү үйл ажиллагаа нь үнэлэгддэг. Ингэснээрээ бол албаны харилцаа зөвхөн хуулиар хэрэгжүүлэх үүргээ хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүйн төлөө хариуцлага ноогдуулах, илүү сайн бүтээмжтэй ажиллаж

байгаа нөхцөлд урамшуулах энэ систем бүрэн ажиллана гэж ингэж харж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд одоо тулгамдаад байгаа асуудлууд ялангуяа хүний нөөцийн эргэлт, хөдөлгөөн, илүү үр дүнтэй ажиллах механизмыг сайжруулахтай холбоотой ажлууд хийгдэнэ. Энэ дээр ч гэсэн бас тодорхой саналууд, судалгаанууд дээр Төрийн албаны зөвлөл хамтарч ажиллах, оролцох үүрэгтэй байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Бадамдоржийн Төгсцэнгэл.

Б.Төгсцэнгэл: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Таны төрийн албаны нэр хүнд унаад байгаа, төрийн алба төрлийн алба болоод байгаа гэдэг дээр хариулъя. Ер нь бол Улсын Их Хурлаас бол төрийн албаны байгууллагуудын давхардсан чиг үүргүүдийг цэгцлэх, төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй, процесс уялдаатай цэгцтэйгээр зохион байгуулахаар процессын дахин инженерчлэлийн асуудлыг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулаад ажиллаж байгаа. Процессын дахин инженерчлэл бол манай улсын хувьд шинэ зүйл биш. 1996 оны Улсын Их Хурлын 38 дугаар тогтоолоор Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлтийг шинэчлэх бодлого баталсан. Анхны суурь нь бол тавигдсан. Энэ нь тухайн үед бол нам төвтэй улс төрийн тогтолцооноос төр төвтэй улс төрийн тогтолцоонд шилжих эхлэл болж байсан. Харин өнөө үед бол нийгмийн хөгжлийн шаардлага, чиг хандлагад бол нийцүүлэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 3 Нэр дэвшигчээ бол дэмжиж байгаа. Одоо бид нар хамгийн гол асуудал бол энэ хариуцлагатай холбоотой асуудлыг л хөндөөд байгаа юм. Хариуцлагагүйн улмаас л төрийн албан хаагчдын нэр хүнд нэг талдаа унаад байгаа шүү дээ. Тэр төрийн албан хаагчдын бараг буруу гэхээс илүүтэйгээр энэ тогтолцоо дээр байгаа асуудал давхардсан чиг үүргийг хуулиар нээж өгсөнтэй холбоотой асуудал байхгүй юу. Төрийн албаныхан ч яах вэ ингээд тангаргаа өргөөд сайхан орж ирээд ажиллаж байх шиг байна. Төрийн өмчит компаниудыг яах вэ. Төрийн албанд багтаагүй нөхөд нөгөө олон давхардсан чиг үүргийн дагуу шаардлага хангахгүй учраас төрийн өмчит компанид орж, тэнд бусниулж байгаа юм. Тангараг өргөөд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын өмнөөс ажиллаж байгаа. Тэнд хариуцлага ерөөсөө явагдахгүй байгаа. Тэгээд энийг та бүхэн маань бас их сайн олж харж ажиллаасай гэж хүсэж байна. Дэмжиж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Нэр дэвшигч нарын материалтай танилцсан. Дэмжиж байгаа. Гэхдээ тодруулаад асуух зүйлүүд бол байна. Та хэдийнхээ бас саналыг сонсмоор байгаа юм.

Сүүлийн хэд хоногуудад эмч, багш нараас бусад 14 мянга гаруй төрийн албан хаагчийг цомхотгоно гэсэн мэдээлэл бол гарч ирлээ. Тэгээд та хэд маань мэдээж Төрийн албаны тухай хуулийг мэдэж байгаа. Тэгээд төрийн албаны ерөнхий шалгалтыг өгөөд, тэр дотор нь ажиллаж байсан хүний хувьд 62.1.4 дүгээр заалтыг заавал сануулъя гэж хүслээ. Тэгэхээр төрийн байгууллага хэрвээ татан буугдах юм бол өөрчлөн байгуулагдах юм бол эсвэл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан

тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих эсвэл төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэших. Энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах эсвэл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг тухайн байгууллагаасаа авна гэж байгаа. Тэгэхээр энэ хуулийн заалт мэдээж хэрэгжих л байх л даа. Тэгээд яг энэ 14 мянган төрийн албан хаагчийг цомхотгох асуудал нь болохоор давхардсан орон тоо их байна гэж яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр Төрийн албаны зөвлөл дээр бүх салбар яамнууд өөрсдийнхөө албан тушаалын тодорхойлолтыг батлуулдаг. Тэгээд энэ баталж байгаа субъект нь өөрөө давхардлаа харах ёстой байхгүй юу. Тэгэхээр миний бодлоор бол хариуцлага Төрийн албаны зөвлөлийнх юм шиг. Тэгэхээр энэ асуудал дээр ер нь ямар бодолтой байна. Саналтай байна. Ялангуяа би Улсын Их Хурлын Тамгын газарт маш олон жил ажилласан Төгсцэнгэл нэр дэвшигчээс яг энэ асуултууд дээрээ хариулт авахыг хүссэн.

Тэгээд дараагийн асуулт нь болохоор миний санал асуух гээд байгаа зүйл нь Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан даргын санаачилсан Шүүр ажиллагаа гээд 5ш ажиллагааны хүрээнд явсан. Энэ бол ерөөсөө шинээр хууль тогтоомж бий болгоод хэрэгжүүлэх гэсэн биш, байгаа хууль хэрэгжих ёстой, төрийн албанд шаардлага хангаагүй албан хаагчдыг яах вэ гэдэг дээр шүүр ажиллагаа бол амжилттай сайн хэрэгжсэн гэж бол би боддог. Тэгэхээр энэ шүүр ажиллагаа гэж нэрлээд, энийг заавал хүчитгээд ингэж явах шаардлагагүй. Ер нь л төрийн албаны хуулийг Хөдөлмөрийн хуультайгаа ер нь хэрэгжүүлээд явах ёстой. Тэгэхээр энэ шүүр ажиллагааг үргэлжлүүлээд явах юм уу. Эсвэл хуулийн хэрэгжилтдээ яг анхаараад явах юм уу. Ер нь яг ямар арга хэмжээ бүгдээрээ авах ёстой юм. Тэгээд яг түрүүн Бат-Эрдэнэ гишүүний хэлснээр ер нь бол одоо ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа хамгаалж, өмөөрсөн байр суурьтайгаар бол энэ үгээ бол хэлж байгаа юм шүү. Тэгээд Төгсцэнгэл нэр дэвшигч энэ 2 агуулга дээр өөрийнхөө байр суурийг илэрхийлээрэй.

Д.Амарбаясгалан: Төгсцэнгэл нэр дэвшигч хариулт өгье.

Б.Төгсцэнгэл: Уянга гишүүний асуултад хариулъя. Сүүлийн үед бол төрийн албан хаагчдын тоог бууруулах асуудал их яригдаж байна. Энэ бодлого, зорилтыг хэрэгжүүлэхдээ бол нөхцөл байдлыг цогцоор нь харах шаардлагатай гэж үзэж байна. Энд бол төсөв талаасаа, хүний нөөц талаасаа, тэгээд бүтэц оновчлол талаасаа, чиг үүрэг хариуцлагын талаас нь цогцоор нь харах ёстой. Төрийн албан хаагчдыг бууруулах замаар төсвөө хэмнэх зорилго тавьж байгаа бол урсгал зардлын бүтцийг нарийвчлан судалж, мөн бусад зардлын бүтцийг хамтад нь харгалзаж илүү оновчтой шийдлийг тооцоолох нь зүйтэй гэж бодож байна. Одоогоор төрийн албанд нийт 226.859 албан хаагч ажиллаж байна. Энэ нь болох дээрээ цалин хөлсний зардлын төсөвт 19,4 хувь, харин цалин хөлсний зардал нь урсгал зардлын 13,6 хувийг бол эзэлж байгаа тул нийт төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө нь хязгаартай байж болох юм.

Хүний нөөц талаасаа бол төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах нь бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 1 минут.

Б.Төгсцэнгэл: Төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах нь бол ойролцоогоор бол 14400 орчим хүний ажлын байрыг хөндөх тул энэ шийдвэрийг бол хэрэгжүүлэхдээ төрийн албаны хүрээ, тогтолцоо хаанаас нь ямар зарчмаар гэсэн нарийн төлөвлөлт хийх шаардлагатай гэж бодож байна. Бүтцийн оновчлол талаасаа төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хүргэхэд зайлшгүй шаардлагатай албан тушаал, орон тооны тооцооллыг бол эхний үед хийх шаардлагатай. Үүний дараа чиг үүргийн давхардалтай төрийн өөрөө зайлшгүй гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн чиг үүргүүд юу юм. Мөн хувийн хэвшилд шилжүүлж болох чиг үүрэг, албан тушаалын тоог цөөрүүлэх замаар зөв суурьтай, тооцоотой, оновчтой шийдэл, бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Чиг үүргийн хариуцлага талаасаа бол ажлын байрны бүтцийн шинэчлэлд хамаарагдах үйл явц нь бол олон талын нөлөөллийг бол урьдчилж тооцох шаардлагатай. Тухайлах юм бол, хүний нөөцийн хөдөлгөөнөөс хамаараад дагаж олгогдох тэтгэмж, нийгмийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ, нийгмийн халамжийн зардлууд бол нэмэгдэнэ. Эдгээр зардлыг урьдчилан тооцож, хэмнэлтийг бодитой, үр дүнтэй харьцуулсан судалгаа болгож хариуцлагатай хандах шаардлагатай гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Шүүр ажиллагаа.

Б.Төгсцэнгэл: Шүүр ажиллагаа хэрэгжээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт н1 минут гүйцээж хариулъя.

Б.Төгсцэнгэл: Төрийн хяналт шалгалтын хуулийн хүрээнд шүүр ажиллагаа нь ажиллагаа амжилттай хэрэгжээд явж байгаа. Энэ ажиллагааны үр дүнгүүд гараад явж байгаа. Тэгээд ер нь бол хэрвээ би Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдоод очих юм бол төрийн албаны үйл ажиллагааг оновчтой, чиг үүргийн давхардалгүй хяналт шалгалтыг тодорхой болгох энэ Шүүр ажиллагаа гэх мэт үйл ажиллагаанд өөрийнхөө хувь нэмрээ оруулаад, идэвхтэй санаачилгатай ажиллана гэж хариулъя.

Д.Амарбаясгалан: Энэ төрийн албанаас 14400 хүн чөлөөлнө гээд өчигдрөөс эхлээд Засгийн газар төсвийн тодотголтой холбоотой асуудал бас яриад эхэлчихлээ. Тэгээд энэ яг ямар албан хаагчдаас яаж чөлөөлөх гэж байгаа талаар та нарт мэдээлэл байна уу. Төгсцэнгэл товч мэдээлэл өг дөө. Энд чинь төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээ, төрийн өмчит үйлдвэрийн газар гээд их олон төрлүүд байгаа. Нийтээр нь хамруулаад яваад байгаа. Мэдээж төрийн үйлчилгээ багш, эмчээс бол орон тоо цөөлөх ямар ч боломж байхгүй. Өнөөдөр дутагдалтай байгаа салбар шүү дээ. Хариулт өгье. 4 дүгээр индэр.

Б.Төгсцэнгэл: Амарбаясгалан гишүүний асуултад хариулъя. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар зохистой бүтэцтэй, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ гэж энэ тогтоолд дурдаж, энэ хүрээнд Засгийн газар өчигдөр Сангийн сайд мэдээлэл хийж байна лээ. Тэгээд төрийн албаны эмч, багш, сувилагчаас бусад нь гэхээр өнөөдрийн байдлаар 2024 оны нэгдсэн тоон үзүүлэлтээр төрийн албанд 21350 төрийн захиргааны албан хаагч буюу 9,4 хувь нь, 49071 буюу 46,1 хувь нь төрийн тусгай албан хаагч байгаа. Тэгэхээр эндээс тооцоолоод 9 хувь, дээрээс нь 150 мянган төрийн үйлчилгээний албаас багш, эмч,

сувилагчийг хасаад дүнгээ харьцуулаад тэрийг нь 9 хувь гэж тоо гаргасан болов уу гэж би хувьдаа бодож байна.

Төрийн захиргаа 21350, тусгай 49071. Ингээд нийт дүнгээрээ бодох юм бол 70 мянга байгаа. Төрийн үйлчилгээ маань бол 156 мянга байгаа. Тэгэхээр тэндээс эмч, багш нараа хассан дүнгээр тооцоод 14400 гэдэг тоо гаргаж ирсэн болов уу.

Д.Амарбаясгалан: Одоо наадхаар чинь төрийн захиргаа 21 мянга, төрийн тусгай 49 мянга гэдэг чинь нийлээд 80 мянга. Тийм ээ. 70 мянгаас 9 хувь 7200 орчим 6300. Цаана нь 14400-аас 6300 гэхээр 8100 төрийн үйлчилгээний албан хаагчид дээр чөлөөлөх ажил явагдах юм уу. Тийм задаргаа нь байна уу, байхгүй юу.

Б.Төгсцэнгэл: Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ тогтоолын төслийг хэлэлцүүлж байхад тодорхой судалгаа юмнуудыг танилцуулсан. Тэр судалгаанаас дурдъя. Энд бол захиргааны албанаас 10 хувь буюу 2153, тусгай албадаас 25 хувь буюу энэ болохоор сүүлийн 12 жилийн хугацаанд 70 хувиар өссөн. Бүтэц давхардалтай, цахимжих боломжтой, бүтээмжийн үнэлгээ сул гэсэн үүднээс тусгай албадаас 25 хувь, үйлчилгээний албанаас 9 хувь буюу 3658, улс төрийн албанаас 9 хувь буюу 340 гэсэн тоон судалгааг хэлэлцүүлгийн үеэр ярьж байсан.

Д.Амарбаясгалан: Иргэдэд, төрийн албан хаагчдад зөв мэдээлэл хүргэхгүй бол салбаруудад бас тодорхойгүй байдал үүсэх эрсдэлтэй. Тэр талаас нь тодруулж асуулаа. Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бейсен: Энэ Төрийн албаны зөвлөлийг ер нь нам бус, улс төрждөггүй гэж ойлгодог л доо. Гэтэл улс төржсөн шийдвэр гаргадаг, улс төржөөд зарим ялсан аймгуудын удирдлагуудын Засаг даргын эрхэнд алддаг, хугацаат даалгавар өгдөг асуудал гарч байгаа. Жишээлбэл аймгийн Тамгын газрын даргыг АТГ тухайн Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөлтэй томилж байхад дахиж тухайн аймгийн намаас сонгогдсон гишүүд ч юм уу, намыг дагаад хугацаат даалгавар өгөөд соль гээд байгаа. Энэ чинь Засаг даргын эрхэнд халдаж байгаа, нөгөө талаар тухайн аймгийн Засаг даргын засаглах эрх төрийн албыг самарч байгаа асуудал байхгүй юу. Энийг юу л гэж ойлгох вэ.

2 дугаарт төрийн албаны шалгалт ерөөсөө шударга бус явагддаг. Ярилцлагыг түрүүн бас Наранбаатар гишүүн ярилаа. Тест дээр яасан мөртөө ярилцлагадаа унагааачихдаг асуудал гарч байгаа. Хуулиар шалгагдаж байгаа нөхцөлд бас хугацаат даалгавар өгөөд ингээд чөлөөл гэдэг. Нөгөөдөх нь хуулиар шалгагдаад давж заалдах шат юм уу ингэж шалгагдаад явж байхад нөгөөдөх нь чөлөөл гэсэн хугацаат даалгавар өгдөг. Энийг юу гэж ойлгох вэ.

Дараагийн 1 асуудал Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-д жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх тухай заасан байхад хуулийг үгүйсгээд Төрийн албаны зөвлөлөөс улс төржсөн шийдвэр гаргаад байгаа. Жишээлбэл Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, ЗДТГ, Нийгэм бодлогын хэлтсийг ингээд хугацаат даалгавраар чөлөөлгөсөн ийм юм өгсөн байх юм. Тухайн аймаг сурагчдын хаврын 10 жил төгсөж байгаа ийм үед нь нөгөө

талаар бас эрүүл мэндийн салбарын чухал асуудлууд ингээд төрийн албыг самарсан шийдвэр гаргаж байгааг юу гэж ойлгох вэ. Дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Нэр дэвшигч Амартөгс.

Ц.Амартөгс: Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд томилгооны зөрчлийг шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ингэхдээ төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, мөн өргөдөл гомдлын хүрээнд бас хяналт шалгалтуудыг зохион байгуулж явуулж байгаа. Өмнө дурдсан энэ хууль хэрэгжсэнээс хойших хугацаанд бол 2234 томилгооны зөрчлийн асуудлыг бид хянан шийдвэрлээд, 80 хувь нь бол зөрчлөө арилгасан гэсэн ийм дүнтэй байгаа гэдгийг бол танилцуулж байсан. 178 буюу 10 гаруй хувь нь одоо хэрэгжих шатдаа байгаа. Тэгэхээр энэ хууль тогтоомж хэрэгжүүлэх хүрээнд тавьж байгаа хяналтын хүрээнд хэрвээ зөрчилтэй томилгоо байна гэдэг маань төрийн албаны хуульд заасан тэр шалгуур, шаардлагынх нь дагуу томилогдоогүй тохиолдолд томилгооныхоо зөрчлийг арилгах мэдэгдэл өгдөг. Тэгээд энэ хүрээнд нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ц.Амартөгс: Энэ хүрээнд тавьсан зөрчил арилгах шаардлагыг биелүүлэх хүрээндээ хугацаатай үйл ажиллагаанд шалгалт зохион байгуулагддаг. Шалгалтын үйл ажиллагааг 56 салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөл зохион байгуулж байгаа. Салбар зөвлөлүүдэд тухайн орон нутгийн болон байгууллагын төлөөллүүдэд 7-11 хүн ажилладаг. Энэ шалгалтын үйл ажиллагааг бие дааж шийдвэрлэх эрхтэй байдаг. Түр орлон гүйцэтгэж байгаагийн хувьд бол зөвхөн хууль ёсны гэж хэлж болно. Тийм нөөцөд байгаа иргэдээс түр орлон гүйцэтгүүлэх ёстой. Энэ нөөцөд байхгүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлсэн тохиолдолд хугацаатай үүрэг өгч байгаа. Энэ хугацаатай үүрэг өгч байгаа тохиолдол нь бол тухайн байгууллагын дотроос нь хууль ёсны хүнээр түр орлон гүйцэтгүүлээд, тэр хоорондоо шалгалт зохион байгуулах, хуульд нийцүүлэх шийдвэрүүдийг гаргах ийм зүйлүүд байдаг. Танд яг тодорхой мэдээллийг бол дэлгэрэнгүй гаргаж өгч болно.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Төрийн албаны зөвлөлөөс шалгалт хийхэд дутуу шалгалт хийгээд байгаа юм. Тухайн халагдсан иргэн ч юм уу хуулиар шалгагдаж байгаа. Давж заалдах шүүхийн шийдвэрээр явж байгаа хүмүүсийг ингээд дахиж хугацаат даалгавраар томил гэж байгаа нь улс төрийн даалгавар гэж бодож байгаа юм. Намуудын даалгавар юм уу. Нөгөө талаар энэ 43.3.4 дэх заалтыг үндэслээд чөлөө авсан, эрүүл мэндээ сувилуулах шаардлагатай гэж томилсон хүмүүсийг бас чөлөөл гэсэн байх юм. Энэ нь бас тухайн аймагт төрийн албыг самарч байна л даа. Чухал чухал эрүүл мэнд, боловсрол, төр захиргааны байгууллагуудыг ингээд ийм ноцтой юм гараад байна. Энэ дээр бас анхаарах шаардлагатай байгаа юм. Тэгэхгүй бол бас энэ боловсон хүчин бэлдэх асуудал дээр хүнд байна шүү дээ. Төрийн албанд ажиллах хүн байхгүй болчихоод байна. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Бас дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Энэ Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа 3 гишүүдээ баяр хүргэж байна. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд бас нэр дэвшиж байгаа Амартөгсөө дэмжиж байгаа. Ялангуяа боловсрол, мэдлэг, тууштай ажилласан туршлагаараа энэ чухал албыг үргэлжлүүлэн хаших ийм чадвартай хүн гэж үзэж байна.

Тэгээд 3 нэр дэвшигчээс нэг асуулт асууя. Орон нутагт чадварлаг боловсон хүчин татах, тогтооход нэлээн хүндрэлтэй байдаг. Тэгэхээр та бүхэн энэ зөвлөлд ажиллахдаа энэ орон нутгийн боловсон хүчнийг төрийн албаны яг ямар бодлогоор хандах, ямар өөрчлөлт хийж энэ боловсон хүчийг орон нутагт байлгахыг зорих вэ. Ялангуяа орон нутгийн урамшууллаас гадна нийгмийн асуудлыг яаж анхаарч ажиллах вэ гэдэг нь илүү мэдээлэл өгч, асуултад хариулна уу.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Нэр дэвшигч Золзаяа.

Л.Золзаяа: Гишүүний асуултад хариулъя. Орон нутагт бол хүний нөөцийн бодлого маш хүнд байгаа гэдгийг бол тантай санал нэг байна. Төрийн албаны зөвлөлийн хувьд бол төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт дээр орон нутгийн ажиллах хүний нөөцийн асуудал дээр бол тодорхой хэмжээний тэр шалгуур үзүүлэлтийг нь бууруулж, арай хөнгөвчлөх шаардлагатай юм байна гэж харсан. Орон нутагт ажиллах төрийн албан хаагчийн хувьд бол цалин, нийгмийн баталгааны асуудлыг бол дэмжлэгээр шийдвэрлэх шаардлагатай. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдсон тохиолдолд бол орон нутгийн өөртөө удирдах байгууллагын албаны хүмүүстэй уулзаж, нэг бүрчлэн уулзаж ямар асуудлууд байна, шийдвэрлэх шаардлагатай ямар асуудал байна, хамтарч шийдэх ямар шийдлүүд байна гэдэг талаас нь бол анхаарч ажиллах болно гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс.

Ц.Амартөгс: Орон нутагт байгаа тулгамдсан асуудлуудын нэг бол очиж ажиллах хүнгүй болж байна гэдэг энэ асуудал байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бид бас өнгөрсөн 2, 3 дугаар сард сум болгоноор очиж Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагын төлөөллүүд ажилласан. Энэ хүрээндээ эхний алхмуудыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтарч авч эхэлж байна. Мэргэжлийн хязгаарлалт үүсдэг. Тийм учраас энэ сонгон шалгаруулалтад оролцох хүн байхгүй байна гэдэг дээр нийтлэг хэрэгжүүлдэг чиг үүргийнх нь хүрээнд албан тушаалын тодорхойлолтуудыг мэргэжлийн өргөтгөсөн хүрээгээр шинэчлэн баталж, нийтлэг байдлаар мөрдүүлэхээр өөрчлөлт хийж шийдвэр гаргасан. Мөн анх орж байгаа буюу дэс түшмэлийн албан тушаалд орж байгаа иргэдэд бол ямар нэгэн мэргэжлийн болон ажлын туршлага заахгүй байгаа.

Дараагийн асуудал бол анхан шатад байгаа байгууллагуудад ажиллаж байгаа албан хаагчдын хоорондоо ялгаатай байдал үүсээд, цалингийн болон зэрэглэлийн ялгаа үүсэж байгаа гэдэг энэ асуудлыг бол бид судалж шийдвэрлэх ёстой гэсэн энэ байр суурьтай тодорхойлсон.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Гүйцээж хариулъя.

Ц.Амартөгс: Яалт ч үгүй анхан шатанд ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудал, орон сууцын асуудал 70 гаруй хувь нь бол орон сууцын асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой. Шилжиж очиж ажиллахад орон сууцын асуудал байхгүй

байна гэдэг асуудал тавьж байна. Тэгэхээр бид бол энэ анхан шатанд, сумд ажиллаж байгаа албан хаагчдын орон сууцын асуудлыг шийдвэрлэх, мөн гэр бүлд ээлтэй гэдэг юм уу, уян хатан ямар чиг үүргийг хэрэгжүүлж болох юм, ачааллыг нь яаж тэнцвэржүүлэх вэ гэдэг агуулгуудаар шийдвэр гаргаж хэрэгжүүлснээр ямар ч байсан энэ орон нутгийн асуудлыг шийдвэрлэх одоогийн нөхцөлийг өөрчлөх ийм боломж үүснэ.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ингээд өнөөдөр бид Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох гэж байна. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн гэдэг бол Улсын Их Хурлын гишүүнээс илүү удаан, бүрэн эрхийн хугацаатай, 6 жилийн бүрэн эрхийн хугацаатай. Тэгэхээр та 3 нэр дэвшигчийн хувьд бол маш хариуцлагатай ажил руу очиж байгаа гэж бодож байна.

Төрийн албанд тулгамдаад байгаа асуудал өнөөдөр манай нийгмийн ер нь эхний 3-д орох асуудлууд гэж би хувьдаа хардаг юм. Ер нь эдийн засгийн бас нэг үзүүлэлт нь хүмүүс хувийн хэвшлээс гараад хэтэрхий их төрийн алба руу зүтгэнэ гэдэг бол эдийн засаг суларч байна гэсэн үг. Төрийн албанаас гараад магадгүй хувийн хэвшил рүү илүү зүтгэж байна гэдэг тэнд илүү цалин хангамж өндөр байна гэдэг эргээд бид баялаг бүтээгчдээ дэмждэг. Төрийн албан хаагчид бид бол баялаг бүтээдэггүй учир энэ нийгмийнхээ балансыг маш сайн бодоорой. Нэг бодлын зарим хүмүүс бүр энэ Төрийн албаны тухай хуулийг бараг татан буулгах ёстой ч гэж ярьдаг хүмүүс байдаг. Хөдөлмөрийн тухай хууль байхад яагаад давхар ийм кастын систем шиг юм үүсгэдэг юм бэ. Уг нь төрийн албан хаагчдын эрхийг хязгаарлах ёстой байтал давхар бараг шинэ ангилал. Нийгмийн баталгаа нь илүү байдаг, хангамж нь илүү байдаг. Ингээд бүх талаар илүү болчихдог гэдэг энэ зүйлийг хэлдэг.

Сонгуулийн үеэр би нэг сурталчилгааны видео цацсан. Тэр дээр нэлээд их дагуулж ярьдаг тооно гэдэг үгийг их ярьдаг. Тэрний хамгийн гол агуулга, тэр сурталчилгааны гол агуулга нь юу байсан бэ гэхээр хаалга түгжээтэй байна гэж байгаа юм. Залуучуудад боломж тэгш биш байна. Ер нь хэн танилтай нь л илүү байдаг ийм систем болох гээд байна. Энэ ялангуяа Төрийн албаны зөвлөлд байгаа. Хэрвээ та 3 томилогдвол та 3 аливаа 1 гишүүний, аливаа 1 даргын томилгоо биш Монгол Улсын Их Хурал та 3-ыг томилсон шүү гэдгийг ямагт санах ёстой. Аймаг, орон нутагт ялангуяа энэ хэрээс хэтэрсэн. Би Ховд аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа залуу хүн орж ирээд ээж, аав нь, эмээ, өвөө нь миний хүүхдийг ажилд оруулж өгөөч гэдэг ийм юмыг харах болгондоо бүр сэтгэл өвдөж харамсдаг байсан. Би гадаадад олон жил ажиллахдаа ямар ч хүн рүү ярилгүйгээр, ямар ч хүнээс гуйлгүйгээр өөрийн анкетаа бариад, ярилцлагаа өгөөд, шалгалтаа өгөөд ингээд л бүх ОУБ-д, Дэлхийн банк, НҮБ энэ бүх байгууллагуудад ингэж ажиллаж байсан. Энэ шударга нийгмийг л залуучууд хүсээд байгаа юм шүү. Тэгэхээр энэ бүгд ерөөсөө та бүхнээс хамгийн дээрээс нь эхэлнэ. Дэлхийн банкны судалгаагаар манай төрийн албанд тулгамдаад байгаа хамгийн том 3 асуудлын 1 нь энэ клиентелизм гээд байгаа. Ерөөсөө улс төрийн нөлөөнд автсан. Тэгэхээр ямар нэгэн улс төрч энэ 126 Улсын Их Хурлын гишүүн та бүхэн рүү энэ хүнийг, тэр хүнийг гэдэг юм ярих юм бол битгий утсаа аваарай. Битгий утсаа ав. Та бүхэнд их шаардлагагүй. Монгол Улсын Их Хурал та бүхнийг томилсон шүү гэдэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Батжаргал: Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэдээ амжилт хүсье. Хэдийгээр 310 мянган төрийн албан хаагч байгаад байгаа гэж ярих боловч яг нарийндаа Төрийн албаны зөвлөлийн тогтож ажиллах ёстой бүтэц нь түрүүний яриад байгаа тэр 83 мянган хүн чинь л байгаад байгаа шүү дээ. Улс төрийн албан тушаалтан 3400 орчим байх шиг байна. Төрийн жинхэнэ албан хаагчид 20 хэдэн мянга байх шиг байна. Цаана нь төрийн тусгай алба 49 мянга байна. Тэгэхээр энэ дээрээ л илүүтэй тогтож ажиллах ёстой. Би тэгээд энэ том бүтцийг зөв явуулах тал дээр Төрийн албаны зөвлөл өөрөө бас нэлээн санаачилгатай ажиллах ёстой юм. Би уг нь Төрийн албаны зөвлөлийн даргыг ирчихвэл хэд хэдэн зүйл тодруулъя гэж бодож байсан юм. Гэтэл шинээр нэр дэвшигчдээсээ асуух асуулттай дэгийн зохицуулалттай учраас боломж үүссэнгүй гэж.

Сая Төрийн албаны зөвлөлөөс бүх орон нутгуудад ажиллаж, Төрийн албаныхаа хуулийн хэрэгжилт, бодит байдал юмаа дүр зургийг нь харсан. Тэрүүгээр юу өгүүлэгдсэн юм гэдэг асуудал байгаа юм. Тэрийг яаж шийдлийг нь зөв олох юм гэдэг л асуудал байгаа. Тийм учраас Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдож очоод, тэр тайлан юмнуудыг үзээд, төрийн албаны өмнө тулгамдчихаад байгаа асуудлуудыг эрх зүйн хувьд нь ч тэр, бодлого чиглэлийнх нь хувьд ч тэр сайжруулах тал дээр нэлээн зүтгэл гаргаж ажиллаарай гэдгийг би зориуд хэлчихмээр байна.

2 дахь зүйл. Төрийн алба дээр дан дамаа энэ ерөнхий мэргэжилтний чиг үүрэг гүйцэтгэх ёстой хүмүүсийг төрийн жинхэнэ албаны ангилал руу оруулж ирээд, шалгалт аваад байгаа нь өөрөө хүндрэлийг бий болгоод байгаа юм. Энэ бол яг нарийндаа төрийн байгууллагуудын зохиомол хүндрэл бий болгоод байгаа үйл явц байхгүй юу. Тэр байгаль орчныг хамгаалах чиглэлээр тэр тусгай хамгаалалттай газар нутаг гэдэг юм уу, ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс заавал төрийн жинхэнэ албан хаагч байх ер нь ямар албатай юм. Мал эмнэлгийн хүмүүс яахаараа заавал төрийн жинхэнэ албан хаагч байх ёстой юм. Харин жинхэнэ төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч 2-ын ангилал өөрчлөгдөхөд нийгмийн баталгаа нь дорддоггүй л байх ёстой. Энэ талаасаа л асуудлуудаа харах ёстой. Ийм эрх зүйн зохицуулалт судалгаа юмнууд дээр нэлээн санаачилга гаргаж ажилламаар байна гэдгийг би зориуд хэлчихмээр байна.

Дараагийн нэг зүйл. Босоо, хэвтээ томилгооны тухай яриад байдаг юм. Бид мөнхийн хэрэлддэг хүмүүс. Энэ дан дамаа нийгмийн салбаруудын удирдах бүрэлдэхүүнийг зарим хэсэг нь хэвтээгээр томилох ёстой, зарим .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Золзаяа хариулт өгье.

Л.Золзаяа: Энэ оны хувьд Төрийн албаны зөвлөлөөс бүх 21 аймаг, 300 гаруй сумдад бол ажиллаж ажилласан байна. Тэгээд бүсийн зөвлөгөөнүүдийг бас хийсэн байна. Энэ дээр бас орон нутагт тулгарч байгаа Төрийн албаны хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийн асуудлуудыг бол газар дээр нь судалж, тэр газар дээр ажиллаж байгаа хүмүүсийнхээ санал бодлыг судалж ажилласан байна. Тэгээд үүнээс энэ бүсийн зөвлөгөөнүүд, орон нутагт томилогдож ажилласан тайлангууд дээрээ дүгнэлт хийгээд, ажлын тайлан гаргаж, Улсын Их Хуралд харьяа байгууллагадаа танилцуулах ёстой байх гэж бодож байна.

Орон нутагт ажиллах төрийн албан хаагчид тавигдаж байгаа шаардлагыг бол тодорхой хэмжээгээр зөөлрүүлэх шаардлагатай гэдэг дээр бол тантай санал нэг

байна. Учир нь бол орон нутагт хүний нөөцийн асуудал маш хүндээр тавигдсан. Хүнд болсон байгаа. Ажлын байр дээр нь хуулийн шаардлагыг нь хангадаг хүн олдохгүй байгаа гэдэг асуудлууд бол яригддаг. Тийм учраас энэ тодорхой хэмжээгээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс.

Ц.Амартөгс: Чиг үүргийн уялдаа, салбарын хуулиудын зохицуулалтууд ялгаатай байдлаар батлагдах, мөн хэрэгжихдээ орж байгаа асуудлаас болоод төрийн ерөнхий мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай ажил, албан тушаалууд төрийн захиргааны шаардлага тавигддаг ажил, албан тушаалын ангилалд орсон байгаа асуудлыг бол шийдвэрлэх шаардлагатай гэдэг 1 дүгээр асуудал.

2 дугаарт нь төрийн удирдлагын нэгдсэн системийг бэхжүүлэх, ялангуяа сумд байгаа босоо томилгоотой буюу мэргэжлийн удирдлагаар хангагддаг байгууллагуудыг иргэнд үйлчилдэг иргэний үйлчилгээ хүртээмжийг сайжруулах чиглэлээр орон нутгийн удирдлагатай нийцүүлэх шаардлагатай. Ажил ачааллын асуудлууд байгаа. Олон салбарын хуулиуд гарч байгаагаас болоод анхан шат дээр ялангуяа тайлан мэдээлэл өгөх, системд мэдээлэл оруулах гэх мэт техник ажиллагаа ихсэж байна гэдэг энэ асуудлууд орон нутагт бас яригдсан байгаа. Тэгэхээр бид энэ ачаалал, хиймэл зүйлүүдийг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Төгсцэнгэл.

Б.Төгсцэнгэл: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлөөс 6 бүс, Улаанбаатар хотыг оруулаад 7 бүс, 330 сумд төрийн албаны хуулийн хэрэгжилт хэр байгаа, төрийн албанд тулгамдаж байгаа асуудал юу байна гэдэг асуудлаар бүсчилсэн сургалт яваад, төрийн албан хаагчдынхаа санал юуг сонсоод, тулгамдаж байгаа асуудлыг Улсын Их Хурлын түвшинд ямар асуудлууд байна, Засгийн газрын түвшинд ямар асуудал байна гэдгийг бол гаргаж ирээд Төрийн албаны хуулийн ажлын хэрэгжилтийг санал, дүгнэлт гаргах ажлын хэсэгт танилцуулсан. Ер нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон Сонгуулийн тухай хуульд төрийн албан хаагч нь улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх, нам эвслийн ашиг сонирхлоос ангид байж мэргэшсэн, тогтвортой, шударга төрийн албыг бий болгох зорилтуудыг бол тодорхой тусгасан. Гэвч төрийн албан хаагчид улс төрийн үйл ажиллагаанд оролцож, зарим талаараа дэмжиж, сонгуулийн сурталчилгаа хийх, намын ажилд оролцоотой байгаа асуудал нь бол нууц биш/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя. Үг хэлье. Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Шинэ томилогдох гэж байгаа хүмүүс ярьж байгаа юмнуудаа яг л ажил болгох талаас нь анхаармаар байгаа юм. Бид чинь нэг юм яваад үзэж хараад, хяналт үнэлгээ хийчхээд, тэрний дүгнэлт, тэрүүгээр үгүйлэгдэж байгаа зүйлүүдийг зөв болгох тал дээр дэндүү удчихаад байх юм. Тийм учраас энэ тал руугаа нэлээн сайн анхаар гэж.

2 дугаарт тэр томилгооны хэвтээ, босгоогийн асуудал голдоо биш. Харилцан хяналт тэнцлийнх нь асуудлыг л шийдэж өгөх ёстой бид. Орон нутаг ямар үүрэг,

хариуцлагатай оролцох ёстой юм. Мэргэжлийн удирдлага нь ямар үүрэг оролцоотой оролцох ёстой юм гэдэг энэ тэнцлийг хийж өгөх юм бол энэ томилгооны асуудал хэнд байхдаа гол зүйл биш байхгүй юу. Үйлчилгээ нь л чухал. Үүнийг нэг нэлээн сайн онцгой анхаармаар байна.

Дараагийн нэг зүйл танай дээр байгаа мэдээллийн сан их бодитой баймаар байна. Тэгээд зарим тохиолдолд танай эрх мэдлийг зарим газар аваад явчих юм. АТГ төрийн албаны шаардлага .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Яг одоогоос 3 жилийн өмнө ТАЗ-ийнхэнтэй бас төрийн албаны асуудлаар үг хэлж байсан юм байгаа юм. Тухайн үед энэ төрийн албаны алба хаагчийн нэр төр, энийг хамгаалах тал дээр ер нь Төрийн албаны зөвлөл бас жоохон ажилладаг байхгүй бол дээрээс нь дарга нь дарамталдаг, ард иргэд нь янз бүрээр хэлдэг, энэ нь эргээд төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллахаас авхуулаад олон зүйл байна. 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ цалин хангамжийн асуудлыг хөндөж байсан. Тэгээд энэ цалин хангамжийн асуудал бол бас тухайн үед ярьж байсныг бодвол бас өнөөдөр харьцангуй нэмэгдсэн. Тэр үед бол сумын Тамгын газрын мэргэжилтэн залуу 450000-ыг гар дээрээ авч байсан бол одоо бас ч гэж 1 сая 200-аад мянган төгрөг гар дээрээ авч байгаа. Ахиц дэвшил байгаа. Үүний үр дүнд сумын Тамгын газрын 17, 18 хүний тал нь шахуу байхгүй байдаг байсан бол одоо бас ч гэж 80 хувьтай, 90 хувьтай бүрддэг болоод ингээд ахиц дэвшил бас байгаа.

3-д нь би юу ярьж байсан гэхээр төрийн албаны энэ тоог 220 мянган төрийн албан хаагч байна. Данхайлаа л гэж яриад байдаг. Яг энэ дотроо ингээд ангилаад, ялгаад үзэх юм бол нөгөө боловсролд нь багш хүрэлцэхгүй, эрүүл мэндэд нь сувилагч хүрэлцэхгүй. Одоо ноднин энэ төсөв батлахад цагдаа тусгай байгууллагад нь бас орон тоо дутуу гээд ингээд байгаад байдаг. Иргэдэд ойлгуулахдаа бол ердөө 220 мянган том дарга байна. Бид нарын мөнгөөр эд нар л тэжээгдэж байна гэдэг ийм мессеж яваад байна шүү. Ийм ойлголтыг өгөөд байна шүү. Та нар энэ ангилал, ялгаа юмнуудаа бас ялгаж салгаж үзээч ээ. Тэгэхээр ингээд яг нарийн ухаад үзэх юм бол 220 мянган төрийн албан хаагчийн 21 мянга нь л төрийн захиргааны албан хаагч гэж ийм л байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ч гэсэн Төрийн албаны зөвлөл бол бас жоохон энэ албаныхаа эрх ашгийн төлөө бас дуугардаг байхгүй бол одоо та нарыг юу гэж харж байна вэ гэхээр ердөө яам сайд нарын өмнө бол та нар хонь. Тэгээд 1 аймаг, сумд очихоороо ердөө тонгорог. Бүгдийг нь ердөө сэлэмдчих гээд л. Сая Хэнтий аймагт та нар зөвлөгөө хийсэн л гэж байна. Төрийн албаны зөвлөлийн хүн нь төрийн албан хаагчийг дуудаж ирээд л улс төржсөн юм ярьж байгаад, тэгээд өөрөө загнуулаад гарсан байна лээ л дээ. Тэр нөхөр өөрөө уучлалт гуйгаад. Тэгэхээр бүхэл бүтэн яам ингээд нүдэн дээр нь баахан үүрэг гүйцэтгэгч болоод ингээд ирэхээр Төрийн албаны зөвлөл нь дуугай л байж байдаг. Тэгэхээр чинь наадхыг чинь Төрийн албаны зөвлөлийн нэр хүнд гэдэг юм чинь бас давхар байхгүй болох гээд байна шүү гэж би хэлэх гээд байгаа юм. Тэр яаманд нь ч тонгорог бай, энэ төрийн албандаа бүгдэд нь л тэгш үйлчилдэг баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол ийм л зүйл хэлмээр байгаа юм. Одоо сүүлдээ ингээд төрийн албаныхан дээр яаж байна вэ гэхээр 36 сарыг нь байхгүй болгоно гэнэ. Хэдэн 10 мянгаар нь цомхотгоно л гэнэ. Томилолтгүй болгоно л гэнэ. Үгүй ээ, тэгээд эд нар чинь яаж ажиллах юм бэ. Сумын багш .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Золзаяа нэр дэвшигч 1 минут.

Л.Золзаяа: Төрийн албаны нэр хүндийг хамгаалах, шударга ажиллаж байгаа төрийн албан хаагчийг дэмжих, хамгаалах асуудал дээр бол би түрүүн бас хариулсан. Энэ бол чухал шаардлагатай асуудал гэдэг дээр бол би тантай санал нэг байна. Төрийн албаны нэр хүндийг хамгаалах ёстой. Шударга ажиллаж байгаа төрийн албан хаагчийг хамгаалах, дэмжих ёстой. Түрүүний бас хэлсэн үгээ хэлэхэд төрийн албыг хэт сулруулах нь үндэсний аюулгүй байдалд бол сөргөөр нөлөөлнө гэж боддог. Энэ бодлоо хэлье.

Тэгээд төрийн алба 2024 оны байдлаар 226 мянган төрийн албан хаагч байгаа гээд түрүүн статистик тоонууд хэлсэн. Энэ Төрийн албаны зөвлөлд битгий ялгавартай хандаарай гэдэг дээр бол би хуулиа мөрдөж, хуульд юу гэж заасан байна тэгш, хараат бусаар бусдын нөлөөнд автахгүйгээр шийдвэр гаргаж, хуулийг биелүүлэх чиглэлээр бол анхаарч ажиллах болно гэдгээ хэлье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс.

Ц.Амартөгс: Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллаж байгаа албан хаагчдын нэр хүндийг хамгаалах, хариуцлагагүй байгаа үйл ажиллагааг илрүүлж засах залруулах энэ үйл ажил явц бол хуулийнхаа хүрээнд процесс сайжирч, ажиллах ёстой. Үүний бас нэг тулгуур гэдэг юм уу төрийн албаны шинэтгэлийн хүрээнд бий болсон систем маань Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль байгаа. Аливаа хандлага, буруу хандлага, хойрго байдал энэ зүйлүүдийг өөрөө илрүүлдэг механизм болж бүрэлдэн тогтоно гэж бид харж байгаа. Ингэхээр хуулийн систем, гүйцэтгэлийн үнэлгээний механизм, ёс зүйн хариуцлага бүгд нийлээд энэ маань бол зөв ажиллаж байгааг нь хамгаалдаг, буруу ажиллаж байгааг нь бол хариуцлага ноо ноогдуулдаг ийм систем болж ажиллаж байгаа гэдгийг бол хэлье.

Сул орон тоо дутуу байгаа албан хаагчдын хувьд бол чиг үүргийг дахиж хуваарилах давхардсан үүргийг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Төгсцэнгэл.

Б.Төгсцэнгэл: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах эрхтэй гэж заасан байдаг. Түүнчлэн “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогод төрийн бүтээмжийн зорилтуудтай уялдуулсан төрийн албаны шинэчлэлийн асуудлыг тусгасны дагуу шинэтгэл эдийн засгийн агуулгаар бол өргөжиж байгаа. Засгийн газраас 2023 оноос бол төрийн албан хаагчийн цалин хөлсний бүтэц, цалингийн тогтолцооны шинэчлэлийг бол үе шаттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд Засгийн газрын 2024-2028-ны оны үйл ажиллагааны хөтөлбөрт бол Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг бол жил бүр нэмэгдүүлнэ гэж тусгасан зорилтынхоо хүрээнд бол төрийн албан хаагчдын үндсэн цалинг бол инфляцтай уялдуулан 2025 оны 1 сарын 1-ээс эхлэн 6 хувиар нэмэгдүүлээд ажиллаж байна. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн асуулт асууж, үг хэлье.

Б.Хэрлэн: Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчийг бол ерөнхийд нь дэмжиж байна. Өнөөдөр төрийн албаны хуулийн шинэчлэлийн тухай яригдаж байгаа энэ цаг үед ялангуяа бас ажлын дадлага туршлагатай, шинэ үзэл бодол, шинэ хандлагатай, юм хийе гэсэн санаа бодолтой 2 шинэ гишүүн орж ирж байгаад бол бас их талархаж хүлээж авч байна. Тэгэхээр надад төрийн албаны бүтээмжтэй холбоотой, ялангуяа төрийн албаны бүтээмжид нөлөөлж байгаа төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай холбоотой 2 асуулт байгаад байгаа юм.

Өнөөдөр ингээд Үндэсний аудитын тайлан бас Төрийн албаны зөвлөлийн тайланг ингээд харахад бол 2024 оны байдлаар гэхэд нийт төрийн албан хаагчдын 18,3 хувь нь ажлаасаа халагдсан, солигдсон байгаад байгаа юм. Энэ бол маш өндөр тоо. Тэгэхээр төрийн байгууллагын үйл ажиллагааг алдагдуулна. Нөгөө шинэ хүнийг чинь сургана, ажилтан дадлагажуулна гээд ингээд бас цаг хугацаа, хөрөнгө яваад байдаг ийм талтай. Тэгээд одоо ингээд харахад бол ердөөсөө 5 хүний 2 нь төрийн албанд 0-5 жил ажиллаж байгаа хүмүүс байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь бол 2023 онд төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмсэн, нийгмийн баталгааг бас шийдвэрлэх олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд бол өмнө нь 23 хувь нь халагддаг, солигддог байсан нь одоо 18 болоод 5 хувиар буураад байна л даа. Тэгэхээр энэ цалин хөлснөөс гадна бас энэ халагдаж солигдоход хүргээд байгаа өөр цаана нь суурь шалтгаанууд байгаад байна уу. Энэ дээр та бүхэн юу гэж боддог юм бэ гэж асуумаар байна.

2 дугаарт нь 2017 онд батлагдсан Төрийн албаны хуульд мерит зарчим гээд тунхаглаад оруулаад ирсэн. Тэгэхээр энэ мерит зарчим маань төрийн албаны гүйцэтгэх, удирдах албан тушаалд дэвшин ажиллахад төрийн албанд ажилласан байх хугацааны шаардлагуудыг тавиад эхэлчихдэг. Хэрвээ төрийн албанд ингээд байнга халагдаад, солигдоод байдаг байх юм бол тэр хугацааны шаардлагыг хангаж гүйцэтгэх, удирдах албан тушаалд ажиллах хүмүүсийн чинь нөгөө сонгон шалгаруулах нөөц сан чинь улам хумигдаад байна л гэсэн үг. 2024 онд төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд тухайлах юм бол 20762 хүний сонгон шалгаруулалт зарласан байна лээ. Тэгээд үүний дөнгөж 50 хувь нь хангагдсан байгаад байгаа байхгүй юу. 50 хувь нь нөхөгдөөгүй үлдчихсэн. Тэгэхээр ингээд ийм их хатуу ийм системийг бий болгоод гаднаас хүн орох арга байхгүй хаалттай системийг бий болгочхоод, тэгээд дээр нь төрийн алба нь өөрөө ингээд тогтвор суурьшилтай ажиллах арга байхгүй болоод ирэхээр чинь цаашдаа орон тоо нөхөх ийм боломжгүй болох гээд байна. Тэгэхээр одоо энэ Төрийн албаны хуулийг шинэчлэх гэж байгаа энэ үед энэ асуудлыг ер нь яаж шийдье гэж та бүхэн бодож байгаа вэ. Энэ дээр ямар санаа оноотой байна вэ гэж би тодруулъя.

Д.Амарбаясгалан: Золзаяа нэр дэвшигч хариулт өгье.

Л.Золзаяа: Төрийн албанд хийсэн Үндэсний аудитын газрын тайлан дээр бол нийт төрийн албан хаагчийн 18 хувь нь ямар нэгэн байдлаар шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна гэж та хэллээ. Энэ дээр бол мэдээж сонгуулийн циклтэй холбоотой төрийн албаны шилжилт хөдөлгөөнүүд бол нэмэгдсэн байгаа.

2 дугаарт энэ бүтцийн өөрчлөлт нэрээр бас халаа сэлгээ хийгддэг асуудлууд бол байдаг. Энэ шилжилт хөдөлгөөнийг хэрхэн багасгах вэ яаж төрийн албанд хүмүүсийг тогтвор суурьшилтай ажиллуулах вэ гэдэг дээр миний хувийн бодол бол энэ шатлан дэвжих арга хэрэгслийг бол бид нар сайтар дэмжиж ажиллах

шаардлагатай гэж харж байгаа юм. Тухайн 1 хүн төрийн албанд ажиллаад 3, 4 жилийн дараа би ийм байр суурьд хүрнэ гэдэг нь тодорхой байх ёстой. Энэ тодорхой бус байдлаас хамаараад төрийн албанаас гарах гэдэг юм уу тийм сэдлийг бол төрүүлдэг байж магадгүй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Төгсцэнгэл хариулт өгье.

Б.Төгсцэнгэл: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны тухай хуулийг 1994 онд анх баталж, түүнийг 2002 болон 2017 онд 2 удаа шинэчлэн найруулсан. Төрийн албаны тухай хуулийн сүүлийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 12 сарын 7-ны өдөр батлаад, 2019 оны 1 сарын 1-ээс эхэлж дагаж бүрдэж эхэлснээс хойш уг хуульд 28 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ орсон 28 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн 22 хувь нь буюу 79 нь хуулийг дагалдуулж оруулсан өөрчлөлт байх бөгөөд үлдсэн 6 удаагийн өөрчлөлт нь бол төрийн албан тушаалын ангилал, төрийн албан хаагчид тавих нийтлэг болон тусгай шаардлагууд, төрийн албан хаагчийн цалин хөлс, урамшуулалтай холбогдсон заалтууд бол орсон. Төрийн албаны хууль тогтоомжид зааснаар бол эрх бүхий албан тушаалтан бол 55 захиргааны актыг бол батлахаар хуульчилсан. Төрийн албаны хувьд нийт төрийн жинхэнэ холбоотой 142 заалт, төрийн үйлчилгээний албатай холбоотой 11 заалт дагаж мөрдөгдөж байна. Тэгээд төрийн албаны тухай .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Заяабал: Өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн гишүүдээр 3 нэр дэвшигч маань орж ирж байна. Юуны өмнө бас дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Тэгэхээр Монгол Улсын төрийн албаны үндсэн зорилго бол төрийн албаны шинэтгэл, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй ийм байгууллага. 1994 оноос хойш эхлэлтэй Монгол Улсад үүсэж бий болсон байгууллага. Энэ жил бол 21 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулаад, хөгжиж дэвшээд явж байгаа ийм байгууллага. 2019 онд төрийн албаны хуульд томоохон шинэчлэлийн өөрчлөлт орсноор Төрийн албаны зөвлөл бас бүрэн хараат ажиллах ийм нөхцөл боломж бүрдсэн гэж ингэж үздэг. Төрийн албаны зөвлөлийг хараат ажиллах энэ нөхцөл бүрдсэнээр эргээд төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдыг ч гэсэн хараат бусаар ажиллах ийм нөхцөлийг бас хангах ёстой. Хангагдсан байх ёстой. Хууль нь маш хатуу байгаа. Өнөөдөр бас чуулганы танхимд зарим энэ төрийн албанд томилогдож байгаа хүмүүс бас намын харьяаллаар томилогдож байгаа тухай бас асуудлууд яригдаж байна. Би бол энийг үгүй байх гэж бодож байгаа. Ер нь төрийн албанд ажилласнаараа улс төрийн эрх мэдлээс маш их хэмжээгээр хязгаарлагддаг шүү дээ. Фэйсбүүк олон нийтийн сүлжээнд явж байгаа улс төрийн өнгө аястай холбоотой асуудалд санал бодлоо илэрхийлж болохгүй, жагсаал цуглаанд очиж болохгүй. Хэрвээ улс төрийн албанд нэр дэвших, оролцох сонирхолтой бол 6 сарын өмнө ажлаа өгч чөлөөлөгддөг. Ийм байдлаар төрийн захиргааны албан хаагчид бол үндсэндээ улс төрөөс бол маш ангид үйл ажиллагаа явуулж, хараат бусаар ингэж явдаг байгаа. Тэгэхээр энэ дээр тухайлбал нэр дэвшихтэй холбоотой асуудал дээр 6 сарын өмнө ажлаа өгдөг энэ асуудал дээр би эсрэг байр суурьтай байдаг гэдгийг бас илэрхийлж хэлье.

Ёс зүйн асуудлууд нэлээдгүй яригдаж байна. Энийг Төрийн албаны зөвлөл өөрөө ёс зүйн асуудлаа хэр мөрдөж байгаа юм бэ гэдгээс эхлэх ёстой шүү гэдгийг би бас энэ дээр хатуу хэлье. Цаг бага байгаа учраас.

Өнөөдөр ингээд үүнтэй холбоотой хэд хэдэн асуудлууд асууя даа.

1 дүгээрт нь энэ төрийн албыг хөдөлмөрийн зах зээлд хамгийн муу оролцогч гэдгийг та бүхэн зөвшөөрч байна уу.

2 дугаарт нь төрийн албанд ажиллаж байгаа энэ албан хаагчид ядуурлын түвшинд яг нийт хэдэн хувь нь ядуурлын түвшинд ажиллаж амьдарч байгаа юм бэ. Төрийн нийт албан хаагч чинь.

3 дугаарт нь энэ албан байгууллага болгонд нийгмийн баталгааны хөтөлбөр гээд хэрэгждэг. Энэ хөтөлбөр ер нь хэр зэрэг хэрэгжилттэй байна. Өнөөдөр нийтийн орон сууцад амьдарч байгаа төрийн албан хаагчид хэд байна. Гэр хороолол, орон сууцад амьдарч байгаа нь хэд байна. 30 сая төгрөгөөс доош зээлтэй хэчнээн төрийн албан хаагчид байна гэдэг дээр холбоотой та бүхэн бас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Золзаяа хариулт өгье. 1 минут.

Л.Золзаяа: Маш тодорхой асуултууд асуулаа. Тэгээд ядуурлын түвшин нь хэд байна. Гэр хороололд ажил амьдардаг төрийн албан хаагч хэд байна гээд. Энэ асуудал дээр бол би Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилогдсон тохиолдолд судлаад танд дэлгэрэнгүй хариулт өгөх боломжтой гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс хариулт өгье.

Ц.Амартөгс: Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Гэхдээ өнөөдөр нийт байгууллагууд энэ хөтөлбөрөө ялгаатай баталдаг. Баталдаг ч гэсэн хэрэгжилт нь хангалтгүй байна гэсэн ийм дүгнэлт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд бол нэгтгэгдсэн байгаа. Энэ дээр юуг анхаарах вэ гэхээр эх үүсвэр баталгаа, тэгээд ямар баталгааг яг бүрэн хангах ёстой вэ гэдэг дээр хуулийн зохицуулалтыг тодорхой заах ёстой юм байна. Тэгж байж санхүүжилтийн эх үүсвэртэйгээр баталгааг нь хангах хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ гэсэн энэ асуудлууд яригдаж байгаа. Нийт төрийн албаны ажиллагчдын 69 хувь нь ойролцоогоор орон сууцын нөхцөл тааруу байна гэж нийгмийн баталгаа, орон сууцыг сайжруулахад зээлд хамрагдах, хамрагдсан болон хамрагдъя гэсэн ийм хүсэлттэй байгаа талаарх судалгаанууд байгаа. Ядуурлын түвшний хувьд яг тодорхой мэдээллийг тодруулж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Төгсцэнгэл хариулт өгье.

Б.Төгсцэнгэл: Гишүүний асуултад хариулъя. Таны асуусан төрийн албан хаагчдын нэр хүнд, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлын талаар та асуудлуудыг хөндөж байна. Энэ асуудлууд дээр би тантай санал нэг байна. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчдын ажиллах, нөхцөл нийгмийн баталгааны асуудлыг бол шийдвэрлэсэн байдаг. Үндэсний аудитын газрын төрийн албаны хүний нөөцийн бодлогод хийсэн үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн албаны хууль тогтоомжид хийсэн хэрэгжилтийн үнэлгээнүүдийг үзэж судалсан. Энэ дээр ерөөсөө нийгмийн баталгааны асуудлуудыг төрийн албанд бол харилцан адилгүй хэрэгжүүлж байна гэсэн дүгнэлт гарсан байгаа. Энэ дээр тухайлах юм бол яам

агентлагийн хувьд бол 4 яам нийгмийн баталгааны хөтөлбөрөө баталсан. Орон нутагт 3 аймаг нийгмийн баталгааны хөтөлбөрөө .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр сонгогдож байгаа эрхмүүд та бүхэн энэ Төрийн албаны зөвлөл өнгөрсөн хугацаанд дандаа энэ томилгоо дээрээ анхаарч ирсэн шүү. Томилгоо дээрээ л их анхаарч томилгоогоо тойроод л яриад байдаг. Томилгоо дээрээ л нэлээдгүй анхаараад яваад байдаг. Гэтэл цаана нь нийгмийн асуудлын асуудал нь орхигдчихсон байгаа. Энэ дээрээ та бүхэн бас онцгой анхаарч ажиллаарай гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт нь энэ төрийн албанд томилгоо хийхдээ та бүхэн энэ төрийн тусгай албанд ажиллаж байсан албан хаагчдыг төрийн захиргаа руу хольж ажиллуулдаг дээр бас онцгой анхаараарай. Энэ чинь цаана нь байгууллагын соёл гэж асар том юм байгаа шүү дээ. Энэ байгууллагын соёл чинь алдагдаад байдаг ийм асуудал үүсдэг. Тийм учраас та бүхэн энэ томилгоо дээрээ энийг бас онцгой анхаарч өгөөрэй гэдгийг бас та бүхэнд захиж хэлж байна.

Мөн түүнчлэн өчигдөр бас агентлагуудыг нэгтгэн 59 Үндэсний хороог байхгүй болгоно. 14400 хүнийг албан тушаалаас цомхотгоно гэж байна. Эдгээр хүмүүс төрд ажилласанд тооцогдох уу гэдэг ийм эцсийн асуулт асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төлөөлж Амартөгс нэр дэвшигч хариулъя.

Ц.Амартөгс: Төрийн албаны тэр зөвлөл, хороодын 59 ажлын албыг татан буулгахтай холбоотой мэдээлэл байгаа. Энэ дээр төрийн албаны статусгүй буюу төрийн албаны ангилалд хамаарахгүй томилогдсон болон эрх зүйн байдалтай байгаа хүмүүсийн хувьд хөдөлмөрийн гэрээгээр харилцаа нь зохицуулагдсан учраас хөдөлмөрийн харилцааныхаа журмаар явна. Төрийн албаны агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын хувьд бол төрийн алба гэж тооцогдож байгаа.

Д.Амарбаясгалан: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр манай энэ төрийн албаны нэр хүнд маш муу байгаа. Тэр тусмаа бид бүхэн үнэхээр чадварлаг чадалтай ийм хүмүүсээ бол бас сонгон шалгаруулж авч чадахгүй байгаатай холбоотой. Мөн дээрээс нь төрийн албан хаагч нар маань ажил үүргээ гүйцэтгэхдээ авлига ашиг сонирхлын зөрчил маш их гаргадаг. Тэр ч үүднээсээ энэ хүмүүс нь амьдрал ахуй нь илт сайжраад, байр машин нь хүртэл ингээд эрс өөрчлөгддөг. Тэгэхээр энэ байдал дээр манай энэ Төрийн албаны зөвлөл ямар үнэлэлт дүгнэлт өгдөг юм. Ийм судалгаа тооцоо ер нь байдаг юм уу. Энэ тал дээр нэг бас хариулт авъя.

Дараагийн асуудал энэ хөдөө орон нутагт жишээ нь багш байхгүй, эмч байхгүй, сувилагч байхгүй, өрхийн эмч байхгүй гээд баахан орон тоонууд сул байж байдаг. Очдоггүй. Тэгэхээр үнэхээр манай энэ төрийн албаны төрийн албан хаагчийн хэрэгцээ шаардлага ер нь хэр байгаа юм. Орон нутагт асууж байна шүү дээ. Энэ дээр ямар бодлого баривал шаардлагатай юм. Ямар мэргэжилтэн боловсон хүчин дутагдалтай байгаа юм бэ гэдэг 2 дахь асуудал.

3 дахь асуудал бол манай энэ Төрийн албаны зөвлөл ажлын байрны тодорхойлолтыг тэр тусмаа тусгай шаардлагыг бол ингээд баталж явуулах ёстой байдаг юм. Гэтэл салбар зөвлөл рүүгээ өгчихдөг тэгээд салбар зөвлөл нь бол яг хүндээ тааруулсан ийм шаардлагуудыг буюу ажлын байрны тодорхойлолтыг батлаад байдаг. Яагаад ийм асуудлыг хийгээд байдаг юм бэ. Энэ дээр та бүхэн маань ямар санаа бодолтой байдаг вэ. Төрийн албаны зөвлөл ажлын байрны тодорхойлолтыг батлах ёстой.

4 дэх асуудал би нэг аймаг цохон хэлмээр байна л даа. Энэ Баянхонгор аймгийн салбар зөвлөл байгаа. Төрийн албаны салбар зөвлөлийн дарга бол Тамгын газрын дарга байдаг. Гэтэл энэ хүн нь өөрөө аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч байж байгаа юм. Тэгээд Төрийн албаны зөвлөл салбар зөвлөлөө удирдах ёстой. Жишээ нь энэ хэдхэн аймгийн чинь Төрийн албаны зөвлөл нь ийм хүн байна шүү дээ. Тэгэхээр яаж энэ төрийн албаны зөвлөлийн нэр хүнд, төрийн албан хаагчдын нэр хүнд яаж өсөх юм. Хууль чинь үүнээс гол зөрчилдөж байна шүү дээ. Баянхонгор аймагт гэхэд 5 хэлтсийн дарга нь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч байна шүү дээ. Энэ дээр бол Хяналт шинжилгээ үндэсний хорооноос бүр хяналт шалгалт явуулаад, албан шаардлага хүргүүлсэн байгаа. Тэгээд та 3 очоод яг энэ дээр яаж ажиллах юм гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Золзаяа хариулт өгье.

Л.Золзаяа: Эхний асуултад хариулъя. Сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой асуудлыг асуусан. Ёс зүйтэй холбоотой холбоотой асуудлыг асуулаа. Энэ дээр өнгөрсөн 2024 онд Төрийн албаны зөвлөл төрийн 400 гаруй байгууллагын 10 мянган албан хаагчийн томилгоотой холбоотой төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийсэн байна лээ. Эндээс 600 гаруй зөрчил илрүүлсэн байна. Энэ нь хуулийн зөрчилтэй байна гээд. Үүнээс 143 нь бол зөрчлөө арилгасан. 400 гаруй зөрчилд бол хугацаатай үүрэг өгчихсөн явж байгаа юм байна лээ.

Ёс зүйн хувьд бол Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдсан. Үүний дагуу иргэд болон төрийн албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 500 гаруй санал, гомдол ирснийг шалгаад, 322 дээр нь бол зөрчил тогтоогдсон байна. Тэгээд энэ зөрчил тогтоогдсон .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Л.Золзаяа: Зөрчил тогтоогдсон тохиолдлууд дээр бол тодорхой хариуцлагын арга хэмжээнүүдийг авч уучлалт гуйлгах, хамт олон болон ганцаарчлаад сануулах арга хэмжээ авах, төрийн албанаас халах, 13 тохиолдолд бол төрийн албан хаагч өөрөө хүсэлтээрээ төрийн албанаас чөлөөлөгдсөн ийм тоо статистик мэдээнүүд бол байна гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Амартөгс хариулт өгье.

Ц.Амартөгс: Албан тушаалын тодорхойлолт батлах болон сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор процессыг бид аль болох ил тод, нээлттэй, хүнээс үл хамаарсан байдлаар шийдвэрлэдэг байх ийм систем рүү оруулах замаар хаана, ямар өөрчлөлт хийгдсэн болон үндэслэл нь ямар хуульд нийцэж байгаа болон нийцэхгүй байна уу гэдгийг шалгадаг ийм процессыг тодорхой болгож байгаа. Тэгэхээр энэ систем бүрэн ажиллаад эхлэхээр

яг ямар албан тушаал дээр ямар, хэзээ, ямар өөрчлөлт орсон, хаана нь өөрчлөгдсөн бэ гэдэг энэ зүйлүүд ил тод мэдээлэгддэг болно.

Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон хүний хувьд төрийн албаны үйл ажиллагаа албан тушаалд томилогдохдоо аль нэгийг нь сонгох ёстой. Төрийн албаны хуулиар төрийн захиргааны албан тушаал эрхлэх тохиолдолд аливаа ямар нэгэн улс төрийн намын гишүүн байх ёсгүй. Тийм учраас энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллана.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Төгсцэнгэл хариулт өгье.

Б.Төгсцэнгэл: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 56 салбар зөвлөл. Тус салбар зөвлөлүүд 7-11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Хуульд заасан болзол, шалгуур, мэргэжил, ур чадварын шаардлагыг хангасан иргэн шударга өрсөлдөөний зарчмаар төрийн албанд ажиллах, улмаар шатлан дэвшихийг баримтлах гол баримт бичиг бол албан тушаалын тодорхойлолт байгаа. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална гэж, тухайн байгууллага чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд бол албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно гэж тус тус заасан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг бол баталж мөрдүүлж байна. Уг журмын 6 дугаар заалтад бол энэ журмын 4.1, 5.3. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг хойшлууллаа.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө.

14 цагт яг цагтаа үдээс хойших чуулганы хуралдаан эхэлнэ. 3 том хуулийн төсөл хэлэлцэх учраас гишүүдийг цагтаа ирэхийг хүсэж байна.

12.58 цаг.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Гишүүдийн өдрийн мэндийг эрье. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаа эхлүүлье.

“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Лувсанжамц: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хооронд ажиллаж, хот, суурин газрыг орон сууцжуулахад

ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал дүгнэлт гарган Эдийн засгийн байнгын хороонд танилцуулсан.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг болон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, уг тогтоолын төслийг 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг тогтоолын төслийн хүрээнд Монгол Улсыг 2026 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон Монгол Улсын 2026 оны улсын төсөвтэй уялдсан эсэх, ирэх жилийн улсын төсөвт хэрхэн тусгах талаар тооцоо судалгаа хийсэн эсэх, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар хийсэн дүгнэлт байгаа эсэх, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг тодорхой болгох, ногоон орон сууцын загвар стандартын талаар мэдээллийн сан бүрдүүлсэн эсэх, бэлтгэл ажлын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд тогтоолын төслийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор олгож байгаа холбогдох татаасыг дулаалгын бодлогод чиглүүлж, ногоон зээлийн хүүгийн татаасанд шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх, зээлийн хүүг 6 хувиас ихгүйгээр тогтоох, Монгол гэрийн дулаалгын нийт зардлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах гэсэн заалтуудын талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуучны орон сууцыг дулаалах асуудлыг нийслэлд хариуцуулан иргэд нь хариуцлагатай хамтран ажиллах нь зүйтэй талаар, мөн Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгож, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээг яаралтай авах, дулаалгын асуудлаа сэргээгдэх эрчим хүчээр шийдэж байгаа иргэдийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар чөлөөлөх гэх зэрэг урамшууллын системийн тогтолцоог бий болгох, ипотекийн зээлийн тодорхой хэсгийг банкнуудтай тохирч дахин төлөвлөлт, гэр хорооллын орчинд баригдаж байгаа орон сууцуудыг дэмжих, ногоон зээлийг стандартын шаардлага хангасан дулаан алдагдалгүй орон сууцад олгох, ногоон бодлогыг дэмжсэн суурь хуулийг санаачлах, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улаанбаатар хотын стандартыг нийслэлийн дүүргүүдийн Тамгын газрууд хамтарч мөрдөх арга хэмжээг авах, орон нутгийн хэмжээнд ногоон орон сууцад олгох зээлийн хүртээмжийг бий болгох, Монголбанк ногоон санхүүжилтийн талаар бусад банкнуудтай хамтарч санаачилгатай ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг баримтлан чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 85 дугаар захирамжаар байгуулагдсан хот, суурин газрыг орон сууцжуулахад ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн

Эдийн засгийн байнгын хорооноос “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 3 гишүүнээр тасаллаа. Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ хөдөө, орон нутаг аймгийн төвүүд маань бас утааны асуудал бас Улаанбаатараас дутахааргүй асуудал болсон л доо. Тэгэхээр бас л аймгийн төвүүд дээр, орон нутагт энэ дулаалга, түлшний асуудлууд бас яригдана л даа. Тэгэхээр энэ зээлийг ер нь бүсчилж олгох, хөдөө орон нутагт, бүр цаашлаад хөдөө малчдад хүргэх талаар ер нь дэмжлэг байх уу.

Ер нь энэ бас Дэлхийн банк, олон улсын байгууллагаас орж ирж байгаа санхүүжилтүүд байгаа гэж яриад байгаа. Энэ малчдыг хямд эх үүсвэртэй зээлээр хангаж, орон сууцжуулах, амьдрах таатай орчныг бий болгох, яг өвөлжөө, хаваржаа, тэр амьдарч байгаа хэсэг дээрээ орон сууцтай болох тал дээр бас ийм зүйл байгаа гэсэн. Энэ талаар бас тодруулж асууж байна.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн хариулт өгье.

Г.Лувсанжамц: Хосбаяр гишүүндээ баярлалаа. Энэ тогтоолын төсөл батлагдсанаар зөвхөн Улаанбаатар гэлтгүй орон нутагт байгаа иргэд мөн ногоон санхүүжилтийн тогтолцоонд хамрагдах боломж нь нээгдэж байгаа. Ялангуяа ямар заалтуудыг оруулж байгаа вэ гэхээр одоо байгаа хэрэглээний зээлийн журмыг шинэчлээд, ногоон зээлийн журам гэдэг зүйлийг шинээр боловсруулахыг Монголбанканд үүрэг болгож байгаа. Энэ маань боловсруулагдаад гарах юм бол орон нутаг болон Улаанбаатар хотын гэр суурин газар амьдарч байгаа байшин болон гэртэй өрхүүд байшин, гэрээ дулаалах дулаалгын ногоон зээл авах боломж бүрдэнэ.

2 дугаарт нь хэрвээ шинээр амины орон сууц барих гэж байгаа бол тухайн амины орон сууц нь ногоон барилгын шалгуурыг хангасан, мөн эрчим хүчний хэмнэлт нь 50-аас дээш хувьтай байх юм энэ зээлийн журамд хамрагдах боломж нь нээгдэж байгаа.

Дээрээс нь нэмээд энэ ногоон зээлд хамрагдахад байшин, гэрээ дулаалах, амины орон сууцыг эрчим хүчний хэмнэлттэйгээр барих гэж байгаа бол тэргүүн ээлжид энэ зээлийн асуудал нь шийдэгддэг байна гэсэн төслийг тусгасан. Энэ ажлынхаа хүрээнд Дулаан баатар гээд аяныг эхлүүлж байгаа. Энэ аяны хүрээнд Улаанбаатар хотод байгаа нь 170 мянган бүр бүрэн бус дулаалгатай байшин, гэрүүдийг дулаалах ажил. Мөн орон даяар 130 мянган байшин, гэр байгааг нийлүүлээд 300 мянган айл өрхийн дулаалгын ажлыг нь эрчимжүүлье. Ногоон

зээлийн санхүүжилтэд хамруулъя, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоё. Байгаль орчны яамнаас олгодог ногоон зээлийн татаасны хэлбэрийг нь өргөжүүлъя. Өнөөдрийг хүртэл бид нар сайжруулсан түлш зэрэг шатдаг зүйлүүд дээр хөнгөлөлт олгож ирсэн бол цаашдаа дулаалга, амины орон сууц эрчим хүчний хэмнэлттэй байх, мөн ногоон барилгын шалгуурыг хангасан байх юм бол тэргүүн ээлжид хамрагддаг больё гэсэн ийм зохицуулалтуудыг оруулсан байгаа.

Мөн энэ ажлын хүрээнд Үндэсний дулаалгын бодлого гэдэг зүйлийг боловсруулахыг Засгийн газарт үүрэг болгож байгаа. Энэ дулаалгын бодлогын хүрээнд тухайлбал ипотекийн зээлтэй адилхан 50 хувийг нь Улаанбаатар хотод, үлдсэн 50 хувийг нь орон нутагт хэрэгжүүлэх ёстой гэсэн хөтөлбөрийг боловсруулж байгаа. Миний бие ч гэсэн мэргэжлийн хүний хувьд бол Байгаль орчны яам, Хот байгуулалтын яамтай энэ тал дээр нягт ажиллаад, орон нутгийн гишүүдийн бас саналыг тусгаад, уг төлөвлөгөөг нь илүү боловсронгуй, оновчтой болгох тал дээр нь анхаараад ажиллая гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Баатархүү: Энэ Улаанбаатар хот цаашдаа энэ хотуудын хөгжлийн тухай ярьж байна. Би зүгээр энд нэг зүйлийг хариуцлагатайгаар хэлмээр байгаа юм. Улс төржиж байгаа юм биш. Өнгөрсөн 35 жилийн 30 жилийг нийслэл Улаанбаатар хотын 30 жилийг одоогийн эрх барьж байгаа МАН удирдсан. Энэний үр дүн Улаанбаатар хот. Нийт айл өрхүүдийн 60 гаруй хувь нь гэр хороололд дэд бүтцийн хүрэлцээгүй газар амьдарч байна. Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж чадахгүй байгаа. Тэгээд оруулж ирж байгаа төсөл хөтөлбөр болгон ийм уриа лоозонгийн шинжтэй байдаг. Хэрэгждэггүй. Энэ оруулж ирж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгыг би буруутгаагүй. Одоо байгаа хотын удирдлагатайгаа зөвлөлдсөн юм уу. Сүүлийн 6 сар Улаанбаатар хот агаар орчны бохирдлыг бууруулах бодлогоо өөрчилж байна шүү дээ. Зуух тараана гэсэн. Больсон. Газаар халаах тухай ярьсан. Больсон. Дулаалгын тухай ярьсан. Хойшлуулсан. Тавантолгойн тэг давхаргын нүүрсээр түлшээ солих тухай ярьсан. Хойшлуулсан. Дараа нь БНХАУ-аас хөх нүүрсийг авчрах тухай одоо ярьж байна шүү дээ. Тэгээд Монгол Улсад чинь энэ агаар орчны бохирдлыг бууруулах, ногоон санхүүжилтийг шийдвэрлэх энэ нэгдсэн бодлого гэдэг юм чинь байхгүй шүү дээ. Нэгдсэн бодлого гэдэг зүйл чинь алга. Орон нутаг чинь өөр юм ярьж байна. Хот өөр юм ярьж байна. Бид нар энд өөр юм ярьж байна шүү дээ. Би түрүүнээс хойш хэлээд байгаа шүү дээ. Энэ төсөл хөтөлбөрийн уялдаа. Эхлээд юу хийх юм. Энэ төсөл дараагийнхаа төсөлд яаж нөлөөлөх юм. Энэ тухай бид нар илүү сайн ярих хэрэгтэй байна. Хамгийн гол асуудал бол энэ ногоон зээл гэдэг зүйл чинь нийт зээлийн багцын ерөөсөө банкны зээлийн 3 хувь байна. Яг гэр хороололд амьдарч байгаа иргэд энэ зээлээ авах тэр шалгуурыг хангахгүй байна. Тэр хүрэлцээ байхгүй байна. Тийм учраас агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр бол цогцоор нь харж төслийг бол оруулж ирэх нь зөв. Энд нэг тогтоол гардаг, дахиад хэрэгждэггүй. Дахиад 1 өөр тогтоол оруулж ирдэг. Улаанбаатар хотын асуудалд ийм хоноцын сэтгэлээр хандаж болохгүй гэдгийг би зарчмын хувьд хэлмээр байна. Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн хариулт өгье.

Г.Лувсанжамц: Баатархүү гишүүнд баярлалаа. Гэхдээ нэг зүйлийг тодотгож хэлмээр байна. Энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл бол бид нар цаашдаа энэ

асуудлыг бодитойгоор шийдье гэж байгаа. Шатдаг зүйл дээр татаасыг олгох, эсвэл хот нь өөр юм ярьдаг, дүүрэг нь өөр юм ярьдаг, аймаг, сум нь өөр юм ярьдаг энэ зүйлийг больё. Үндэсний дулаалгын бодлогыг хэрэгжүүлбэ гэсэн ийм Дулаан баатар гэсэн аян байгаа. Энэ зөвхөн Улаанбаатарыг хэлээгүй. Байшин, гэрээ дулаалаад утаа гаргадаггүй болсон та өөрөө баатар хүн болж байгаа. Та бол оршин суугч, та баатар хүн болж байгаа. Үр хүүхдийнхээ төлөө, Монгол Улсын нийгмийн төлөө энэ хүндрэлтэй байгаа агаарын бохирдлыг бууруулахын төлөө хувь нэмэр оруулж байгаа та баатар хүн болж байгаа юм гэсэн тийм санаачилгатай аян юм.

Тэгэхээр энэ үндэсний хөтөлбөр боловсруулаад явахад таны яг хэлсэн алдагдсан зүйлүүдийг нь боловсруулаад, сайжруулаад явах зүйл дээр хамтраад ажилламаар байна. Улсын Их Хурал дээр байгуулагдсан 80 гишүүнтэй Улаанбаатар хотын нийслэлийн хөгжлийг дэмжих бүлэг байгаа. Дэд даргаар ажиллаж байгаа таны хувьд бас нэлээн сайн оролцоотойгоор, ялангуяа нийслэлийн гэр, суурин бүсийн тойргоос сонгогдсон таны хувьд бас бидэнд өгөх зөвлөмж, зөвлөгөө их байгаа болов уу гэж бодож байна.

Дахиад нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Өнгөрсөн хугацааны алдаа, оноог яриад суух нь бол Улсын Их Хурлын гишүүдийн ажил биш болов уу гэж бодож байна. Оносон, оноогүйг тухайн асуудлыг хариуцаж байгаа яам нь хариуцаад явах ёстой. Сүүлийн 10 сарын хугацаанд бол Одонтуяа сайдтай энэ тал дээр маш сайн ойлголцсон. Цаашдаа Батбаатар сайдтай бас энэ тал дээр хамтраад ажиллая гэж бодож байна. Гол нь бид нар шийдэл ярих ёстой. Ирээдүйг ярих ёстой. Утаагүй өвлийн талаар ярих ёстой. Тэгэхээр чи би гэдэг чичлэх зүйлээ хажуу тийш нь хойшлуулж тавьж байгаад энэ шийдлийн төлөө хамтдаа зүтгэе гэсэн тийм уриалгыг хэлмээр байна.

Дулаалгын асуудлын хувьд нийслэл хойшлуулсан зүйл бол байхгүй. Энэ жилийн хувьд 20 мянган өрхийн дулаалгын ажлыг дэмжбэ гэж байгаа. 10 мянган байшин, 10 мянган гэр. 2026 онд 15 мянган байшин, 15 мянган гэрийг дулаалъя гэсэн ажлыг хийж байгаа. Таны сая дурдсан төсөл арга хэмжээнүүд бол хойшлогдсон эсвэл цуцлагдсан шалтгаан бол Засаг дарга нарын түвшинд ч гэсэн бид нар дулаалгын ажил дээр анхаарах ёстой юм байна гэсэн нэгдсэн ойлголтод хүрсэн учраас цаашдаа дулаалгынхаа ажлыг хэрэгжүүлээд явъя. Энэ үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулахад нийслэлийн зүгээс мөн адилхан мөн дүүргийн Засаг даргын Тамгын газруудтай бас тулж ажиллаад санал, хүсэлтүүдийг нь авсан байгаа. Тэгэхээр цаашдаа бодитоор хэрэгжих талаас нь хамтраад, Улсын Их Хурлын гишүүдийн хувьд дэмжээд орон нутгийнхаа чиглүүлээд, Аж ахуйн нэгжүүдэд зөв мэдээлэл өгөх гол нь хэрэглэгчид буюу оршин суугчдыгаа дулаалгын ажил хамгийн чухал юм шүү. Энэ дулаалгын ажлыг хийх боломж бололцоо нээгдэж байгаа юм шүү. Зээлийн шалгуур нь намсаж байгаа юм шүү гэсэн мэдээллүүдийг хүргээд явъя гэсэн тийм уриалгыг дахиж хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Энэ тогтоолын төсөл дээр учиргүй эсрэг зүйл алга. Бид нар дандаа л зөв юм яриад байдаг. Ирээдүй цаг дээр яриад байдаг. Горьдлого төрүүлээд байдаг. Ногоон зээлийн тухай олон жил ярьсан. Хэрэгждэг зүйл байхгүй. Энэ зээлийнх нь багц энэ банкнууд дээр зүгээр л гангараа болж хувирсан. 3 хувь байна. Одоо тогтоолын төсөл дээр 10 хувь болгоно гэсэн санал оруулж ирж байна.

2 дахь зүйл. Гэр хороололд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс маань тэр шалгуур хангах нөхцөл чинь маш хэцүү байгаа учраас авах боломж байдаггүй. Зээлийн батлан даалтын сан чинь шийдэж өгдөггүй. Дахиад Улсын Их Хурал тогтоол гаргадаг. 4 жилийн дараа ногоон зээлийн 10 хувийг нь 20 хувь болгох тухай ярих вий. Би 1 зүйл дээр бол санал нэгдэхгүй байна. Хариуцлага ярихгүйгээр урагшаа харж болохгүй байна. Улаанбаатар хотын өнөөгийн нөхцөл байдал бол өнгөрсөн 30 жилийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан. Гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Жаргалан: 126 гишүүнтэй шинэ парламентын хувьд өмнөх бас хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ч гэсэндээ бид өнгөрсөн 20, 30 жилийн туршид бугшсан олон асуудлуудыг шийдэх, тэр дундаа яг өнөөдөр яригдаж байгаа Улаанбаатар хотын агаарын бохирдол, утааны асуудлыг бүрэн шийдвэрлэх бас ийм улс төрийн зориг гаргаж байгаа болов уу гэж бас найдаж байна. Тэр утгаараа ч тэр 2025 оны 6 дугаар сарын 5-нд Улсын Их Хурлаас 53 тоот бас 1 тогтоолыг баталсан байгаа. Өөрөөр хэлбэл энэ Улсын Их Хурал шат дараалсан байдлаар Засгийн газарт чиглэл өгөх, бас үйл ажиллагааны хөтөлбөр төсөвт тусгуулах замаар утааг 3 жилийн дотор бүрмөсөн бас алга болгох ийм зорилтуудыг дэвшүүлээд ажиллах шаардлагатай байгаа гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ 6 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан 53 тоот тогтоолоор бид ямар зорилтууд дэвшүүлсэн бэ гэхлээр 3 жилийн дотор нийслэл болон төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлт бүрэн нийцүүлэх зорилт бас дэвшүүлсэн байж байгаа. Мөн түүнчлэн нь төсвийн хөрөнгөөр зуух яндан түлш зэрэг агаарын бохирдлын эх үүсвэрийг санхүүжүүлэхгүй байх ийм зарчмын буюу үзэл санааны шийдвэрийг бас гаргасан байж байгаа. Үүнтэй холбоотойгоор орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог Ерөнхий сайд өөрөө ахалж, бас ийм улс төрийн манлайлал үзүүлээд ажиллах ёстой гэсэн ийм үүрэг чиглэлүүдийг бол өмнөх тогтоолоор Засгийн газарт бол өгсөн.

Өнөөдөр Лувсанжамц гишүүн тэргүүтэй ажлын хэсгээс оруулж ирж байгаа ногоон санхүүжилтийн тогтоол бас араас нь хэрэв бид нар зуух яндан, түлшинд мөнгө зарахгүй бол юунд мөнгө зарах вэ гэдгийг бас илүү тодорхой болгож байгаа ийм тогтоол байгаад байгаа. Тэгэхээр яах вэ гэхээр дулаалгынхаа арга хэмжээг авъя. Эрчим хүчний халаалтын асуудлын шийдье гэдэг байдлаар Улаанбаатар хотын утаанаас ангижрах ийм төлөвлөгөөнүүд бол шат дараалсан байдлаар боловсруулагдаад явж байгаа. Гэвч харамсалтай нь Улсын Их Хурал дээр ийм улс төрийн шийдвэрүүд гараад байхад нийслэл хотоос гаргаж байгаа шийдвэрүүд бас уялдахгүй байгаад байна. Тухайлах юм бол сая 2025 оны 6 дугаар сарын 13-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас урд хөршөөс энэ хөх нүүрс гэж нэрлэгдээд байгаа хагас коксжих түлш 226 тэрбум төгрөгөөр худалдаж авах ийм тендер зарлачхаад сууж байгаа юм. Өөрөөр хэлбэл ирэх жил ахиад бид нар төсвийн мөнгийг агаарт хийсгэх буюу 226 тэрбум төгрөгөөр коксжих нүүрс урдаас худалдаж авч ингэж төлөх юм байна л даа. Тэгэхээр ингээд энэ Улсын Их Хурал дээр явж байгаа бодлого, Засаг дээр гарч байгаа бодлого чинь ерөөсөө уялдахгүй байна гэж хэлмээр байгаад байгаа юм.

Тэгэхээр саяын миний дурдаад байгаа энэ 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бол Засгийн газар буюу Ерөнхий сайдаас бас шаардмаар байгаад байгаа юм. Тэгээд өнөөдөр энд сайд нараас бас хэн ч алга. Яагаад энэ нийслэлээс ийм зөрүүтэй бодлогууд яваад байгаа юм бэ. Яахаараа бид нар 230

тэрбумаар бас гаднаас нүүрс худалдаж авах ёстой юм бэ. Хэрэв энэ 230 тэрбумыг энэ Лувсанжамц тэргүүтэй гишүүдийн яриад байгаа энэ дулаалга бөгөөд халаагуурыг санхүүжүүлэх аянд зарцуулах юм бол магадгүй бид нар ахиад даруй 20, 30 мянган айлыг энэ жилдээ багтаагаад яндангүй болгох боломжтой болно. Гэтэл энэ бодлого бас хэрэгжихгүй байгаад байна. Тэгэхээр сайд нараас энэ тодорхой асуудлуудыг бас асуумаар санагдаад байна. Тэгээд харамсалтай нь бол хэн ч бас байхгүй л байгаад байна. Их Хурлын дарга аа, хэнээс асуух вэ.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга хариулна даа.

Г.Лувсанжамц: Жаргалан гишүүндээ баярлалаа. Та бас энэ тогтоолын төсөл дээр бодитой саналуудыг хэлж өгсөн, тусгасан. 6 сарын 5-нд батлуулсан 53 дугаар тогтоолын төслийг боловсруулахад манлайлж ажилласан. Баярлалаа. Яг таны хэлж байгаачлан бидний энэ 2 тогтоолын төсөл бол хоорондоо уялдаад явна. Асуултын хувьд бид нэгэнт мэргэжлийн бөгөөд ялангуяа нийгмийн асуудалд бодитойгоор ойлголттойгоор зөв шийдлийг санал болгоод явж байгаа Улсын Их Хурлын гишүүд цаашдаа Засгийн газрын үйл ажиллагаа, нийслэл, дүүрэг, аймаг, сумдын засаг захиргааны байгууллагууд дээр яг энэ дулаалгыг хэрэгжүүлэх ёстой. Ганцхан л төлөвлөгөөтэй, ганцхан бодлоготой бариад, түүндээ уялдсан ажлыгаа хэрэгжүүлээд явах ёстой. Энэ талаар мэдээллүүдээ хувийн арилжааны банкнууд болон дулаалгын ажил гүйцэтгэдэг ногоон орон сууц барьдаг тийм аж ахуйн нэгжүүдэд мэдээллийг зөв олгох, хамгийн гол нь иргэдэд бас зөв мэдээллийг түгээж Засгийн газар болон төрийн түвшинд бүгд нэг чигт харж байгаа юм байна гэсэн ойлголтыг үүсгээд явах нь бол нэн чухал гэж бодож байгаа болохоор энэ тал дээр цаашдаа Нийслэлийн хөгжлийг дэмжих бүлгийн гишүүний хувиар бас хамтраад, зөв чиглүүлээд, залаад, бурууг нь засаад, зөвийг нь дэмжээд явъя гэсэн тийм санаачилгатай байна.

Д.Амарбаясгалан: Агаарын бохирдолтой холбоотой асуудлаар, дулаалгатай холбоотой, түлштэй холбоотой гээд олон янзын санаачилгууд бас шат шатанд гарч ажиллаж байгаа. Тэгээд энэ гишүүдийн хэлж байгаа байр суурийг би дэмжиж байна. Улсын Их Хурлын шийдвэр эцсийнх байх ёстой. Улсын Их Хурлаас гарсан хууль, тогтоолын хэрэгжилтийг хангах нь аливаа шатны гүйцэтгэх засаглал, орон нутгийн удирдлага, байгууллагын бус үүргийн асуудал байх ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад, Лувсанжамц гишүүн өөрөө ахлаад, Улсын Их Хурлын гишүүд оролцоод, идэвхтэй ажилласан. Бодитой үр дүн гаргахын төлөө зорилго тавьж байгаа. Үүн дээр нь үндэслэж өнөөдөр Улсын Их Хурлаар энэ тогтоол орж хэлэлцэгдэж, батлагдаж байгаа. Мэдээж өмнө нь гарсан тогтоолуудтайгаа уялдах, хамтарч энэ заалтууд нь хүчин төгөлдөр хэрэгжих тэр боломжуудыг бас давхар судлах хэрэгтэй. Сая Жаргалан гишүүн бас хэлж байна. Ер нь гарсан тогтоолууд яг амьдрал дээр очоод аль зүйл заалт нь хэрэгжих боломжтой байна. Аль нь бас бодлоготойгоо зөрчилдөөд байна. Эргээд эдгээрийг нэгтгэж, нийлүүлж 1 зүйл болгох шаардлага байна уу, үгүй юу гэдэг дээр бас ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаад, судалгаа дүгнэлт гарга. Тэгээд шаардлагатай гэвэл энэ гишүүдийн хэлсэн санаачилгын дагуу дахиж бас нэгтгэсэн байдлаар шийдвэр гаргах боломж байгаа гэдгийг бас хэлье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал хураалтыг хойшлуулна. Санал хураалтын нэгдсэн зохион байгуулалтаар явуулна.

14.32 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ахалж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төсөл зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Л.Соронзонболд, Д.Цогтбаатар нар болон Х.Баасанжаргал нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, О.Номинчимэг нараас гаргасан саналуудыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Мөрдөгч хэргийн оролцогчийн өөрийн хүсэлтээр албан ёсоор бүртгүүлсэн цахим харилцаа холбооны хэрэгслийг ашиглан дуудан ирүүлэх, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлэх зэрэг харилцааг тусгалаа.

Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хяналт шалгалтын ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэл зэрэгт нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийн хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, мөн түүний онцлог шинжийн талаар, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар тусгах зарим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж, ажиллах талаар, хэрэглэсэн техник хэрэгслийн талаар тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг, дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгээр давхар баталгаажуулдаг байхаар, цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгагдсан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болох зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн мөрдөгч, прокурор яллагдагч, шүүгдэгчийн цагаатгах хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхийг баталгаажуулахаар тусгалаа.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг нэгдсэн цогц байдлаар зохицуулж, процессын нэгдмэл журам, нэгдмэл платформыг шилжүүлэх шаардлагыг харгалзан хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтын шүүх хуралдааныг шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг хуулийн төслөөс хасах зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сайнзориг гишүүнд бас талархал дэвшүүлъя.

Ядамжавын Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, Максимын Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Отгонбаярын Мөнхбаатар

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Халтарын Буянтүмэн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Пагмадоржийн Оростогоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа, Доржхүүгийн Сандаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Батсүхийн Батдэлгэр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга цагдаагийн хурандаа, Бадамын Батзориг Монголын криминалистикийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Доржсүрэнгийн Батсүх Монголын өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хорооны дарга, Төгсийн Энхбаяр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Дарааллын дагуу Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Алтангэрэл сайдын өргөн барьсан Эрүүгийн хэрэг хянанх шийдвэрлэх тухай хуулийн төслийг бид хэлэлцэж байгаа. Тэгэхээр сайд өөрчлөгдсөн учраас би Засгийн газар, сайдаас бол асуух боломжгүй байна. Ажлын хэсгээс асуулт асууя. Сайнзориг гишүүнээс асууя.

Сайнзориг гишүүн сайн ажилласан байна. Ажлын хэсэг сайн ажилласан байна. Би сайн ажилласан гэдэгт 1 зүйлийг тодотгож хэлэх гэж байгаа нь энэ хуулийн төсөлд одоо Тэмүүжин бид нарын 20 гаруй жил тэмцээд, арай чүү гэж ард нь гарсан шүүхээс Дээд шатын шүүхээс доод шатын шүүх рүү чиглэл өгдөг, буцаадаг, хугацаагүйгээр хүнийг хэлмэгдүүлдэг энэ хонгилыг нураах хүрээнд хэргийг прокурорт буцаах үндэслэлийг маш хязгаарласан юм. Энэ бол 3 удаа хуульд хүчингүй болгосон, буцаахгүй болгосон. 3 удаа сэргээсэн. Хонгилынхон парламентад нөлөөлж. Хамгийн сүүлд нам үл харгалзаад Пүрэвдорж, Сандаг-Очир бид 3 санаачлаад, манай Цогтбаатар Байнгын хорооны дарга ажлын хэсгийг нь ахлаад, манай Бедон Ганбаа ах өөр чинь хэн орлоо. Ингээд 3 гишүүн, нам намуудын төлөөлөл ороод, тэгээд МАН, АН-ын дэвшилтэт гишүүд санал нэгдэж, 2023 онд шүүхээс хэргийг буцаадаг явдлыг бол хязгаарласан.

Тэгэхдээ зарим тохиолдлоор хэргүүдийг хүртэл шүүх буцаагаад л байгаа. Тэр буцааж байгаагийн үйлчлүүлэгчид нь энэ танхимд бас байгаа. Алтанхуяг, Найдалаагаас эхлээд хэрэг нь Дээд шүүхээс буцчихсан хүмүүс байгаа. Ганц л зарчим барьж байгаа. Гэм буруутай бол нотол, ялаа өг. Гэм буруу нь нотлогдохгүй бол цагаатга, хүчингүй болго. Шүүх энэ Мөрдөх алба болон прокурорын дутуу хийсэн ажлыг гүйцээдэг байгууллага биш. Өөрөө мөрдөн шалгах нотлох баримтыг цуглуулдаг газар биш. Мөрдөгч, прокурорын шүүхэд авчирсан хэргийн үйл баримтын хүрээнд л шийдвэрээ гаргах ёстой. Гэтэл харамсалтай нь манай Алтангэрэл сайд хэргийг прокурорт буцаах гэдэг энэ 33.3 дахь заалт дээр 1.4 гээд процессын ажиллагааг бүрэн хийгээгүй бол буцаана гэдэг заалт оруулж ирсэн байгаа юм. Бүрэн хийгээгүй бол. Өөрөөр хэлбэл мөрдөгч, прокурорын дутуу хийсэн ажиллагааг шүүх гүйцээх энэ Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн заалт оруулж ирсэн.

Энийг манай Сайнзориг илрүүлээд, үнэт зүйл, зарчмынхаа талд зогсож, энийг хасах санал ажлын хэсгээс оруулж санал хураалгах гэж байна. Тийм учраас би энийг дэмжиж байна. Ажлын хэсэг дээр энэ талаар юу гэж ярилцаж, яаж шийдсэн бэ гэдгийг хууль санаачлагч өөрчлөгдчихсөн учраас би ажлын хэсгээ ахлагчаас асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Сайнзориг гишүүн хариулт өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгэхдээ Засгийн газраас өргөн барьсан энэ төслийг бол өнгөрсөн парламентын үед ерөнхийдөө Улсын Их Хурлын тогтоолоор чиглэл өгсөн юм байна лээ. Ийм ийм зүйлүүдийг бас сайжруулж, хуулийн төслийг өргөн бариарай гэсний хүрээнд Алтангэрэл сайд маань бол шуурхай ажиллаж, оруулж ирсэн. Энэ дээр бол өмгөөлөх эрхийг сайжруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бас олон тодорхойгүй заримдаа эргэлзээтэй зүйлүүдийг сайжруулах чиглэл байгаа боловч зарим бас Энхбаяр гишүүний асууж байгаа энэ 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа энэ хуулийн амин сүнс болсон зарим заалтууд бас эвдрэх, үзэл баримтлалын хувьд зөрчилдөх ийм зүйлүүд ганц нэг заалтууд байгааг бид нар ажлын хэсэг дээрээ сайтар ярилцсан.

Эргээд энэ саналуудыг ярилцахдаа шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөх байгууллагуудын тал талын төлөөллүүдийн байр суурийг сонссон гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр танд бас хэлмээр байна. Гол асуудлууд бол яг л таны хэлж байгаа юмнуудыг би давтаж яриад яах вэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ил тод, шуурхай, эргээд энэ шүүхийн бас мөн чанарын асуудал, хандлагын асуудал яригдаад байгаа юм. Бид хэд яг Үндсэн хууль болон бусад хуулиар заагдсан чиг үүргээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой байтал шүүх маань илүү их мөрдөн шалгах ажиллагаа руу хутгалдаж заавал нэг юмыг гүйцэлдүүлж орж ирээд, хүнийг яллах гээд дайраад байдаг ч юм уу, энэ мөрдөгч, прокурорын бас дутуу хийсэн эсвэл энэ зүйлүүдийг дөрөөлөөд бас ийм чиглэл өгөх тал руу юмнууд бас хазайчих гээд байгаа мэр сэр зүйлүүд бол байгаа. Нуугаад яах вэ. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас засаж залруулах чиглэлдээ ажилласан гэдгийг хэлье.

Тэгээд мэдээж энэ шинэ хуулиар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэдэг зүйл байгаа. Урьдчилсан хэлэлцүүлэг дээрээ хэргийг буцаах асуудлыг 3 үндэслэлээр заачихсан байдаг. Хэргийг буруу тусгаарласан, шүүх хуралдааныг нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах хийлгэсэн бол хийлгэх шаардлагатай бол мөрдөн шалгах ажиллагааны явцад эрүүгийн хэргийг ноцтой зөрчсөн буюу яг Энхбаяр гишүүний яриад байгаа тэр хавтаст хэрэгтээ бүрэн танилцуулаагүй гэдэг энэ үндэслэлүүд өөрөө энэндээ багтах ойлголт байгаа. Гэхдээ Өмгөөлөгчдийн холбоо болон Хуульчдын холбооны гишүүдийн дэвшүүлж байгаа саналыг бол би бүрэн ойлгож байгаа. Цаашдаа бас энэ эрүүгийн процессын хуулийг ноцтой зөрчсөн гэдгийг мөрдөн байцаалтын шатад тодруулах зайлшгүй шаардлага байгаа гэдгийг би бол протоколын хүрээнд зөвшөөрч байгаа. Энийг илүү их сайжруулаад явъя гэдэг ийм зүйл байгаа.

2 дугаарт ер нь зүгээр энэ асуудлуудын цаана шүүх эрх мэдлийн байгууллагад үл итгэх, шүүх ерөөсөө л ингэчихдэг гэдэг энэ олон нийтийн хардлагыг төрүүлээд байдаг учраас хэдүүлээ бас ажил, чиг үүргийнх нь дагуу хуулийн хүрээнд ажлаа хийдэг байх хууль сахиулах тогтолцоог шахаж өгөхийн тулд эдгээр энэ саналуудыг бас гаргаж ирж байгаа. Ажлаа хийдэггүй, субъектив байдлаар хандчихаад шүүх рүү

алдаагаа түлхээд, шүүх нь бас гарцаагүй байдалд орчихдог ийм тохиолдлууд бас амьдрал дээр байдаг. Тэгэхээр хаана хаанаа хариуцлагатай байх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Энэ хууль ажлын хэсэг яваад анхны хэлэлцүүлэг болж байна. Тэгэхээр ганц зүйл заалттай холбоотой нарийвчилсан хариулт авъя гэж бодож байна. Энэ юуг гэхээр төслийн 1 дүгээр зүйлийн 21 буюу яг энэ процессын хуулийн 34.16 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт 1 зүйл, заалт нэмэхээр оруулж ирсэн байгаа юм. Тэгээд энийг нь харахаар уг нь энэ 34.16 бол өөрөө нөгөө хурал хойшлуулахтай холбоотой процессын асуудал. Ямар ямар үндэслэлээр хойшлуулж болох юм. Ингээд саад учруулаад байхгүй бол ямар арга хэмжээ авах юм гэдэг юм. Тэгтэл энэ дээр орж ирж байгаа зүйл, заалт нь болохоор ер нь шүүгдэгчийн өөр өмгөөлөгч томилох, шүүх хуралдаанд өөр өмгөөлөгч улсаас томилохтой холбоотой ийм хэм хэмжээний зохицуулалт ороод ирчихсэн байгаа.

Үзэл санааны хувьд бол шүүх хуралдаан хойшилдог асуудал бол өмгөөлөгч нар ирдэггүй, хүндэтгэн үзэх шалтгаан байдаг уу, байхгүйгээр хойшлуулдаг байх энийг больё гэж байгаа юм байна лээ. Гэхдээ бид нар энэ процессын хуулийг бас хараад үзэх юм бол 5 дугаар зүйлийн 2 буюу өмгөөлөгч сонгохтой холбоотой энэ харилцаа дээр яг энэ утга агуулга уг нь байгаа юм. 5.2.7 дээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч сонгосон өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцохгүйгээр шүүх хуралдаанд, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулаад байх юм бол томилсон өмгөөлөгчийг нь өөрөөр томилж өгөөд оруулна гэдэг энэ хэмжээнд байгаад байгаа юм. Тэгээд нөгөө талаараа бас үүнтэй холбоотой шүүх хуралдааныг хойшлуулж, зүй бусаар хойшлуулахыг сэргийлсэн арга хэмжээг энэ 34.16.3 дээр буюу санаатай саад учруулах нөхцөлөөр юу гэдэг юм энэ шүүх хуралдаан хойшлуулах үндэслэлийг ашиглаад байвал гэдгийг 2 буюу түүнээс дээш удаа байсныг нь хасчхаж байгаа юм. Ер нь бол энийг шүүгч өөрөө харж байгаад, 2 байна уу, 1 байна уу. Энийгээ бас шийддэг больё гэсэн юм энд гараад ирж байгаа юм.

Тэгээд ингээд хууль зүйн техникийн хувьд гарахлаар 1 дүгээрт энэ байх ёсгүй процессын хэм хэмжээ дээр улсын өмгөөлөгч томилох хэм хэмжээний ийм заалт ороод ирчихсэн. Дээр нь адил агуулгатай зүйл маань 5.2.7 дээр байгаад байдаг. Тэгээд энэ ямар учир шалтгаантай өөр нэмэлт агуулга агуулж байгаа, тэгээд энийг ажлын хэсэг дээр бас хөндөөгүй юм байна лээ. Энэ дээр бас ажлын хэсгийн ахлагч уу, ажлын хэсгээс тайлбар эхлээд авчихъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн хариулт өгье.

П.Сайнзориг: Бид хэд ажлын хэсэг дээр ерөнхийдөө зүйл зүйлээрээ бас асуудлаа ярьсан. Энэ удаагийн яг таны хөндөж байгаа 36.16 дугаар зүйлийн 8 дахь хэсэг болон холбогдох бусад тэр заалтуудыг бол бас Засгийн газрын өргөн мэдүүлснээр нь бол явах нь зүйтэй юм байна гэж санал нэгдсэн. Таны яах вэ зүгээр давхцал үүсээд байна гэдэг зүйлийг бас санал хураалгах явцдаа үндэслэлд та бичсэн байна лээ. Яах вэ, зүгээр 5.2 дугаар зүйл бол үндсэндээ өмгөөлөгчийг сонгох гээд нийтлэг заалт байгаа. Нийтлэг заалт. Бүх процессын үе шатууд дээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгчийг томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын өмгөөлөгчдийн холбооны

саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсэн журам буюу ерөнхий заалт байгаа.

Харин 34 дүгээр зүйлээс эхлээд энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг анхан шатын шүүхийн процессын ажиллагаанууд эхэлдэг. Энэ хүрээ дээрээ өмгөөлөгч тодорхой үндэслэлээр оролцох бололцоогүй бол яах вэ гэдэг заалтыг өмнөх тэр 5.2 дугаар зүйлтэйгээ уялдуулан дэлгэрүүлж байгаа заалт байгаа гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна. Тийм учраас зөрчил гарахгүй болов уу гэдэг үүднээс бид хэд хөндөөгүй байж байгаа.

Таны тэр 2 болон түүнээс дээш санаатайгаар шүүх хуралдааныг бас хойшлуулах асуудал байсныг тэр заалт бол хасагдаж байгаа. Тэгэхээр ер нь зүгээр санаатайгаар ийм үйлдэл яваад байвал бас өмгөөлөгчийн зүгээс санаатай энэ үйлдэл дээр дор дор нь арга хэмжээ авахгүй бол 2 болон түүнээс дээш удаа гарахыг бас хүлээгээд явах юм бол хэрэг хянан шийдвэр ажиллагааны явцад энэ түргэн шуурхай байх гэдэг юм уу, энэ зүйлүүд дээр зохимжгүй гэх юм уу тэр үндэслэл муутайгаар тэр хууль зөрч гэдэг зүйлийг бид хэд хүлээн зөвшөөрөөд байна гэсэн үг шүү дээ. Заавал 2 болохыг нь хүлээгээд байна гэсэн үг. Тэр санаатай үйлдлийг. Хүндэтгэн үзэх шалтгаан биш. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас тодруулж, Засгийн газраас бас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн текстийг нь үлдээх нь зүйтэй юм байна гэж ажлын хэсэг дээр бид үзсэн.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Тэр 2 ба түүнээс дээш удаа дээр би ямар ч санал байхгүй. Ийм арга хэмжээ авчихсан юм байна гэдгийг нь хэлж байгаа юм. Давхардаж байгаа санал чинь таны уншдаг санал биш, энэ 5.2.7 буюу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгосон өмгөөлөгч тухайн ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцох боломжгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаар бол тухайн мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалтын явцад хийгдэх шүүхийн хэлэлцүүлэгт шүүх, прокурор, мөрдөгч нь томилогдсон өмгөөлөгчийг оролцуулж болно гээд ижил агуулгатай байгаа юм.

Нөгөө талаараа энэ 8 дугаар зүйл чинь энэ чиглэлээрээ үлдчих юм бол бас нэг юм нь ийм байгаад байгаа байхгүй юу. Эсхүл гэж байгаад шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 52-ын дагуу буюу улсын өмгөөлөгчийг томилно гэж байгаа юм. Тэгээд шүүгдэгч өмгөөлөгчөөсөө өөрөө ямар нэгэн шалтгаанаар бас татгалзаж болно шүү дээ. Өмгөөлөгчийн арга тактикаар сунжруулах гэж ч болно. Эсвэл үнэхээр эрх ашгийг нь хамгаалахгүй байна гээд энийг чинь татгалзаж болно. Тэгэхэд энэ зүйл заалтаар чинь бол 1 удаа өмгөөлөгчөөсөө татгалзахад ерөөсөө улсын өмгөөлөгч .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Засгийн газраас оруулж ирсэн энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ажлын хэсгээс ажиллаад оруулж ирж байгаа энэ төслийг бол дэмжиж байгаа.

1 дүгээр асуулт болохоор бол энэ Засгийн газрын саналаас ямар заалтуудыг хассан бэ. Тэрний үндэслэл юу вэ гэдэг асуулт байна.

2 дугаарт болохоор энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр яг процессын хувьд цаг хугацааны болоод үйл ажиллагааны дэс дарааллын хувьд хүний эрхийг сайжруулсан яг ямар ахиц дэвшил гарч байгаа юм бэ гэдэг асуулт байгаа юм. Ялангуяа өмгөөлүүлэх эрхийг яаж баталгаажуулж байгаа вэ гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Сайнзориг гишүүн хариулт өгье.

П.Сайнзориг: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Маш тодорхой 2 асуулт асуулаа. Бид хэд зүгээр хассан заалтуудыг 1 дүгээрт цахимжилттай холбоотой энэ асуудлыг бол энэ удаад хасъя гэдэг зүйлийг бид нар оруулж ирж байгаа. Тэгэхдээ энэ хасаж байгаа нь цахимжилтыг дэмжихгүй байгаадаа биш юм. Энэ хууль сахиулах салбар болон шүүх эрх мэдлийн байгууллага дахь цахимжилтын дундын мэдээллийн санг хэн авч явах юм бэ. Энд үүсэж байгаа датануудын аюулгүй байдал, цаашдаа ашиглах байдлыг хэрхэн яаж зохион байгуулах юм бэ. Хатуу, зөөлөн дэд бүтцийн асуудлын хөрөнгө оруулалтыг хэрхэн яаж шийдэх юм бэ гэдэг зүйлүүд нэлээн бас суурь хууль гаргах зайлшгүй шаардлагатай юм байна. Ингэж чадвал бид нар эрүүгийн хэрэг дээрх зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулж, хавтаст хэргийг цахимжуулахаас гадна цаашдаа иргэн, захиргаагаа бас ялгаагүй цахимжуулах нэгдсэн ийм платформ уялдаатай явах нь зүйтэй юм байна. Хөрөнгө оруулалтуудыг бас тал талд ингэж үргүй ашиглаж болохгүй юм байна гэдэг үүднээс бид нар энэ цахимжилтыг хасаж байгаа. Тухайн үедээ бол Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэлтэй энэ саналыг ойлголцож зөвшилцсөн. Ингээд хууль сахиулах шүүх эрх мэдлийг дэмжих, цахимжилтыг дэмжих ерөнхий хуулиа бид нар эхлээд намрын чуулгандаа оруулж ирээд, уг асуудлаа сууриар нь шийдчихье гэдэг зүйл 1 дүгээрт байж байгаа.

2 дугаарт хасаж байгаа тэр заалтыг сая Энхбаяр гишүүн хөндөж л байна л даа. Өөрөөр хэлэх юм бол энэ хуулийн амин сүнс буюу нэг бол үнэхээр хэргийн бодит үнэнийг тогтоогоод хангалттай үндэслэл байна гэвэл ялла. Үнэхээр тэр хүн дээр буруутгах бололцоо байхгүй бол цагаатга гэдэг зарчмыг баримтлах үүднээс хэргийг ямар нэгэн байдлаар шүүхээс дамнуулан шат шат руугаа шилжүүлэх байдлаар прокурор луу буцаадаг заалтууд орж ирснийг бол бид нар хасаж байгаа. Өөрөөр хэлэх юм бол энд хүний эрхийг хангах томоохон алхмууд явах ёстой гэж бид үзсэн.

2 дугаарт өмгөөлүүлэх эрхийг хангах чиглэлд энэ хуулийн бас амин сүнс орж ирсэн юм байна лээ. Алтангэрэл сайдын бас барьсан бодлого энэ байсан байна лээ. Ер нь энэ хуулийн хувьд. Тэгээд бид нар бол жишээ нь өмгөөлөх эрх буюу мэтгэлцэх бүрэн бололцоог олохын хувьд хавтаст хэрэгтэйгээ танилцах хугацааг бас хөндөж орж ирсэн. Тэгэхдээ энийг бас эцсийн хэлэлцүүлэг дээр Энхбаяр гишүүн, Цогтбаатар даргын өгсөн чиглэлийн дагуу тодруулж авч үзнэ.

2 дугаарт энэ шүүхийн шатад бас тодорхой хэмжээний нотлох баримтуудыг гаргаж өгөх асуудлыг энэ хуульд заасан процессын дагуу өмгөөлөх талаас буюу гаргаж өгдөг бололцоог бас нээж өгч байна. Эргээд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр бас бодитой энэ хэргийг цаашдаа гэм буруугийн хурал руу орох үүднээс асуудлуудаа бас шийдвэрлэх гарц гаргалгаанууд бас нэлээн сайтар орж ирж байгаа гэх зэргээрээ энэ өмгөөлүүлэх эрхийг бас хангах, энэ чиглэлдээ бас нэлээдгүй өөрчлөлтүүд орж ирж байгаа.

2 дугаарт бас манай Өмгөөлөгчдийн холбооноос бас хэд хэдэн өмгөөлөгч оролцвол 1 нь заавал төлөөлж ярина гэдэг ийм заалтууд орсон. Энэ бол бас өмгөөлөх эрхийг нэлээн дордуулах ийм нөхцөл байдалтай байсныг бас энэ хуулийн төслөөс бас хасаж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Д.Амарбаясгалан: Сонгобайн Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ерөнхийдөө дэмжиж байна. Тэгэхдээ 4 асуулт байна.

5.1 дүгээр зүйлийн 2.11 дэх хэсэгт цахим хавтаст хэргийн мэдээллийн системд нэвтэрч хэргийн материалтай танилцах гэж шинээр заалт болгон нэмж байгаа юм байна. Цахим мэдээллийн системийн аюулгүй байдлыг гаднын халдлагаас хэрхэн хамгаалах тухай урьдчилан сэргийлэхээр авч байгаа арга хэмжээ байна уу.

2 дугаарт Процессын хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ашиг холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ хэмээн хуульчилсан. Энэ хуулийн төслийн 16.3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож болохоор тусгасан байна. Мөрдөгчийг гэрчээс гэрчийн мэдүүлэг авах үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл гэдгийг хэрхэн ойлгох вэ. Хуулийг ийм ойлгомжгүй байдлаар хэрэглэх биш гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл хангалттай байгаа бол гэрчээр мэдүүлэг авчихвал зөрчих биш шууд сэжигтнээр мэдүүлэг авахаар зохицуулалт хийж болдоггүй юм уу.

3 дугаарт 12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг хууль санаачлагчийн зүгээс агуулгаар нь яг юу гэж ойлгож байгааг тайлбарлаж өгөхийг хүсье. Мөрдөгч эрх хэмжээнийхээ хүрээнд энд дурдсан ажиллагаануудыг хийж гүйцэтгэх юм уу, эсвэл прокурорын мэдэгдэх хуудсаар энэ ажиллагаануудыг хийж гүйцэтгэх юм уу.

4 дүгээрт 30.14 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт хэрэг бүртгэлийн хэргийг хаах саналаа прокурорт шилжүүлсэн хэргийн хянах хугацаа 14 хоног шаардлагатай тохиолдолд дээд шатын прокурор тухай бүр 14 хүртэлх хоногоор сунгаж болно гэсэн байна. Тухай бүр гэдэг 14 хоногийн хугацаа гэдэгт хугацааны хязгаар байна уу. Эсвэл ээдрээт төвөгтэй гэсэн шийдвэрээр хэдэн ч удаа байсан хамаагүй ингээд сунгаад байх уу гэдэг ийм 4 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Сайнзориг гишүүн хариулт өгье.

Д.Сайнзориг: Замира гишүүндээ баярлалаа. 4 асуулт асуулаа. Цахимжилттай холбоотой зүйлийг би бас сая Соронзонболд гишүүний асуултад хариулсан. Ер нь энэ цахим хавтаст хэрэгтэй холбоотой асуудлыг цаашдаа явах нь бол зөв байгаад байгаа юм. Хууль зүй, дотоод хэргийн яам дээр Энхбаяр сайдын үед бас ажлууд нэлээн эрчимтэй явсан байх. Зөрчлийн хэргийг цахимжуулах ажил нэлээн дөхчхөөд байгаа юм. Хамгийн үр дагавар багатай хэсгээсээ уг нь цахимжуулалтын ажлыг хийгээд алдаа оноогоо бас нэг харчихъя гэдэг бодлого бол Хууль зүй, дотоод хэргийн яам дээр тухайн үедээ явж байсан. Энэ ажлууд бол явж байгаа. Үүний дараагаар бид нар энэ эрүүгийн хэргийг цахимжуулах асуудал энэ удаад ороод ирж байгаа юм. Гэхдээ бид ажлын хэсэг дээр ярилцаад, яг таны ярьж байгаа энэ аюулгүй

байдал болон дундын мэдээллийн сан, хатуу, зөөлөн дэд бүтцийг хаана авч явах юм гэдэг энэ асуудлаасаа эхлээд ойлгомжгүй байгаа.

Өнөөдөртөө бол Нийтийн мэдээллийн ил тод байдал болон Кибер аюулгүй байдлын тухай хуулиар, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар энэ асуудлыг зохицуулж байгаа юм. Гэхдээ хангалттай биш. Энэ дээр илүү их нарийн зохицуулалтууд байна. Энэ хооронд өөрөөр хэлэх юм бол бас засаглал хоорондын эрх хэмжээний асуудал байхгүй юу. Шүүх эрх мэдэл дээрээс нь Засгийн газар, дээрээс нь манай өмгөөлөх байгууллага гэхэд бол яг төрийн байгууллагадаа ордоггүй. Тэгэхдээ нийтийн эрх зүйн этгээд гэх мэт энэ байгууллага хоорондын уялдаа буюу үүсэж байгаа мэдээллийг хэрхэн яаж ашиглах вэ гэдэг асуудлыг бие даасан хуулиар эхлээд тодорхой болгож орж ирсний үндсэн дээр уг асуудлыг ярьж гээд бид нар төслөөс бас таны хөндөж байгаа зүйлийг хасаж байгаа.

2 дугаарт яах вэ зүгээр гэрчээр байцааж байгаад ерөнхийдөө ингээд яллагчид гэдэг тохиолдлууд гарсан. Яах вэ хууль хэрэглээний л явц. Дээрээс нь яах вэ манай иргэдийн бас эрх зүйн мэдлэг ухамсраас болдог. Өөрөө өөрийнхөө болон гэр бүлийнхээ гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй боловч зарим талаараа энэ зүйл нь явж байгаад өөр дээр нь явчихдаг тохиолдлууд байгаа юм. Уг нь энэ эрүүгийн шинэ процессын хуулийн гол амин сүнс бол үнэхээр хүнийг сэжигтнээр ч гэдэг юм уу, тодорхойгүй байдлаар мөрдөгчийн тогтоолоор байлгаад байдаг байдал байхгүй. Үнэхээр тухайн гэмт хэрэг холбогдуулж шалгах асуудал байвал, нотлох баримт байвал яллагдагчаар шууд татаж шалгадаг энэ байдал руу орсон юм байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүд бол цаашдаа хуулийг нэг мөр хэрэглэх асуудал явна.

Би яг хууль санаачлагчийн өмнөөс бол зарим заалтуудыг тайлбарлаж чадахгүй байна. Таны хувьд. Яг санаачлагч ямар байр суурьтай байгаа вэ гэж хэрэгжиж байгаа хуулийг асуусан байна лээ. Энийг бол танд дараа нь бас манай ажлын хэсгээс хэлэх байх.

Тэр хэргийг хэрэгсэхгүй болгох, хаах асуудал дээр тухай бүр гэдгийг бид нар хасаж байгаа. Яг таны энэ хөндөж байгаа асуудлаар энэ бас ойлгомжгүй буюу ерөөсөө хаагдахгүй ч юм шиг ийм нөхцөл байдлууд байгаа. Бид нар бас Байнгын хороо, ажлын хэсэг дээр нэлээн сайн яриад уг асуудлыг бас хөндөж орж ирсэн гэдэг зүйлийг бас танд хэлье.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Улсын Их Хурлаас энэ хүн төвтэй хүний эрхийг хангасан ийм хууль, тогтоомжуудыг гаргах энэ чиглэлээр түлхүү их санаачилга гаргаад ажиллаж байгаа. Энэ хүрээндээ Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хууль бол өөрөө энэ хүний эрхийг хангах тал дээр нэлээн бас сайжирсан ийм өөрчлөлтүүд орж байгаа гэж ойлгосон. Тэгэхээр би ажлын хэсгийн ахлагчаас 1 зүйл асууя.

Энэ 2.7 дахь заалт дээр энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу хуулбарлан авах зорилгоор зураг, дууны дүрсний, дуу дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглана гэж байгаа юм. Энэ дээр нөгөө нэг мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаад дууссаны дараа хэргийн материалуудтай оролцогч холбогдогч нар танилцдаг. Ингэхэд нөгөө гар утсаараа энийг хуулбарлаад бичээд авч болох юм уу.

Энийг ингэж ойлгох юм уу. Аль эсвэл юуг хэлж байгаа юм бэ гэдэг энийг илүү жоохон тодорхой хэлж өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нь тэр 16.3 3 дугаар зүйлийн 10, 11, 12 дээр гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна гээд. Ер нь байна шүү дээ. Энэ процессыг нь Хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмгөөлөгч авахад нөгөө хэрэгт оролцогч өөрөө холбогдогч өөрийнхөө сонголтоор аваад байгаа юм. Нэг бол авч болно. Эсвэл авахгүй байж болно гэдэг. Энд ер нь заавал авна гэдэг ийм зүйл оруулж болох уу. Тийм юм байж болдог жж. Би энэ хуульч гишүүдээсээ хуульч гишүүний хувьд тодруулж байгаа юм. Энэ дээр яадаг вэ гэхээр мөрдөн шалгах байгууллагууд бол яг үнэндээ ялангуяа албан тушаалтнуудтай холбоотой хэрэг шалгаж байх явцад бол мэргэжилтэн доод тушаалын албан тушаалтнуудаас мэдүүлэг байцаалт авдаг. Ингэхдээ бас айлгах сандаргах, хөтлөх, янз бүрийн асуудлуудаар үг унагахыг оролддог. Тэр унагасан үгийг хэрэг болгоод явж байгаа ийм тохиолдлууд байгаа. Тэгэхээр зэрэг заавал өмгөөлөгчтэй байна гэдэг ийм асуудлыг тусгаж болох уу гэдэг ийм зүйлийг би тодруулж байгаа юм.

3 дугаарт Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Данзанноров Ерөнхийлөгчөөс 1 зүйл асууя. Ер нь танайх энэ өмгөөллийн төв байгууллага. Ер нь энэ хууль хяналтын байгууллагууд, өмгөөллийн байгууллагууд хоорондоо энэ мэтгэлцээний эрхийг хангах энэ эрхийг нээж өгөх тал дээр энэ хуульд хэрхэн өөрчлөлтүүд орсон бэ. Танай байгууллагаас оруулсан саналууд энэ хуулийн өөрчлөлтөд бүрэн дүүрэн тусаж чадсан уу, үгүй юу гэдэг дээр бас хариулт авъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс хариулт өгье. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Мөнхбат гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Энэ дээр бас нугалаа үүсээд байгаа юм байгаа юм. Өнөөдөр энэ хуулийн бас амин сүнс болсон өмгөөлүүлэх эрхээ хангах, хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал бол хэргийн хавтаст хэрэг болон нотлох баримтуудтайгаа танилцаж, тэдгээрийг төрийн нууцад хамаарахаас бусдыг нь хуулбарлаж авах эрхийг баталгаажуулж өгч байгаа асуудал байгаа. Гэтэл зарим хууль сахиулах чиглэлийн буюу мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагууд маань орохоос нь эхлээд гар утсыг нь хураагаад авчихдаг асуудал байдаг. Энийг бас манай ажлын хэсгийн гишүүн Баасанжаргал гишүүн энэ тэр нэлээн ярьсан. Бид хэд гар утас энэ тэр гээд энэ хууль дээрээ, текст дээрээ нэмээд дурдаад биччихье гэхээр зарим техникүүд нь үлдчих гээд байгаа юм. Тэгэхээр яг таны ярьж байгаа шиг бусад тэр техник, тоног төхөөрөмж гэдэг дотор гар утас, таблет болон яг энэ зориулалтаар ашиглаж болох тэр өмгөөлөгчид хамаатай эд зүйл орно шүү гэдэг зүйлийг бид нар протоколын хувьд энэ чуулганы нэгдсэн хуралдаан дээрээс хариуцлагатайгаар бас үлдээх нь зөв байгаа юм. Ингэж хуулийг зөв хэрэглэхгүй бол одоо яг энэ өмгөөлөх гэдэг юм уу, үйлчлүүлэгчийнх нь эрхээ хамгаалах үүднээс ингээд явдаг бараг нэмэлтээр ийм зургийн аппарат авах шаардлага ч юм уу үүсчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нөхцөл байдлуудыг бол цаашдаа хууль хэрэглээний явцад битгий нугалаа гаргаасай гэдэг зүйлийг би мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууддаа бас хэлмээр байгаа юм. Протоколын хувьд.

2 дугаарт энэ таны ярьж байгаа шиг гэрчээр асууж яваад ингээд шууд яллагдагчаар ч юм уу, сэжигтнээр асуудлуудыг хөндөөд явчихдаг энэ асуудал байгаа. Тэгээд ийм асуудлууд байх юм бол хууль зөрчиж үнэхээр авсан нотлох баримтуудыг бол хавтаст хэрэг дээр хэдийгээр тусгасан ч гэсэн үнэлэхгүй байх, хасах асуудлыг бол энэ хууль дээр тодорхой заачихсан байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт хүн бол өөрөө өөрийнхөө эсрэг болон гэр бүлийнхээ гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуулийн эрхээ баталгаатай эдлэх тэр боломжийг бид нар иргэдийнхээ эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар олгох нь зөв байгаа. Би Улсын дээд шүүхийн шийдвэрийг бол санахгүй байна. Улсын дээд шүүх сая маш чухал шийдвэр гаргасан. Яг таны энэ 2 дахь асуудалтай холбоотойгоор гэрчээр асууж байгаад, ямар нэгэн байдлаар хууль зөрчиж асуугаад түүнийг яллах талын байр суурь гэдэг юм уу, яллах нотлох баримт болгож явж байгаа энэ асуудлыг бол цаашдаа үнэлэхгүй гэдэг зүйлийг Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлаараа тогтоол гаргасан байна лээ. Энэ ингээд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг цаашдаа хангасан гэсэн үг. Тэгэхээр энэ таны ярьж байгаа зүйл бас цаашдаа хөндөгдөхгүй байх.

Өмгөөлөгчийг заавал авах тохиолдлыг эрүүгийн процессын хуулийн 5.3 дээр заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн болон хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байгаа өсвөр насны, Монгол хэл бичиг мэдэхгүй бүх насаар хорих ял оногдуулж болох хэрэгт татагдаж байгаа, хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, 1 өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч заавал авах ёстой гэх зэрэг 6 үндэслэлийг бол заавал тохиолдлуудад заасан байгаа. Энэ өмгөөлөгч авна гэдэг бол тэр эрх зүйн үр дагавар буюу тухайн асуудал дээр оролцож байгаа хүний бас хувь заяатай холбоотой учраас Монгол Улсын Үндсэн хуульд заасан .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Сайнзориг: Үндсэн хуульд заасан тэр хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөх эрхийг нь хангаж байгаа бас сайн хүний эрхийг хангах шийдэл байгаа шүү. Тэгэхээр энийг төвөг гэхээсээ илүүтэйгээр та өөрөө ингээд яг цаг тухайд гэдэг юм уу тухайн иргэн маань өмгөөлөгч заавал авмаар байна гэх юм бол улсын өмгөөлөгчөөр бас хангах тийм бололцоо байдаг юм гэдэг зүйлийг би бас ингээд хариултын явцад хэлье.

Энэ ташрамд сүүлийн 20 секунд дээр бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр миний яриагүй зүйлийг бас мушгиж холбогдох гишүүдийг бас нэр төрд халдаж байгаа учраас ингэхээ болиоч гээд би Пүрэвдорж дарга болон Номинчимэг гишүүдээсээ бас уучлалт хүсэж байна. Үнэхээр тэр янз бүрийн байдлаар яриагүй зүйлийг постер болгож явуулаад байхад хэцүү юм. Энэ зарим зүйл дээр үзэл бодлын зөрөөнөөс болж хэлж байгаа зүйл байгаа боловч яриагүй зүйлээр ийм буруу мэдээллийг бас түгээж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагадаа бас хариуцлагатай байгаач гэдэг зүйлийг бас хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Сайн байна уучлалт гуйгаад. Өмгөөлөгчдийн холбооноос хариулт өгье. Өмгөөлөгчдийн холбооны тэргүүн Данзанноров. 3 дугаар индэр.

Л.Данзанноров: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн Их Хурлын 18 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бас эрх тэгш мэтгэлцээний нөхцөлийг хангах, өмгөөлөгч, прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох энэ бүрэн эрхийг тэнцвэржүүлэх чиглэлээр нэлээд чухал өөрчлөлтүүд орсон. Хэрвээ зүгээр энэ шинэчлэлийг нэлээд цогц хүрээнд хийнэ гэвэл цаашдаа судалгаа, илүү олон зүйл заалтуудыг бас хөндөх шаардлагатай. Гэхдээ энэ ажлын хэсэгт бол нэлээд олон байгууллагын төлөөлөл оролцуулж, нэлээд олон ургалч үзлийн хүрээнд маргаан мэтгэлцээнтэй явсан нэлээд зүйлүүд байгаа. Хэдийгээр манай холбооноос орсон зарим нэг саналын тухайд бас хуулийн төсөлд тусгагдаж амжаагүй, тусгагдаж чадаагүй ганц нэг санал байгаа. Тухайлах юм бол урьдчилсан хэлэлцүүлгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буцах зохицуулалт дээр нэг чухал зохицуулалт байсан нь хасагдсан. Тэр нь юу вэ гэхээр 33.1.4 гэсэн заалт. Энэ нь бол 33.1.4-д.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут гүйцээж хариулъя.

Л.Данзанноров: Төслийн 10.9-д заагдсан урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг буцаах зохицуулалт дээр бол 32 дугаар зүйлийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагааг бүрэн хийгээгүй бол буцах. Энэ нь бол зөвхөн хэргийн материалыг танилцуулах төдийгөөр хязгаарлагдахгүй. Энд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоод, хэргийн материалтай танилцаад, энэ ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлээгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буцаах, прокурорт хэргийг буцаах зохицуулалт байсан нь бол төсөлд тусгагдаж чадаагүй гэх мэт нэлээд асуудлуудыг олон талаас нь ярилцсан.

Гэхдээ ерөнхий утгаар нь авч үзэх юм бол хүний эрхийг дээрдүүлэх, өмгөөлөгчийн эрх боломжийг нэмэгдүүлэх чиглэл дээр нэлээд үр дүнтэй өөрчлөлтүүд бас орсон байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо намын бүлгүүдээс болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсээр үг хэлэхээр байгаа. Энэ чинь зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж хэлэх үг тийм ээ. Гишүүд танхим цуглая. Санал хураалт эхлэх учиртай байгаа 1 дүгээрт.

2 дугаарт Түвшин нарын 41 гишүүн гарын үсэг зурсан Нийгмийн даатгалын хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл дараа нь хэлэлцэнэ. Гарын үсэг зурсан 41 гишүүн орж ирэхгүй бол хэлэлцэх эсэхээ бас хэдүүлээ бодох болох нь байна. Гишүүд үг хэлье. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн индрээс үг хэлнэ. 2 дугаар индэр. Суудлаасаа хэлэх юм байна. Уучлаарай.

Х.Баасанжаргал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд би бас яагаад зориуд үг авсан юм гэвэл энэ хууль тогтоомжид орж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орж байгаа зарим зохицуулалтууд бас зөв хэрэглэгдээсэй гэж үзэж бас энэ протоколын дагуу зарим нэг зүйлүүдийг зориуд тэмдэглэж үлдээж байгаа юм. Тэгээд манай хуульчид бас энийг хууль хэрэглээнийхээ явцад анхаарах ёстой гэж хэлж байгаа.

1 дүгээрт энэ нууцлан гардуулна гэдэг зохицуулалт прокурорын яллах дүгнэлт болон шүүхийн шийдвэр дээр аль аль дээр нь нууцлан гардуулна гэдэг ийм

зохицуулалт орж ирсэн байгаа. Ажлын хэсгийн явцад бол энэ нууцлан гардуулах дээр 2, 3 өөрөөр бид нар ойлгож, хоорондоо нэлээн ярилцсан. Би бол хувь гишүүнийхээ хувьд төрийн нууцтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон хүн бол энэ яллах дүгнэлтээ бүрэн дүүрэн авах, тэртээ тэргүй нууцын баталгаа гаргаж байгаа учраас энэ нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээж байгаа учраас энэ материалыг нууцын баталгаа гаргаад, прокурорын яллах дүгнэлт, шүүхийн шийдвэрийг бол гардаж авах ёстой гэдэг байр суурьтай байсан. Гэхдээ ажлын хэсгийн олонхын саналаар энэ хэсгийг нь нууц мэдээллийн хэсгийг нь дараад урьд нь бол огт хасдаг байсныг нь болиод, 1 хэсэг тухайн өгүүлбэр, тухайн хуудас ч байдаг юм уу ингэж харлуулж дараад яллах дүгнэлт, шүүхийн шийдвэрийг гардуулж өгнө гэдэг байдлаар энэ агуулга орсон гээд.

2 дугаарт цагдан хорих асуудлыг бас хэлэх ёстой. Бид нар үйлчлүүлэгчийнхээ цагдан хорионы хуралд орохын өмнө энэ хүнийг яагаад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах гэж байгаа юм бэ гэдгийг огт өмгөөлөгч нар мэдэхгүй ордог. Шүүх хурал дээр орсон хойно прокурорын саналтай танилцдаг. Ямар нотлох баримт байгаа вэ гэдгийг танилцаж чаддаггүй ордог. Энэ чинь ерөөсөө цэвэр өмгөөлөгчөөр хангах, мэтгэлцэх зарчмыг ерөөсөө хангахгүй байгаа зохицуулалт гэсэн үг. Тийм учраас энэ удаагийн хууль дээр цагдан хорих, таслан сэргийлэх, цагдан хорих арга хэмжээ авахдаа прокурорын санал, холбогдох нотлох баримттай танилцана гэдэг агуулгаар орсон. Энэ дээр бас урьдчилж танилцах уу, яг хурал дээр танилцах уу гэдэг дээр ажлын хэсгийн явцад бол нэлээн ярилцаад, ямар ч байсан өмгөөлөгчид мэтгэлцэх боломж олгож танилцуулна гэдэг агуулгаар танилцана гэдэг заалт орсон шүү. Тэгэхгүй хурал дээр танилцуулаад, эсвэл хурлын дараа юу гэдэг юм нотлох баримт мэдээллүүдийг хэлээд, яг хурал дээр дандаа сюрприз барьчхаад, түүнийгээ танилцуулсан гэж. Ингэж цаашид хуулийг хэрэглэхгүй. Тэгэхээр энэ дээр манай прокурор болоод шүүхийн байгууллага анхаарах ёстой.

Хамгийн сүүлд нь 3 дугаарт түрүүн Данзанноров Ерөнхийлөгчийн хувьд 1 зүйлийг яг хэлэх гээд зарим нэг зүйлийг жоохон дутуу орхигдуулчихлаа. Би тэрийг нэмчихье. Прокурорын шатад гомдол гаргах процесс яг үнэн хэрэгтээ амьдрал дээр огт хэрэгждэггүй. Прокуророос яллах дүгнэлт гардууллаа, хэргийн материалыг тэр дор нь шүүх рүү шилжүүлдэг. Яллах дүгнэлттэй холбоотой гомдлыг өмгөөлөгч гаргахаар гомдлыг чинь хэрэгтэй нь хамт шүүх рүү явуулчихсан, шүүх дээр очоод шийдүүл гэдэг. Аль болох энэ процессыг бид нар прокурорын шатдаа гомдол гаргасан бол тэрийг нь хянан шийдвэрлэж дууссаны дараа хэргийг шүүх рүү шилжүүлнэ гэдэг ийм зохицуулалт оруулах гэж оролдсон боловч харамсалтай нь цөөнх болоод ажлын хэсэг дээр оруулж чадаагүй.

Тэгэхээр энийг би зориуд бас протоколын хувьд бол тэмдэглэж үлдээх ёстой гэж бодож байна. Харин прокуророос шүүх рүү хэргийн материалыг шилжүүлэхдээ 3 хоног, 3-аас доошгүй хоногийн дараа хэргийг шилжүүлнэ гэдэг ийм хоног хугацаатай холбоотой зохицуулалт орсон. Мэдээж тодорхой хэмжээгээр дээрдэж байгаа. Гэхдээ өмгөөлүүлэх эрх бол бүрэн дүүрэн хангаж чадахгүй хэвээрээ бас ийм зохицуулалт үлдэж байгаа шүү гэдгийг протоколд тэмдэглүүлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Өнөөдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэлээн зарчмын том хэмжээний өөрчлөлтийг бид хэлэлцэж санал хураах гэж байна. Энэ өөрчлөлтийн намтарчилсан түүхийг би товч дурдах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Протоколд тэмдэглэх ёстой. Үзэл санаа бол юунаас урган гарсан бэ гэхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж байгаа асуудал дээр маш олон хүний эрх зөрчигдөж байна. Энэ үе шатан дахь хүний эрхийг яаж илүү ахиулах вэ гэдэг дээр олон талаас нь бид ярилцаж байсан. 2023 оны хаврын чуулганы төгсгөлд Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан, илтгэлийг бид яг энэ чиглэлээр хэлэлцсэн юм. Ингэж хэлэлцэхдээ анх удаа хүний эрхийн тайлан илтгэлийг сонсгол байдлаар хэлэлцсэн юм. Сэдэв болгоноор нь, 2 өдрийн турш.

Үүний хүрээнд энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа дахь хүний эрхийг зөрчигдөж байгаа байдлыг таслан зогсоож ахиулах дээрх комиссын санал, дүгнэлтийг сонсгол хэлбэрээр сонсоод, үүний мөрөөр хууль тогтоогч яаж, юун дээр шинэчлэл хийх вэ гэдэг дүгнэлтийг өгсөн. Улмаар Хууль зүйн байнгын хороо тухайн үед Мөнх-Оргил гишүүн санал гаргаж, Цогтбаатар Байнгын хорооны дарга дэмжиж, Засгийн газарт тодорхой чиглэл өгсөн. Энэ чиглэлийн утга санаа, үзэл санаа бол процесс дахь харилцан чек баланс буюу харилцааг хяналт тэнцвэрийн зарчмыг хангах замаар хүний эрхийг хамгаалах юм байна гэж үзсэн юм.

Өөрөөр хэлбэл зөвхөн мөрдөгч яллах тал тэнд илүү зонхилгогч байр суурьтай байгаад байгаа учраас тэнд хонгил үүсээд байна. Тэнд хэлмэгдүүлэлт үүсээд байна. Тэнд хүний эрх зөрчигдөөд байна. Энийг нөгөө талд нь яаж балансжуулах вэ гэхээр өмгөөлөх талын эрхийг илүү дээшлүүлж адил биш юм гэхэд дүйцүүлэх хэмжээнд очуулж байж бид нар процесс дахь шударга ёсны зарчмыг хангах юм байна гэж үзсэн юм. Ингээд яг миний бие Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсоны дараа 2 дахь үе шатынх нь хүрээнд нь энэ өөрчлөлтийг 2024 оны 5 сард Улсын Их Хуралд өргөн барьж байсан ийм өөрчлөлт байгаа юм.

Улсын Их Хурлын шинэ дэгийн дагуу шинэ парламент үүссэнтэй холбоотойгоор бүх Улсын Их Хуралд өргөн баригдсан байсан төслүүд буцаагдаад, улмаар 2025 оны 3 сард Алтангэрэл сайд энэ өөрчлөлтийг дахин Улсын Их Хуралд өргөн барьж, өнөөдөр бид анхны хэлэлцүүлгээ хийж явж байгаа. Энэ хууль батлах бол нэг хэрэг гэдгийг бол бид маш сайн мэднэ. Хууль амилах эсэх бол Чимэд багшийн хэлсэнчлэн хүнээс хамаарна. Муу хүн сайн хуулийг утгыг нь алдуулж чадна. Муу хүн сайн хуулийг. Сайн хүн муу систем дээр очоод бас чөтгөр ч бол болдог. Тийм учраас бид нар процесст хүний эрхийг ахиулах чиглэлд яг талыг нь хийж байгаа. Одоо үлдсэн нь үүнийг хэрэгжүүлэх, өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүх, мөн иргэдийн эрх зүйн ухамсар гэсэн олон талын оролцоотойгоор хийгдэнэ. Энэ үйл ажиллагаа бол нэг удаагийн амьсгаагаар хийгдэхгүй. Үргэлжилсэн тасралтгүй, байнгын хичээл зүтгэл, тэмцэл, сургалтууд гэсэн олон үе шатуудаар хийгдэнэ. Тэгэхдээ бид нар хуулийг баталж байгаа энэ хуулийг өнөөдөр Хуулийн сургуулийн 2 дугаар курсийн оюутнууд шинэ хуулийн дагуу хичээлээ заалгана. Тэр оюутнууд 5 жилийн дараа төгсөөд, 5 жилийн дараа энэ хуулийг хэрэгжүүлнэ, амилуулна. Тийм учраас бид нар 10 жилийн урт хугацааны тэмцэл хийж байж энэ хуулиа амилуулна шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье ирц бүртгээдэхье. Санал хураалтад бэлдье. Ирц бүртгэлийн санал хураалт явуулж үзье. Санал хураалт. Санал хураалтад орж амжаагүй гишүүд гараа өргөө. Гончигдоржийн Уянгахишиг, Буланы Бейсен, Пунсалмаа гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Сүрэнжавын Лүндэг, Отгоншарын Батнайрамдал нарын гишүүд байна. Дахиад ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Гишүүд Батнайрамдал наад уншиж байгаа юмаа түр болиод, саналаа өгөөдхөөч. Санал хураалт. Байнгын

хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа зарчмын зөрүүтэй 27 санал байна. Гишүүд ажлын хэсгийн хуралдаанд байгаа гишүүдийг дууд, санал хураалтад оръё. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлэх боломжтой.

Би зарчмын зөрүүтэй саналыг уншиж эхэлье.

Эрүүгийн хянан хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Гишүүд нэлээн хэд ороод ирэх шиг боллоо. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Дахиад бэлтгэл хангая. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалтад орж чадаагүй гишүүн хэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал, Сайнбуянгийн Амарсайхан, Жудагийн Баярмаа, Батбаярын Жаргалан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн ингээд үндсэндээ 55, 56 хувь боломжтой болж байна. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Алтанхуяг, Бат-Амгалан, Баасанжаргал, Нарантуяа-Нара, Отгонбаяр Сандаг-Очир, Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар цаашид /ажлын хэсэг/. Санал хураалт. 56 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 5 дахь хэсгийн “бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар” гэснийг “материалтай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57 гишүүн буюу 57 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56 гишүүн буюу 56 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14 дэх хэсгийн “шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт 56 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 5 дахь хэсгийн “гомдлыг” гэсний дараа “энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 60 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/16.14 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9 дэх хэсэг:

“5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч, мэргэжилтний хийсэн үйлдэл, үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болно.

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 гишүүн буюу 59 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 8 дахь хэсгийн “зохих” гэснийг, мөн хэсгийн “тухай бүр” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 61 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалтын 3 дахь хэсгийн “оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг” гэснийг “оруулсан тогтоолыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 61 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “хамаарах хэсгийг нууцлан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагч Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг өгье.

П.Сайнзориг: Дарга аа, энийг болон дараагийн 3 заалт байгаа. Энийг та гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэж хүсэж байгаа юм. Түрүүн Баасанжаргал гишүүн бас яг энэ текст дээр ярихаар 3 ч өөр ойлголт гарчихлаа гэдэг зүйл бас яригдсан. Тэгээд эхний санал маань энэ асуудлыг хөндөж ярилцахаас өмнө хураагдаад, 2 санал хоорондоо зөрчилдсөн учраас бид хэд нэгдсэн байдлаар хураагаад явчихсан. Тэгэхээр одоо та бас яг зохих журмын дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгчихвөл бид хэд ярья гэж байгаа.

Гол асуудал юу вэ гэхээр ер нь зүгээр нөгөө хавтаст хэрэгтэйгээ бүрэн танилцах, яллах дүгнэлттэйгээ бүрэн танилцаад өөрт хамаатай эсэхийг хуулбарлан авах хэрэгтэй байгаа юм. Гэтэл төрийн мэдээлэлтэй хэсгүүдийг яллах дүгнэлт юм уу, шүүхийн шийдвэрийг гардуулахдаа хасаад өгчихдөг юм. Практикийн хувьд, өнөөдөр. Тэгэхээр бид хэд ер нь тэгэхээр хүмүүс нөгөө яллах дүгнэлт, шүүхийн шийдвэрийн хувьд тэр хуудасны зөрүү гаргаад ингээд намайг зөрүүтэй байдлаар ялласан. Нэмж үзэмжээрээ баахан үндэслэлүүд нэмж байгаад яллагчигдсан юм шиг дараа нь маргаан гардаг. Шүүх эрх мэдэлд бас итгэх итгэлийг бас алдагдуулдаг ийм зүйл байдаг. Тэгэхээр энэ дээрээ бид нар уг гардуулж өгөхийг нууцлаагүй. Тэр төрийн нууцтай хэсгүүдээ техникийн шийдлийн хувьд нууцлаад өг гэдэг текстийг оруулж ирэх гэж байсан боловч жоохон агуулгын хувьд зөрчлүүд байгаа учраас бид хэд найруулга дээрээ энийгээ ярилцаад ороод ирье гэж байгаа юм. Тэгэхээр энэ 10 дугаар саналыг та гүйцээн болгох чиглэл өгнө үү гэж хүсэж байна. Санал дээр хэлээд явах дэгтэй юм болов уу даа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүний саналаар, ажлын хэсгийн ахлагчийн саналаар 10, 11, 12, 13 гэсэн 4 ... дугаарыг нь хэл дээ. Сайнзориг гишүүн ахиж үг өгье. Дугаарыг нь хэлээдэх дээ.

П.Сайнзориг: 10, 15, 16. 16 биш шүү. Уучлаарай 10. 15.

Д.Амарбаясгалан: 10 дугаар зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгье.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 61 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 58 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын “бусад баримтыг” гэсний дараа “энэ хуульд заасан журмын дагуу” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 1.8 дахь заалтын “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57 гишүүн буюу 57 хувиар санал дэмжигдлээ.

15 дахь санал хураалтыг санал гаргасан ажлын хэсэг гүйцээн боловсруулах чиглэл авъя гэсэн. Гүйцээн боловсруулахаар чиглэл өглөө.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалтын 8 дахь хэсгийн “хавсаргуулна” гэснийг “хавсаргаж болно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 15 дахь заалтын 9 дэх хэсгийн “оролцогч” гэсний дараа “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 4 дүгээр зүйлийн “34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төлөөлж болно” гэснийг “төлөөлнө” гэж”, гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 гишүүн буюу 62 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн, 3 дугаар зүйлийн “зүйл” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийн “заасны” гэснийг “заасан журмыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 61 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шинжээч” гэсний дараа “сэжигтэн,” гэж” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 гишүүн буюу 63 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын “2.12” гэснийг “2.13” гэж, мөн зүйлийн 7 дахь заалтын “5” гэснийг “6” гэж, мөн зүйлийн 13 дахь заалтын 6 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 гишүүн буюу 62 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17” гэснийг “2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16” гэж, мөн зүйлийн “31.2 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.2 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа” гэснийг” гэж, мөн зүйлийн “31.3 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.3 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах” гэснийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62 гишүүн буюу 62 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 34.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг. Санал гаргасан гишүүнд үг өгье.

О.Номинчимэг: Энэ санал түрүүн би асуулт асуусан. Ер нь бол ийм болхи заалт байгаа юм. Тэгээд шүүх хуралдаан хойшлуулахгүй гэдэг зорилгоор зүйл заалтын дунд шумуул маш хортой үр дагавар гаргахаар байгаа. Юу вэ гэвэл шүүгдэгч өөрөө тэр өмгөөлөгч маань чадваргүй ч юм уу, өөрийнх нь эрх ашгийг хамгаалахын төлөө яваагүй ч байдаг юм уу ийм ямар ч нөхцөл байж болно. Өмгөөлөгчөө сольсон тохиолдолд шууд шүүгч үзэмжээрээ улсын өмгөөлөгч томилох эрх зүйн үүд хаалгыг нээж өгч байгаа. Энэ дээр шүүх хуралдааныг хойшлуулахтай хэсэг дээр байгаа ч гэсэн яг энэ шалтгаанаар байна уу, үгүй юу ерөөсөө хамаагүй. Хууль зүйн хувьд техникийн маш буруу зүйл, заалт орж ирсэн. Буруу газраа байна. Тэгээд ийм нэмэлт үр дагавар оруулж ирж байгаа. Тэгэхээр энийг гишүүд дэмжихгүй байж өгч дэмжиж өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хууль зүйн техникийн хувьд буруу зөрүү гэдгийг нь бол яг хэлж мэдэхгүй байна. Тэгэхдээ 1 их зөрчилдөөд байгаа юм байхгүй. Би тэгэхээр Улсын Их Хурлын даргаас Номинчимэг гишүүний гаргасан энэ санал, дараагийн 2 дэмжигдээгүй саналыг Хууль зүйн байнгын хороонд гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэж хүсэж байна. Би хэд нэг сайн ярилцаадахъя. Өөрөөр хэлэх юм бол асуудлууд байвал дахиж нэг нягталчихъя.

Дэмжигдээгүй 2 санал маань бас өмнөх тайлбартай 1 нь хамаатай байгаа. Дэмжигдээгүй 3 дахь санал бол бас нэлээн энэ хуулийн үзэл баримтлалд хамаатай зүйл ажлын хэсгээс орсон уу, үгүй юу гэдэг дээр бас холбогдох гишүүд маань яриад байгаа юм. Бид хэд бол энэ хууль зөрчиж авсан нотлох баримтыг бол нотлох баримтаар тооцохгүй гэснээсээ гадна мэдүүлэг тайлбар өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болохгүй гээд нэлээн том концепцын өөрчлөлт бол хийж байгаа. Агуулгын хувьд бол эрүү шүүлт тулгах гэмт хэрэг гэдэг юм уу ийм зүйл гарахгүй байхад маш зөв заалт боловч аль аль заалтуудтай цаашдаа уялдаж хөндөгдөх ёстой вэ гэдэг зүйлээ бид хэд бас ярилцах зайлшгүй шаардлага байгаа юм. Тэгээд Номинчимэг гишүүн бас татгалзахгүй байх гэж бодож байна. Энэ 3-ыг гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй зарчмын зөрүүтэй 3 саналыг гурвуулааг нь гүйцээн боловсруулах чиглэл авъя гэж ажлын хэсгийн ахлагчийн зүгээс санал гаргаж байна. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 2 дугаар зүйлийн “2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс” гэснийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 гишүүн буюу 60,4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

15.42 цаг.

Өмнөх асуудлын санал хураалт руу оръё.

Төрийн албаны зөвлөлийн нэр дэвшигчтэй холбоотой асуулт Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Байнгын хорооны саналаар Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нууц санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Бадамцоогийн Идэрчулууныг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор томъёоллоор нууц санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтдаа бүрэн бэлдье. Хурууныхаа хээг уншуулъя. 60 гишүүн бэлтгэгдсэн юм байна. Нууц санал хураалт. 58 гишүүн буюу 57,4 хувиар дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Должингийн Баатарсайханыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 63 гишүүн буюу 62,4 хувиар санал дэмжигдлээ.

3.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 64 гишүүн буюу 63,4 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хот Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Цэнддаваагийн Амартөгс, Должингийн Баатарсайхан, Бадамцоогийн Идэрчулуун нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Одоо томилох санал хураалтыг явуулъя.

Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя аа. Санал хураалт 59 гишүүн буюу 58,4 хувиар дэмжигдлээ.

2.Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт 56 гишүүн буюу 55,4 хувиар санал дэмжигдлээ.

3.Бадамдоржийн Төгсцэнгэлийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. 61 гишүүн буюу 60,4 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2, 68.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох н5

1.Цэнддаваагийн Амартөгс, Лхагвасүрэнгийн Золзаяа, Бадамдоржийн Төгсцэнгэл нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.48 цаг.

Дараачийн асуудалд орёё.

“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалт явагдана.

Байнгын хорооны саналаар “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлдье. Энэ нууц санал хураалт явагдчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгохгүй бол болохгүй. Дэгээрээ ил санал хураалт явагдах ёстой. Тэгэхээр гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67 гишүүн буюу 66,3 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагч Лувсанжамц гишүүнд баяр хүргэе. Улсын Их Хурлын даргаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг богино хугацаанд ажиллаж чухал тогтоолын төслийг батлуулж авлаа. Түрүүн хэлсэнчлэн ижил төстэй батлагдсан олон тогтоолууд байгаа. Зүйл, заалт тус бүрээр нь авч үзэж, нэгтгэх ажлыг бас цааш нь үргэлжлүүлж хийгээрэй гэдгийг хэлье. Ингээд тогтоолын төсөл батлагдлаа.

15.51 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Түвшин нарын 41 гишүүн өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Түвшин: Монгол Улсын Их Хурлын гишүүд, хууль тогтоогч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж, амар мэндийг эрэн мэндчилье.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд суудалтай 5 нам, эвслийн төлөөлөл болсон бидний 41 гишүүд хамтран санаачиллаа. Энэ хуулийн төслийг дараах асуудлуудыг нэг мөр зохицуулж, хүн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, цаашлаад далд эдийн засгийг ил болгох, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд татвар, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг үр дүн, бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан боловсруулсан. Үүнд:

1.Өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулан ажил үйлчилгээ эрхлэх хүнийг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчаас хасах. Эдгээр гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ноогдох орлогын бүрэлдэхүүнээс хасах. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2008 оны 05 сарын 08-ны өдөр батлагдсанаар өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлүүдэд заасан ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажилласан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг нийгмийн даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээлгэж, эдгээр гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ноогдох орлогод хамруулан гэрээ байгуулсан аль аль тал нь тухайн хувь хүнд хамаарах нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх үүрэгтэй болсон. Үүгээр зогсохгүй 2023 онд батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ төдийгүй, тэдгээртэй адилтгах гэрээ байгуулан ажиллаж буй хүнийг албан журмаар даатгуулахаар нийгмийн даатгалын харилцааны хамрах хүрээг дахин өргөжүүлсэн.

Энэхүү хуульд ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээнээс гадна тэдгээртэй адилтгах гэрээ гэж гэрээний төрлийг өргөн агуулгаар зааснаар иргэний хуулийн ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон үүрэгт хамаарах буюу ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээтэй хамт яг нэг бүлэгт багтдаг нэрлэсэн болон нэрлэгдээгүй гэрээнүүд, тухайлбал аялал жуулчлалын, тээвэрлэлтийн, хадгалалтын, даалгаврын, илгээмжийн, жуулчлалын гэх мэт олон төрлийн гэрээгээр гүйцэтгэх бизнес аж ахуйн шинжтэй бүх төрлийн харилцаанаас олсон орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах болсон. Нөгөөтээгүүр Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу олсон орлого буюу татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, өмгөөлөл, хууль зүйн

туслалцаа үзүүлэх үйлчилгээ гэх мэт бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил үйлчилгээний орлого, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох, хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа, тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлого нь ХХОАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар үйл ажиллагааны орлогод хамаарч, тухайн үйл ажиллагаа буюу бизнес эрхлэгч нь уг орлогыг үйл ажиллагааны орлогоор тайлагнаж татвар төлөх зохицуулалттай.

Түүнчлэн эдгээр бизнес эрхлэгчид Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу жилд 50 сая төгрөгийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээг бусдад борлуулснаар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болж давхар татвар төлдгөөрөө нийгмийн гэрээний дагуу ажиллаж, хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж цалин хөлс авдаг ажилтнуудаас онцлог ялгаатайг Татварын хуулийн эдгээр зохицуулалтууд харуулж байна.

Энэхүү эрх зүйн зөрчил үүсгээд зогсохгүй хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээний дагуу олох орлогод ноогдуулах нийгмийн даатгалын шимтгэлийг гэрээ байгуулсан, төлбөр шилжүүлсэн нийт дүнгээс шууд тооцож байна. Хүнтэй байгуулах Иргэний хуулиар тодорхойлсон болон тодорхойлоогүй хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээний орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй болгосноор ажил олгогч, ажилтан хөдөлмөр эрхлэгчийн харилцаанд өөр гэрээ ашиглавал яах вэ гэдэг болгоомжлол байж болох юм.

Тэгвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэгт ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 4.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулсан боловч уг харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн шинжийг агуулсан бол түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно гэжээ. Эндээс үзвэл Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах ажил олгогч, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд хөдөлмөрийн гэрээнээс өөр буюу Иргэний хуулийн аливаа гэрээ байгуулахыг хориглох ба хэдий өөрөөр нэрлэсэн ч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжийг агуулсан байвал тухайн гэрээ нь хөдөлмөрийн гэрээнд тооцогдоно.

2. Ажил олгогчоос олгосон хоол, унаа, орон сууцын ашиглалтын төлбөр, түлээ нүүрс худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтийг цалин түүнтэй адилтгах орлого болон нийгмийн даатгалын шимтгэл ноогдох орлогын бүрэлдэхүүнээс хасах. 2008 оны 05 сарын 08-ны өдрийн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар анх ажил олгогчоос ажилтанд олгосон хоол, унаа, орон сууцын ашиглалтын төлбөр, түлээ нүүрс худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтөд нийгмийн даатгалын шимтгэл ноогдуулж одоог хүртэл үйлчилж байна.

Ажил олгогчоос ажилтанд олгож буй уг дэмжлэг нь ажилтны өдөр тутмын наад захын хэрэгцээ, амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, тэдэнд тулгарч буй нийгмийн эрсдэл, санхүүгийн ачааллыг бууруулах, хөнгөвчлөх зорилготой байдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ гэж заасан ба хоол, унааны төлбөр, түлээ нүүрсний хөнгөлөлт, орон сууцын ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого нь ажилтны цалин хөлсний орлогод хамаардаггүй. Иймд уг орлогод НДШ

ноогдуулахаар зохицуулсан нь эдгээр төлбөр хөнгөлөлтийг олгож буй үндсэн зорилготой нийцэхгүй байна.

3.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг даатгуулагчийн адил тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоох. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар заасан. Энэ хязгаар нь даатгуулагч цөөн хэдэн сард хэт өндөр дүнгээр шимтгэл төлснөөр тогтмол цалинтай нийгмийн даатгалын шимтгэлийг олон жил тасралтгүй төлж байсан иргэдээс илүү өндөр тэтгэвэр тогтоолгох боломжийг хаах зорилготой.

Тэгвэл ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд хязгаар тавиагүй. Тухайн даатгуулагчийн сарын нийт хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоор тогтоож байгаа нь даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас авах тэтгэвэр тэтгэмжийн хэмжээнд төдийлөн нөлөө үзүүлдэггүй бөгөөд ажил олгогч аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид ажилтны цалинг нэмэх боломжийг хязгаарладаг.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бодлогын өөрчлөлтийн нөлөөллийг зардал үр өгөөжийн шинжилгээ буюу cost benefit анализын аргаар зардлын бага, дундаж, өндөр хувилбар бүхий нөхцөлөөр тооцоход бүх хувилбарууд эерэг үр өгөөжтэй гарсан. Хуулийн төсөл батлагдаж, бодлогын өөрчлөлт гарсны нөлөөллийн үр дүнг өнөөгийн үнэ цэнээр тооцоход дунджаар 254 тэрбум төгрөгийн цэвэр үр өгөөжтэй байхаар байна.

Мөн 2025-2027 онд ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хассанаар 1508 ажлын байр, хоол, унаа, түлээ нүүрс, орон сууцын ашиглалтын зардлыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хассанаар 2479 ажлын байр, ажил олгогчийн хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээнд дээд хязгаар тогтоосноор 14371 ажлын байр, нийт 18358 ажлын байр нэмэгдэх тооцоолол гарсан.

Шинээр бий болсон ажлын байрны өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын орлогын өсөлт 2025-2027 онд дунджаар 242,1 тэрбум төгрөг байхаар байна. Харин макро эдийн засгийн үзүүлэх нөлөөллийг эс вар загвараар тооцоход ДНБ эхний жилд 973 тэрбум, 2 дахь жилд 820 тэрбум, 3 дахь жилд 695 тэрбум нийт 2,5 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна.

1.Хүн, хуулийн этгээдийн бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, эдийн засаг, хууль зүйн дарамт, эрсдэл буурч тэдгээрийн ашиг орлого, үйл ажиллагааны төрөл нэмэгдэнэ.

2.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх ачаалал буурснаар хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөнгөвчлөх боломж нэмэгдэж, тэр хэрээр ажилтны ачаалал хөнгөрч, худалдан авах чадвар сайжирч, ашиг орлого, хэрэглээ өсөж, улсын эдийн засгийн эргэлт сайжирна.

3.Ажил олгогчийн зардал багассанаар ажлын байр нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсөж, ажилгүйдэл буурна.

4.Бичил жүжиг, дунд бизнес эрхлэгчдийн зах зээл тэсэж үлдэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

5.Бараа ажил үйлчилгээний нийгмийн даатгалын шимтгэлийн зардал буурснаар эцсийн хэрэглэгч дээр ирэх үнийн нэмэгдэл буурна.

6.Хууль хоорондын зөрчил арилна.

Эдгээр эерэг үр дагаврууд гарснаар Монгол Улсын эдийн засаг тэлж, далд эдийн засаг ил болоход нөлөөлж, тэр хэрээр эдийн засгийн эргэлт сайжирч, татварын суурь өргөжиж, нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Энэхүү хуулийн төслийг 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр D-parliament.mn цахим хуудаст байршуулсан. Мөн иргэд, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийг эсэргүүцсэн, дэмжээгүй санал гараагүй. Хуулийн төслийг дэмжих олон нийтийн дэмжлэг маш өндөр байгааг дурдахыг хүсэж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүй. Анхаарал тавьсанд баярлалаа. Та бүхэн энэхүү хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүн танилцуулга хийлээ. Улсын Их Хурлын гишүүн Түвшин нарын 41 гишүүн гарын үсэг зураад, Нийгмийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачилж, өргөн мэдүүлсэн. Өргөн мэдүүлэхдээ Засгийн газраас өргөн барьж байгаа Нийгмийн даатгалын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй уялдаж, 1 зарчмаар асуудлаа шийдвэрлэнэ гэсэн ийм байр сууриар илэрхийлж өргөн барьсан.

Мэдээж Улсын Их Хурлын даргын хувьд гишүүдийн санаачилсан хуулийн төслийг хүлээж авах үүрэгтэй. Нөгөө талаасаа нийгмийн даатгал, татвартай холбоотой асуудал бол улсын төсвийн орлого, зарлагатай шууд холбогддог асуудал учраас гишүүд бас шууд санаачлаад, хэлэлцээд явахад учир дутагдалтай зүйлс байдаг учраас заавал Засгийн газрын саналыг авдаг. Засгийн газраас авсан санал зарим яамнуудынх нь дэмжээгүй ирсэн байсан учраас бас энийг Засгийн газрын асуудлаа хариуцсан сайдтай бас урьдчилж уулзаж, ярилцсаны үндсэн дээр энэ төсөл өргөн баригдаад явж байгаа. Гэхдээ энэ төсөлтэй холбоотойгоор улсын төсвийн орлого, зарлага дээр нөлөөлөл үзүүлэх нөхцөл үүсэх учраас бид энийг өнөөдөр хэлэлцэхдээ их олон талаас нь бодож болгоомжтой хэлэлцэх ёстой. Олон нийтэд урьдчилж буруу зөрүү мэдээлэл өгч, өндөр хүлээлт үүсгэх эрсдэл бас их байдаг. Эргээд энэ асуудлаа Засгийн газар, Улсын Их Хурал тэр хүрэх түвшинд нь хүргэж баталж чадахгүй эрсдэл үүсэх асуудал бас байдаг гэдгийг би зориуд энэ

хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхлэхээс өмнө бас хэлэхийг хүсэж байна.

2 дугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.4-д хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна гэж заасан байгаа. 31.2 дээр Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд эсвэл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн Засгийн газрын гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн хийнэ гэсэн ийм заалт байдаг. Тэгээд үүнтэй холбогдуулаад Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан уг өргөн баригдсан хуулийн төсөлтэй холбоотойгоор саналаа илэрхийлнэ. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Түвшин нарын санаачилсан хууль дээр Дэгийн тухай хуулийн дагуу Сангийн сайдын хувиар саналаа илэрхийлэх боломж олгож байгаад талархлаа.

Улсын Их Хурлын гишүүн Түвшин нарын санаачилсан Нийгмийн даатгалын тухай хуульд оруулах өөрчлөлтийн төсвийн нөлөөлөлтэй заалтуудын талаар та бүхэнд мэдээлэл өгье.

1 дүгээрт хоол унааны хөнгөлөлтөд шимтгэл ноогдуулахгүй байх. Энэ өөрчлөлт орсон даруйд төсвийн нөлөөлөл нь 891 тэрбум төгрөгийн төсвийн ачаалал ирнэ.

2 дугаарт ажил олгогчийн шимтгэл төлөх цалин хөлсний хэмжээ нь дээд хязгаар тогтоовол даруй 175 тэрбум төгрөгөөр төсөв дээр хасах ачаалал ирнэ гэсэн үг.

3 дугаарт хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа гэрээт ажиллагсдын шимтгэлийг чөлөөлөхөд 127 тэрбум төгрөгийн сөрөг ачаалал төсөв дээр ирэх нь. Ингээд нийтдээ 1 их наяд 197 тэрбум төгрөгөөр нийгмийн даатгалын сангийн орлого буурна гэсэн үг. Ингэсэн тохиолдолд нийгмийн даатгалын сангийн зарлага маань 20 хувиар бууруулах шаардлагатай. Эсвэл ийм хэмжээгээр санд төсвөөс татаас олгох буюу татвар төлөгчдийн нуруун дээр энэ ачаалал ирэх ийм эрсдэл үүсэхээр байна.

Тиймээс энэ хуулийн төслийг дараах үндэслэлүүдээр дэмжих боломжгүй байна. Мөн Засгийн газар дээрээс ч саналаа хүргүүлсэн байгаа.

1 дүгээрт нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагч, төрөөс төлсөн шимтгэлээс бүрдэж, буцаад зардал гаргадаг ийм сан. Жилдээ жилийн эцсээр тэг үлдэгдэлтэй гардаг ийм сан. Нийгмийн даатгалын сангийн орлогыг бууруулж байгаа нөхцөлд нөгөө талд улсын төсвөөс татаас нэмэгдэх сөрөг үр дагавар үүснэ. Тиймээс улсын төсөвт ирэх ачааллыг тооцоолох, дахин тооцоолж энийгээ нийлүүлэх шаардлагатай байна.

2 дугаарт орлогоо бууруулаад зардал нь өсөөд байвал нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэртэй байдал алдагдана. Нөгөө 20 гаруй жил явж ирж байгаа энэ чөтгөрийн тойргоосоо бид нар улам гарч чадахгүй. Улам л энэ маань гүнзгийрэх нь. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл улам алсарна гэсэн үг. Тооцоотой судалгаатай зардлаа яах вэ гэдгээ хэдүүлээ бодох хэрэгтэй байна. Тийм учраас одоо энэ нийгмийн даатгалын сангийн зардал нэмэгдээд ингээд алдагдал нь улам өсөх юм бол 3 ийм сөрөг арга хэмжээ авахаас өөр аргагүй болно эсвэл 1 дүгээрт ажилтны шимтгэлийг нэмэгдүүлнэ гэсэн үг. Эсвэл тэтгэврийнхээ хэмжээг бууруулах шаардлагатай болно. Тэтгэврийн хэмжээг нэгж тэтгэвэр авагч дээр 20 хүртэл хувиар бууруулах шаардлага үүснэ. Эсвэл төсвөөс өгч байгаа татаас нэмэгдэнэ. Энэ татаас дотор төр өөрөө өгөх мөнгө байхгүй. Энэ татвар төлөгчдийн мөнгөөр л эргээд төлөгдөнө гэсэн үг.

Нэг талаар татвар төлөгчдийнхөө ачааллыг нь бууруулаад, нөгөө талаар нэмж байна гэсэн үг. Иймэрхүү хүнд нөхцөлүүд үүсэхээр байна.

Тийм учраас удахгүй Татварын багц хуулийн шинэчлэлтэй хамтдаа Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл Засгийн газраас өргөн баригдана. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүн Түвшин нарын өргөн барьж байгаа энэ хуулийн өөрчлөлтийг Засгийн газраас өргөн барих багц хуулийн өөрчлөлттэй нэгтгээд Улсын Их Хурал дээр Засгийн газраас хамтарсан ажлын хэсэг гаргаад, энийгээ аль нэг тал руу нь шингээгээд, өргөн барихдаа цуг өргөн барья гэсэн ийм санал, ийм шийдэлтэй байгааг хүлээж авна уу.

Ингээд нийгмийн даатгалын та бүхний өргөн барих гэж байгаа хуулийн төсвийн нөлөөлөл дээр 1,2 их наяд, нөгөө Татварын багц хууль дээр чинь бараг 4 их наяд байгаа. Ингээд 5 их наядыг ойрын жилүүдэд төсөв маань өөрөө дийлэхгүй. Алдагдалгүй төсөвтэй үед 5 их наядын алдагдлыг бид нар шингээх боломжгүй болж ирнэ. Тэгэхээр энэ шинэчлэлүүд маань цаашаа улам алсраад ойрын жилүүдэд хийх боломжгүй болно шүү.

Тийм учраас бүгдээрээ дахиж эргэж тооцоо дээрээ суугаад, дундын хувилбар дээрээ суугаад, тэгээд хуулиа санаачилгуудаа нэг тал руу нь шингээгээд ингээд явбал яасан юм бэ гэдэг ийм саналыг та бүхэнд хэлэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсөл санаачлагчийн илтгэл, танилцуулга болон Засгийн газраас өгсөн ийм саналтай холбогдуулан Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт боловсруулсан. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Баатархүү: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид хүн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг нь бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, цаашлаад далд эдийн засгийг ил болгож, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар улсын төсөв, иргэн, хуулийн этгээдэд шинээр зардал үүсэхгүй гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хуулийн төслийн хүрээнд цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаар тэтгэвэр бодоход ямар ялгаа зааг гарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Засгийн газраас өргөн барихаар боловсруулж буй хуулийн төслийн үзэл баримтлал, хэзээ өргөн барихаар бэлтгэж байгаа, Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх боломжтой эсэх, нийгмийн даатгалын удирдлагын бүтэц, түүний зардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Хуулийн төслийн хүрээнд иргэнд нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх эсэх сонголтыг өгч болох талаар, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоолол зөрж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун бүрэн болон хувь тэнцүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй тэтгэвэр авагчдын тоо, хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдын тоо, хуулийн төслийг баталснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ирэх ачаалал болон Засгийн газраас боловсруулж буй хуулийн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хуулийн төслийг баталснаар өндөр насны тэтгэврээс гадна нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний, амаржсаны, тэжээгчээ алдсаны, ажилгүйдлийн гэх мэт олон тэтгэмж төлбөрүүдэд хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авсан эсэх, нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалингийн дээд хэмжээнээс илүү цалин авдаг ажилтны тооны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нийгмийн даатгалын шимтгэлээс татвар авч байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Төсвийн тухай хуулийн хүрээнд хуулийн төслийг хэрэгжих хугацааг дараа жилээр хэрэгжүүлэхээр зохицуулах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нийгмийн даатгалын шимтгэлийн дарамт бизнес эрхлэгчид хүндээр тусаж байгаа нь ирээдүйд ажил олгогч болон нийгмийн даатгалын сандаа алдагдалтай тул одоогоос тодорхой зохицуулалт хийж эхлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Х.Болормаа, С.Зулпхар, О.Саранчулуун нар Засгийн газраас боловсруулж буй хуулийн төслөө шуурхай бэлтгэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Засгийн газрын харьяа байгууллагууд Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн төсөл боловсруулахад

мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд анхаарах талаар тус тус саналыг гаргасан болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 92,9 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх дээр Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өнөөдрийн 41 гишүүний гарын үсэг зурж, өргөн барьсан хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахад Байнгын хорооны санаачилгаар төсвийн орлого, зарлагатай холбоотой асуудал учраас иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал учраас Засгийн газрын асуудал хариуцсан яам, агентлагийн эрх бүхий албан тушаалтнуудыг байлцуулах ийм саналыг гаргаж, өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцуулж байгаа юм байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хууль боловсруулахад ажилласан ажлын хэсгийг төлөөлж:

Лхагвасүрэнгийн Батхуяг Эдийн засагч, Болор-Эрдэнийн Төрболд хуульч, Пүрэвээгийн Баттулга хуульч, Баттулгын Солонго хуульч, Баянмөнхийн Буянзаяа хуульч. Энэ бол хууль боловсруулахад ажилласан ажлын хэсэг.

Засгийн газрыг төлөөлж:

Сангийн яамнаас Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг төлөөлж Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга.

Мөн чуулганы хуралдааны танхимд Сангийн сайд Болдын Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир, мөн сайд асан Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нар байгаа. Манай Улсын Их Хурлын гишүүд бас онцлогтой хэлэлцүүлэг болох гэж байна шүү дээ. Хууль санаачлагч талаас асуулт асууж, хариулт авч болно. Мөн Засгийн газрын байр суурийг холбогдох албан тушаалтнуудаас асуулт асууж, хариулт авч болох нь байна. Дэгээрээ явна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт

харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийт 20 гишүүн асуулт асуухаар нэр ирүүлсэн байна. Ирцийн дараалалд оруулъя. Пүрэвдорж гишүүн байхгүй юм уу. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя. Алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Сайд асан гээд яах вэ, 41 гишүүнийхээ саналыг хүндэтгэж байгаа гэж би хэлсэн. Түвшин гишүүнтэй ч өргөн барихаас өмнө уулзаж надаас бас зөвлөгөө, санал авсан. Тэгээд энэ 3 заалтаас нь анхны 4 заалт байсан. 1 нь бол хасагдсан. 3 заалтаас нь би нэгийг нь л үндсэндээ дэмжиж байна буюу ажил олгогчийн зүгээс төлж байгаа шимтгэлийн буюу бодогдож байгаа цалингийн хязгаарлалтыг ажилтантай адилтгах буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй хязгаарлахыг би дэмжиж байна гэдгийгээ илэрхийлсэн.

Нөгөө 2 заалт нь 2004 болон 2008 оноос хэрэгжиж байгаа заалт. Энэ зарчмыг өөрчлөх гэж байгаа энэ заалтуудыг яагаад болгоомжтой авч үзэх ёстой вэ гэдгийг би хэлсэн. Ажил олгогчийн зүгээс байнгын хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр зүгээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад яваад байх эрсдэлтэй. Хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр зүгээр хүн ажиллуулаад байх ийм эрсдэлтэй. Тэгээд энэ нь яагаад вэ гэхээр шимтгэл төлөхгүй байх тал дээр нь 1 талдаа анхаарч байна. Нөгөө талдаа ажилтны эрсдэлд орохоор, лист тогтоолгохоор, декретээ авахаар, осолд ороод хөдөлмөрийн чадвараа алдахаар нийгмийн хамгааллын тал нь огт зохицуулагдаагүй байдаг учраас энэ эрсдэлтэй. Ийм учраас хөдөлмөрийн гэрээ байгуулж байгаатай адилхан байх ёстой ийм зохицуулалт 2004 оноос хойш явж ирсэн. Энийг эвдэх гэж байна.

2 дахь нь болохлоор унаа, бусад хоол, байр, орон сууц, даатгал гээд цалин хөлсөө нэмэхгүй үндсэн цалингаа нэмэхгүй, бусад олговроороо улам нэмээд явах ийм эрсдэлтэй. Тэгэхээр цалин хөдлөхгүй. Эргээд өөр зохицуулалтаар шимтгэлээс зугтаж ийм нөхцөл байдал үүснэ. Энэ чинь давхар эрсдэл үүсгэнэ гэдгийг хэлсэн.

Манай нийгмийн даатгалын тогтолцоо бол хуваарилалтын тогтолцоо дээр явж байгаа. Одоо хагас хуримтлалын тогтолцоо руу дөнгөж шилжээд эхэлж байна. Хуваарилалтын тогтолцоо гэдэг маань юу юм бэ гэхээр өнөөдөр шимтгэл төлж байгаа хүмүүсийн сангаас өнөөдөр тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэтгэвэр тэтгэмж нь олгогдож байдаг. Тэгэхээр орлого тал нь буурах юм бол жил бүр инфляцын түвшинтэй уялдуулаад 6 хувиар нэмэгдүүлэх энэ бодлого маань хэрэгжихэд хүндрэлтэй. Хагас хуримтлалын тогтолцоонд бага багаар орж ирж байгаа гэж байна. Тэгэхээр шимтгэл тэтгэвэр тооцоход хүртэл энэ хуваарилалтын тогтолцоо дээрээ 1960-1979 оны хооронд төрсөн хүмүүс 2 боломжтой. 1 нь хуваарилалтын тогтолцоогоороо цалин хөлсний суурьтай бодолт хийлгэх буюу сүүлийн 5 жилийн дунджийг авч үзэж байгаад 1 сард оногдох цалингаас тухайн цалингийн 45 хувиар тэтгэвэр нь тогтоогддог. 1979 оноос хойш төрсөн хүмүүс бол ямар ч сонголтгүй буюу яг энэ хуримтлалын тогтолцоо дээр суурилж тэтгэврээ тогтоолгоно. Та хэдийн хэмжээний мөнгө энэ санд төвлөрүүлсэн байна, түүнээсээ цаашид амьдрах магадлал 1 сард, 1 жилд нь ноогдох сарын тэтгэмж нь онолынхоо хувьд томъёоллоороо бодогдоод, тэгээд тэтгэвэр нь тогтоогддог ийм онол байгаа. Тэгэхээр аль аль талдаа сөрөг талтай.

Өнөөдөр хуваарилалтын тогтолцоо дээр цалин хөлс нь буураад ирэхээр цалин хөлснөөс нь эргээд бодогдож байгаа тэтгэврийн хэмжээ нь буурч орж ирнэ

Хуваарилалтын тогтолцоо дээр суурилж байгаа нь. Хуримтлалын тогтолцоо дээр суурилж байгаа буюу 1979 оноос хойш төрсөн хүмүүс төлж байгаа шимтгэлийн хувь, хэмжээ нь буураад ирэхээр тэр хэмжээгээрээ дахиад тэтгэвэр тэтгэмж нь буурна. Өнөөдөр тэтгэвэр тэтгэмж тогтоолгох тэтгэвэр биш тэтгэмж тогтоолгох хүмүүс дээр декрет, лист, хөдөлмөрийн чадвар гэх зэрэг бүх асуудлууд нь буюу олголт дээр нь бодогдож байгаа цалин хөлс, бүтэц нь буурч орж ирэх учраас мөнгө нь ч гэсэн багасна. Буурна гэсэн үг. Тэгэхээр зөвхөн аж ахуйн нэгж байгууллагуудад гоё сайхныг нь ярьчихаад, ажилтан талаасаа, хүн талаасаа буурна гэдэг сөрөг талын .../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн хариулт өгье.

Б.Түвшин: Баярлалаа. Энэ нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа зүйл бол 3 зүйл заалтаас бүрдэж байгаа.

1 дүгээр зүйл заалтын ерөнхий агуулга бол Иргэний хуулиар бизнес эрхэлж байгаа хувь хүнийхээ нэр дээр эрхэлж байгаа орлогоос 2 талаас нь нийгмийн даатгалыг албан журмаар авахаа больё л гэж байгаа юм. Нэг ёсондоо бол байгууллага дээр тэр хөлсөөр ажиллах гэрээ, бусдаар гүйцэтгэх ажил гэдэг бол нөгөө талдаа хувь хүн байдаг. Өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт чангарч эхэлснээрээ иргэн хүн ямар нэгэн хөдөлмөр эрхлэхэд тэр нь орлого нь байдаг. Тэгэхээр хөлсөөр ажиллах гэрээ гэдэг чинь нөгөө иргэн хүнийхээ хувьд Иргэний хуулиар зохицуулсан гэрээ байгаад байгаа учраас энэ төрлийн бүх гэрээний орлогоос 2 талаас нь албан журмаар нийгмийн даатгал 10, 10 хувь авчихаар энэ орлого нь боломж байхгүй. Одоо үүний чинь дараа хүн амын орлогын албан татвар 10 хувь суутгачихна. Угаасаа энэ иргэний орлогыг чинь бизнесийн орлого нь гэж үзэж байгаа учраас хамгийн өндөр татвараар буюу 10 хувийн орлого нэг талаасаа харахад ноогдуулаад байгаа. Гэтэл нөгөө талаас нь энэ бол хөдөлмөрийн хөлстэй адилтгаж 10, 10 хувиар 2 талаасаа 20 хувь суутгаж байгаа. Тэгэхээр дэлхийд ч энэ жишиг байхгүй. Орлогоосоо дахиад НӨАТ-ыг оролцуулчих юм бол 40 хувь төлөөд амьдардаг бизнес байхгүй. Үүний муу үр дагавар нь юу болж байна вэ гэхээрээ Монгол хүн Монгол хүнийхээ нэрээрээ иргэний гэрээ байгуулаад, бизнес эрхлэх ямар ч боломжгүй болж байгаа юм. Энэ хүмүүсийг яаж нийгмийн даатгалд хамруулж болох вэ гэдэг бодлого бол зөв юм. Тэгэхээр энэ Иргэний хуулиас нь авахыг нь больчихъё. Хөдөлмөрийн шинж чанартай харилцаануудаас нийгмийн даатгалыг яг авдгаараа авна. Энэ талаар ерөөсөө огт хөндөөгүй. Ингэснээрээ нийгмийн даатгалын албан журам бол ялангуяа 2 талаас ажил олгогч, ажилтан 2 талаас авдаг чинь зөвхөн хөдөлмөрийн харилцаан дээрээ байя гээд эрх зүйн нэг талаа зохицуулчхаж байгаа юм.

Нөгөө Иргэний хуулиар зохицуулж байгаа хүмүүсийг яаж нийгмийн энэ хамгаалалд оруулж ирэх вэ гэхээрээ орлогод нь таарсан бүтээгдэхүүнүүд хийдэг. Жишээлбэл, Англи, Солонгос зэрэг улсууд өнөөдөр юу хийж байна вэ гэхээрээ жилдээ 1 удаа тайлан гаргаад, сар болгон байнгын даатгалуудыг төлөөд явж байдаг. Ингэж орлогод нь таарсан юм хийхгүй бол орлогоос нь ажилтан, ажилтан бишээр авчихаар энэ чинь энэ бизнесүүдийг эдийн засгийн хувьд сэргэх боломжгүй болгочхоод байна гэж ингэж хэлж байгаа.

2 дугаарт Ариунзаяа гишүүний хэлсэн тэр хөдөлмөрийн гэрээ байгуулахад зугтаана гээд ингэж яриад байгаа. Тэгэхээр манай Хөдөлмөрийн тухай хуулийн 41.3 дээр нэг ийм агуулга байгаа. Ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 44.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол

хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулсан боловч уг гэрээний харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн шинжийг агуулсан байвал түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно гэж байгаа юм.

Нэг ёсондоо хөдөлмөрийн шинж чанартай гэрээ байгуулсан энэ тохиолдолд түүнийг өөр гэрээ байгуулахыг хориглоно. Манай хуулийн төсөл дээр ч гэсэн ийм .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Түвшин гишүүн 1 минут.

Б.Түвшин: Нэмэлт ийм төрлийн гэрээ байгуулсан бол нийгмийн даатгалыг нь нөхөн төлүүлнэ гэж ингээд заачхаж байгаа юм. Тийм учраас бизнесийн орлогоос нь авахаа больё.

3 дугаарт Ариунзаяа гишүүний хэлсэн тэр хуваарилалтаас хуримтлалын зарчим руу шилжье гэж байгаа энэ бол нэг талдаа зөв зарчим. Одоо энэ хүмүүс бизнесийнхээ орлогоос 2 талаас нь 22 хувь суутгаад энэ дээрээ хуримтлал үүснэ гээд байгаа боловч энэ орлогууд ихэвчлэн цаг хугацааны шинж чанартай. Зарим нь жилдээ 1 удаа, жилдээ 2 удаа гэрээ байгуулах ийм орлогын шинж чанартай байгаа. Энэ нь өөрөө нөгөө тогтвортой байдлыг хангаж чадахгүй учраас нийгмийн хамгааллыг бүрэн хангаж чадахгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ өөрөө ялангуяа 1979 оноос хойш хуримтлалын тэтгэврийг нь тооцоолоод үзэхээр өмнөх тэр цалин суурьтайгаасаа хамаагүй бага гарч байгаа. Одоо ч гэсэн тооцооллын аргачлалууд нь. Тэгэхээр энэ аргачлалууд дээрээ бид нар анхаарах хэрэгтэй байгаа байх. Ер нь бол энэ хүмүүсийг тогтвортой, тасралтгүй нийгмийн даатгалыг төлөвлөдөг ийм тогтолцоог 1 талаас нь төлөвлөдөг байж байж ажилтай орлого .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын ажлын хэсгээс нэмж хариулах санал байвал гараа өргөөрэй. Ажлын хэсгийн гишүүд. Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Яах вэ, Татвар тэгээд нийгмийн даатгалын шимтгэл 2-ыг хольж хутгаад байгаа байхгүй юу. Татвар бол татвар тусдаа явдгаараа явах ёстой. Нийгмийн даатгалын шимтгэл нийгмийн даатгалын харилцаа гэдэг чинь нийгмийн хамгаалал байхгүй юу даа. Яах вэ, одоо ингээд хэлэлцээд баталдаг бай, үгүй бай ямар ч байсан өгөх мессеж нь юу вэ гэхээр аж ахуйн нэгж, байгууллага талдаа л ашигтай юмыг яриад байгаа болохоос биш ажилтан талдаа өнөөдөр тэтгэвэр тэтгэмж авч байгаа хүмүүсийн талдаа ямар сөрөг үр дагавартай вэ гэдгийг огт ярихгүй, нийгмийн пи ар хийгээд эерэг оноо аваад байгаа байхгүй юу даа. Энэ дээр би бухимдаад байгаа юм. Сөрөг талыг нь огт ярихгүй байна. Энэ чинь өнөөдөр болон маргааш ч гэсэн сөрөг нөлөөлөлтэй.

Хууль тогтоомжийн тухай хууль дээр ч гэсэн ийм томоохон асуудлуудыг Засгийн газар л оруулж ирэх ёстой гэдэг дээр би байр сууриа илэрхийлж байсан байхгүй юу даа. Энэ бол ердөөсөө маш чухал. Энэ дээр ямар нөлөөлөл үзүүлэх вэ, өргөн барих хууль дээр ямар боломж байгаа вэ гэдэг дээр Мөнхзул даргыг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулж асуусан асуултад Түвшин гишүүн эхлээд хариулъя. Нэмж Засгийн газрын байр суурийг илэрхийлж хариултыг Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул хариулт өгнө. Түвшин гишүүнд микрофон өгье.

Б.Түвшин: 1 дүгээрт хөдөлмөрийн хуулийн тухай харилцаа буюу ажилтан, ажил олгогчийн асуудал бол яг энэ албан журмын нийгмийн даатгал дээр явдгаараа явна. Энэ асуудал огт хөндөгдөөгүй. Иргэний хуулийн харилцаанууд бол ажилтан ажил олгогчийн харилцаа биш. Энэ хууль дээрээ байгаа. Энэ ерөөсөө тэр өмгөөллийн хөлсөөр ажил гүйцэтгэх буюу иргэний хуулийн бизнесийн орлого нь. Энийг яагаад бизнесийн орлого гэж тодорхойлоод байна вэ гэхээрээ татварын хувь 10 хувь авахаараа, татвар талаасаа харахаараа энэ та нарын үйл ажиллагааны орлого юм гээд 10 хувь харчихдаг. Нийгмийн даатгал авах болохоороо ажилтан, ажил олгогчийн харилцаа гээд тодорхойлчихоод байгаа нь энэ буруу тодорхойлоод байгаа байхгүй юу. Эндээс бол нийгмийн даатгалыг 1 талаас нь тэгээд өөрөөр нь сайн дураар тасралтгүй төлөвлөх тогтолцоог хөгжүүлнэ үү гэхээс биш энэ иргэний хуулийн харилцаанууд бол ерөөсөө хөдөлмөрийн ажилтан, ажилтан олгогчийн харилцаа биш юм шүү гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт энэ 3 заалтын эдийн засгийн тооцоо 2024 оны хамгийн өндөр хувь жингээрээ тооцоход 300 орчим тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын санг бууруулж байгаа буюу нийгмийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 3 дугаар индэр. Алив Байнгын хорооны дарга Лутаагийн Энхнасан дарга Засгийн газрын ажлын хэсгийг Байнгын хороо яагаад дуудсан талаараа та тайлбараа өг дөө. Байнгын хороо дуудаж ирсэн байна лээ. Лутаагийн Энхнасан гишүүний микрофоныг өгье.

Л.Энхнасан: Байнгын хороо дуудсан биш. Хэрвээ ажлын хэсгээс Засгаас тодруулах юм байвал ажлын хэсэг хариулж болно. Засгийн газар хэлж болно. Ажлын хэсгээс хэрвээ гишүүн Түвшин болон ажлын хэсгээс асуух бол ...

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн дэгийн тухай хуулиараа энэ өөрөө бас боломжтой зүйл гэж манай Байнгын хороо өөрөө үзээд, ажлын хэсэг оруулж ирсэн байна лээ. 3 дугаар индэр.

Л.Мөнхзул: Ариунзаяа гишүүний тодруулгад хариулт өгье. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Энэ хуулийн нийгмийн даатгалын харилцаанд 3 тал оролцдог. Ажил олгогч, даатгуулагч, төр. Оруулж байгаа хувь нэмэр төр, ажил олгогч, даатгуулагч эн тэнцүү хувь нэмэр оруулдаг. 5,8 их наяд төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлдэг. 2,8 их наядыг ажил олгогч, 2,7-г даатгуулагч, 1,4 их наядыг төрөөс төлж байгаа. Шимтгэлийн орлогыг өөрчлөх тохиолдолд даатгуулагчийн тэтгэврийн хэмжээнд гарах нөлөөллийг зайлшгүй тооцох ёстой. Хэрвээ нийгмийн даатгалын шимтгэл ноогдуулж байгаа цалин хөлсний бүрэлдэхүүнийг 1 талын санаачилгаар автоматаар бууруулах тохиолдолд тэтгэвэрт гарахаар бэлтгэгдэж байгаа хүний дундаж цалин хөлс буурна. Тухайлбал өдөрт 20 мянган төгрөгийн хоол унаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Л.Мөнхзул: Тухайлбал өдөрт Улаанбаатар худгийн жишгээр 20 мянган төгрөгийн хоол, унааны зардлыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж цалин

хөлсний бүрэлдэхүүнээс хасах тохиолдолд 1 даатгуулагчийн тэтгэвэр 230 орчим мянган төгрөгөөр бууруулах энгийн тооцоолол байна. энэ тэтгэвэрт гарахаар бэлтгэж байгаа хүмүүсийн хувьд бол бас хугацааны хувьд бол нэлээд тулгуу. Тийм учраас өргөн барьсан хувилбар дээр нэлээд хууль, эрх зүйн зохицуулалт хийх ёстой. Нөгөө талаасаа хөлсөөр ажиллах гэрээ Иргэний хууль Монгол Улсын 2002 онд батлагдсан Германы хуулиас эх авсан хөлсөөр ажиллах гэрээ хөдөлмөрийн гэрээний хооронд ялгаа маш бага. Иргэний хуулийн зохицуулалт бүдэг зохицуулчихсан. Энэ мөн ажил хийснийхээ төлөө хөдөлмөрт нь ноогдох хөлс байдаг. Тэгэхээр хөлсөөр ажиллах гэрээ дээр цалин хөлсний бүрэлдэхүүн бас давхар орж ирдэг ийм зохицуулалт бас байдаг.

Д.Амарбаясгалан: Дахин тодруулж асууя Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би тодруулга гэхээсээ илүүтэй зүгээр үг хэлчихье дээ. Ер нь аливаа ийм маш олон хүний аж амьдралтай холбоотой асуудал дээр попролтын хувь шинжтэй юмнууд байж болдоггүй байхгүй юу. Пүрэвдорж гишүүний өнгөрсөн парламентын үед хийсэн 7 жилийн дунджийг 5 жил болгоно гэж ярьсан энэ асуудал бол сан дээр маш их ачаалал үүсгэхээс гадна шударга бус байдлыг улам гааруулсан. Тэгэхээр одоо энэ маш чухал асуудал дээр мэргэжлийн яам, мэргэжлийн Байнгын хороо, тухайн ОУВС, олон улсын байгууллагууд бүхий л тал дээр нь яг энэ онолынх нь хувьд, шинжлэх ухааных нь хувьд тогтсон сууриар нь явахгүй л бол энэ өөрөө маш их эрсдэлийг үүсгэдэг байхгүй юу даа. Тэгээд яах вэ 41 гишүүний саналыг нь хүндэтгэж байна гэж би хэлээд байгаа шүү дээ. Яадаг ч байсан бай нийгмийн даатгалын энэ ач холбогдлыг маш сайн судалж бас маш сайн болгоомжтой хандахгүй бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ингээд намын бүлгүүд дээр яриагүй, Байнгын хороо дээрээ асуудлаа бас олигтой ярилгүй орж ирэхээр ингээд гишүүдийн хооронд маргаан дэгдээд, олон нийтэд буруу зөрүү ойлголт төрүүлнэ. Тийм учраас уг хэлэлцэж байгаа асуудлыг ирэх 7 хоногийн 1 дэх өдрийн намын бүлгүүд дээр хэлэлцээд, дахиж оруулж ирэх чиглэл өгөөд, өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулж болно тийм ээ Дондогмаа дарга аа.

Тэгэхгүй бол хууль санаачлагч санал гаргачих. Тэгээд яах вэ гэхээр нөгөө намын бүлгүүд бүгдээрээ нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа учраас хэлэлцэж байгаа асуудал маань эрсдэлд орох магадлалтай. Ард иргэд биднээс эерэг хүлээлттэй байж байгаа. Засгийн газраас өргөн барих, Түвшин нарын 41 гишүүний өргөн барих асуудал нь хамтдаа хэлэлцэгдээд, хамгийн гол нь энд хэн нэгнийх нь өргөн барьсан төсөл батлагдана гэхээс илүүтэйгээр ард иргэдэд зөв ээлтэй Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт хийгдэх ёстой л гэдэг хүлээлт байгаа шүү дээ. Тэгэхээр бид энийг ажлын үр дүнгийн төлөө энэ асуудал дээр ажил хэрэгчээр асуудалд хандах ёстой. Улс төржиж биш. Бид ер нь татвар болон нийгмийн даатгалын асуудлаар улс төржиж ерөөсөө болохгүй.

Тийм учраас горимын санал гаргаад, энэ хэлэлцэж байгаа асуудлыг дараагийн 7 хоног хүртэл хойшлуулах санал Түвшин гишүүн гаргах уу. Түвшин гишүүн санал гаргая.

Б.Түвшин: Ерөнхийдөө энэ Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт орох асуудал гэнэтхэн ч орж ирээгүй л дээ. Нэлээн олон хэлэлцүүлэг хийгээд, тооцооллуудаа ч тал талаасаа тулгаад, статистик тоонуудаа бол нэлээн гаргаад

явж байсан юм. Тэгээд би горимын санал гаргахынхаа өмнөхөн ганцхан статистик тоо хэлчихье.

2023 онд тэр хөлсөөр ажиллах гэрээгээр төлсөн нийгмийн даатгалын шимтгэл 11,3, 2024 онд 43,4 тэрбум буюу хамгийн ихдээ 43,4 тэрбум байгаа юм шүү. Хоол, унааны хөнгөлөлт статистик тооцоогоороо нь хамгийн ихдээ 63 тэрбум, нөгөө байгууллагаас төлөх 235 буюу нийтдээ 300 тэрбумд байгаа юм гэдэг энэ статистик тоон дээр үндэслээд, энэ нь цаашаа ямар загварчлалаар яаж өсөх вэ, Монгол Улсын эдийн засагт эергээр болон муугаар яаж нөлөөлөх вэ гэдгээр загварчлалыг нь гаргачихсан юм байгаа юм. Тийм учраас статистик тооны хувьд маргаан байхгүй.

2 дугаарт энэ асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон сайд нартай зөвшилцөж байсан учраас Их Хурлын даргын тавьсан саналын дагуу 1 дэх өдөр хүртэл завсарлага аваад, бүлгээрээ хэлэлцүүлье. Гэхдээ энэ асуултуудаа дуусгачхаад, санал хураахаасаа өмнө завсарлага авч бас болох юм.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр ингэнэ Түвшин гишүүн ээ. Завсарлага өгөхгүй. Энэ өөрөө улс төрийн намуудын хувьд бүлгүүдээрээ хэлэлцүүлээгүй байгаа асуудал. Миний хэлээд байгаа санал юу вэ гэхээр та бүхэнтэй би өргөн барьж байхад Засгийн газрын асуудал хариуцсан сайдтай хамт уулзаад, давхардал байгаа. Энэ 2 төсөл хоёулаа нийцээд, 1 ажлын хэсэг нийлүүлээд нэгтгээд хэлэлцээд явах боломжтой гэдэг агуулгаар асуудалд хандсан. Тийм ээ та бид. Тэгэхээр та 1 дүгээрт ирэх 7 хоногт намын бүлгүүд хэлэлцэх боломжийг олгож өгөх нь зүйтэй юм байна.

2 дугаарт ирэх 7 хоногт Засгийн газар төслөө өргөн барихыг хүлээх зайлшгүй шаардлага энд байгаа юм байна. Тийм учраас бүгдээрээ энэ дээр улс төрийн асуудлаар биш ажил хэрэгч байр суурийн үүднээс та горимын санал гаргаад, тэр горимын саналаар хойшлуулаад явах нь зүйтэй. Тэгэхгүй бол аль нэг намын бүлэг завсарлага авахаар энэ бас л нэг тийм буруу улс төрийн асуудал болоод явах учраас завсарлагын асуудал бол зохимжгүй юм гэж ингэж үзэж байна. Тэгээд Түвшин гишүүнд микрофон өгье.

Б.Түвшин: Энэ хэлэлцээгүй биш. Бүр тэр байтугай намын бүлэг рүү орох шаардлага ч үгүй, Нийгмийн бодлогын байнгын хороогоор орчихсон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үе үеийн сайд нартай уулзаад, ганц нэгхэн тооцооллын асуудал дээр л ойлголттой. Хэлэлцэх эсэх асуудлаа явуулчихаад, дараа нь Засгийн газраас өргөн барьж байгаа хуультай хамтран хэлэлцэх боломжтой юм гэдэг ийм л ойлголттойгоор орж ирсэн шүү дээ. Тэгэхээр нэгэнт энэ ойлголцол байгаа учир энэ хэлэлцэх эсэхээ хэлэлцүүлээд явуулчихвал яасан юм бэ.

Д.Амарбаясгалан: Би тэгвэл өнөөдөр хэлэлцэх эсэхийг дуусгаад, санал хураалтыг бас хийж дуусгана. Үргэлжлүүлж явъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Уучлаарай. Ариунзаяа сайд байж байгаарай. Ер нь зүгээр энэ нийгмийн даатгалын сангийн нөхцөл байдлыг эргээд аваад ухраахаар сайн, муу 2 талтай. Хуулийн төслүүд угаасаа тэгж л явдаг. Гишүүд улс төрийн зорилгоор санаачлахаар бас байгаад байгаа юм. 1 талдаа тооцоо судалгаа жоохон тийм. Тэгэхдээ би энэ гишүүдийн хууль санаачлах эрхийн асуудлыг өнөөдрийн хууль, эрх зүйн орчинд бол хүндэтгэж байгаа гэдгээ хэлье.

Ер нь зүгээр цаашдаа бодлогын хүрээнд нийгмийн даатгалын сантай холбоотой энэ асуудлыг Улсын Их Хурлын гишүүд биш Засгийн газар санаачилдаг. Харин Улсын Их Хурлын гишүүд нь ийм чиглэлийн эрх зүйн реформыг хийх Засгийн газартаа шахалт, саналаа хүргүүлдэг ийм байдлаар явах нь уг нь зүйтэй юм байгаа юм. Тэгээд өнгөрсөн парламент дээр бас яг энийг гишүүд санаачилгыг жоохон хязгаарлалтыг Үндсэн хуулийнхаа агуулгад нийцүүлээд тавья гэсэн бас парламент дээр унаж байсан юм. Тэр хуулийн төслийг нь миний бие оруулж ирж байсан л даа. Тэгээд бид хэд чинь яг эцсийн дүндээ олон нийтийн мөнгийг, дээрээс нь ирээдүйд тэтгэвэр гаргах гэж байгаа хүмүүсийн ирээдүйн эрсдэлийг тооцож аливаа зүйлийг ярих ёстой болж таараад байгаа юм. Тэгэхээр өнөөдөр энэ агуулгуудыг л нэлээн балансыг нь олж байж аливаа асуудал ярих ёстой. Би гуравхан тодорхой асуудлыг хууль санаачлагч болон Засгийн газраас аль сайд нь хариулж болохоор байна хариулж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Миний ойлгож байгаагаар энэ хуулийн төсөл батлагдвал 480 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого орж ирэхээргүй болох юм байна. 1.2. Уучлаарай. Тэгээд энэ мөнгийг ер нь яаж нөхье гэдэг байдлаар энэ зардлын тооцоо дээрээ хийсэн юм бэ. Хаанаас орж ирнэ гэж үзсэн юм. Яг үеийн үед нийгмийн даатгалын энэ реформыг хийе гэхээр төр засаг аваад хэрэглэчихсэн юм уу, эсвэл энэ тодорхой хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэлийг буурууллаа гэхэд энийг хаанаас санхүүжүүлэх вэ гэдэг эх үүсвэрээ бид нар эхлээд ярьж байж дараа нь энэ тогтолцооны реформ уг нь яривал зүгээр байгаа юм. Тэгэхээр энэ дутагдах эх үүсвэр буюу 1,2 их наяд төгрөгийн асуудлыг хэрхэн яаж зохицуулах юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр нөгөө тэтгэвэр авах гэж байгаа хүмүүс нь бүүр тэтгэврээ авч чадахаа байчих вий дээ. Эсвэл цаашдаа үүнээс нөлөөлөөд одоогийн тэтгэвэр авч байгаа хүмүүс тэтгэврийг бууруулах ийм шийдэл рүү орох юм болов уу. Энийг аль аль талаас нь эрсдэл байна уу энийг хариулж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Тэгээд сүүлийн үед уул уурхайн салбар, тээврийн салбар дахь нөхцөл байдал хүнд байна. Эндээс бас нийгмийн даатгалын орж ирэх орлогууд ер нь багасах юм шиг байна. Яагаад гэхээр цомхотгол явах шинжтэй байна. Тэгэхээр энэ дээрээсээ бас үүсэхэд энэ хууль ер нь хэрэгжих боломж нь хэр байна вэ. Та бас өргөн барьсны дараагаар геополитикийн ч гэдэг юм уу, өнөөдөр экспортын орлого янз бүрийн юм дээр нөлөөлөөд, энэ салбаруудын бас цомхотголын асуудлууд нэлээд яригдахаар байна. Үүний тооцоо судалгааг бас хуулийн төсөлтэйгөө уялдуулж авч үзсэн зүйл байна уу гэдэг зүйл байгаа.

2 дугаарт хоол, унаа, түлээ нүүрсний хөнгөлөлтийг цалингаас гаргаад, энэ орлого дээр нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэхгүй гэхихээр үндсэн цалин маань ийм жижигхэн байгаад байдаг. Энэ хоол унааны мөнгө нь хэт өндрөөр болоод, сүүлдээ ийм зөрөөнүүд үүсээд, нийгмийн даатгалын шимтгэл маань сүүлдээ бүр хүнд байдалд орох вий дээ гэдэг зүйл байгаа. Энэ дээр бас ямар бодсон, эрсдэлийг хаасан зохицуулалт байдаг юм бэ. Нэг зүйлийг би хууль санаачилж байгаа хүмүүстэй адилхан байгаа юм. Нийгмийн даатгалын шимтгэлийг авах зорилгоор хөдөлмөрийн харилцаа, дээрээс нь хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээний ялгамжтай байдлыг байхгүй болгоод хаячихсан байхгүй юу. Энэ уг нь асар том үр дагавартай, ялгаатай харилцаанууд байсан юм. Хөдөлмөрийн харилцаа дээр би жишээ аваад ярихад ХААБ-ын асуудлыг ажил олгогч хариуцдаг бол хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ дээр ХААБ-ын асуудал магадгүй үр дагавар гарлаа гэхэд ажилтан буюу тэр ажил хөдөлмөрийг хийж байгаа хүн өөрөө хариуцдаг гэх зэрэг бид өнөөдөр бас энэ ялгамжтай байдлууд үнэхээр энэ нийгмийн

даатгалын шимтгэлийн малгайн дотор ороод энэ эрх зүйн ялгамжтай харилцаанууд байхгүй болчхоод байгаа нь бас үнэн. Энийг бас ингээд засах гэдэг юм уу, энэ оролдлогыг хийхдээ бас ингэж үүнтэй уялдуулаад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: хариулт өгье. Банзрагчийн Түвшин гишүүн.

Б.Түвшин: Энэ статистик болон статистикийн гаргаж авсан Нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан бүх талын мэдээллүүд дээр суурилж, сүүлийн 10 жилийн үзүүлэлтүүд дээр суурилагд ирээдүйн загварыг боловсруулсан ийм тооцоо байгаа. Энэ тооцоог эдийн засагт энэ чинь нэг ёсондоо татвар, нийгмийн даатгал өөрөө эдийн засагт нөлөө үзүүлэх импакттай. Энийг хэдэн хувиар манай Монгол улсын эдийн засагт яаж нөлөөлөх вэ гэдэг энэ загварчлалын судалгаануудыг бас хийлгэсэн юм. Тэгэхээр энэ Сангийн яамнаас баталсан. Одоохондоо энэ сангийн бодлого дээр нэг хийгдээгүй байгаа тэр cost benefit анализ буюу бодлогын өөрчлөлтийн нөлөөллийг хэмжиж хийхэд энэ 3 заалт гурвуулаа эерэг дүнтэй буюу ирэх 3 жилд Монгол Улсын эдийн засагт өгөх нийт өгөөж нь бол 82,6 тэрбум буюу цэвэр өнөөгийн үндсэн дээр 68 тэрбумын дүнтэй. Заалт болгон нь он тус бүрээрээ ашигтай буюу өгөөжтэй гарч байгаа юм. Яагаад гэхээр энэ нийгмийн даатгалаас бууруулж байгаа мөнгө чинь өөрөө алга болчихгүй. Тэр ажил олгогч, тэр ажилтанд өөрийнх нь орлого болж байгаа. Тэгээд энэ cost benefit анализыг яг ийм бодлогын нөлөөлөл гаргах гэж байгаа аргууд хэрэглэдэг учраас энэ удаа ингэж шийдсэн. Бид нарт шууд тусаж байгаа асуудал сан. Гэтэл нийгмийн даатгалын сан одоогийн энэ сүүлийн 3, 4 статистикаар 5-10 хувь өсөж байгаа. Энэ өсөлтийнх нь 1/3 буюу 300 тэрбум төгрөг дотор л энэ асуудлыг шийдэх буюу одоо ажилгүйдэл багасаж байгаа бизнес эрхлэгчид орлого багасаж байгаа энэ үед сангийн бодлогын хувьд бол хам хамгийн зөв оновчтой, хамгийн бага зардлаар эдийн засгийг сэргээх ийм бодлого юм гэдгийг энд бас хэлэх байгаад байгаа юм. Тэгэхээр 1 ёсондоо бид нарын энэ тарааж өгсөн материал дээр байж байгаа cost benefit анализ бол ийм гаргаж байгаа. Ингээд энэ загварчлалаар SVR энэ загварчлалаар орох юм бол ирэх 3 жилд 2,5 их наядын эдийн засгийн ДНБ-ийг нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Энэ бол манай Сангийн яамны гаргаж байгаа нөгөө ДНБ-ийг нэмэгдүүлэх бодлоготой нийцэж байгаа. Өнөөдөр энд нэг процессын алдаа гарч байгаа. 1 процессын алдаа бол Сангийн яамтай бол санаатай биш, зөвшилцөөгүй ч юм уу ингэж орж ирж байгаа асуудал дээр би бас процессын алдаа гарчээ гэж ингэж хэлж байна.

Түлээ нүүрс хөнгөлөлт бол нийгмийн даатгалын хуулиар авчихсан хуулиараа авчихсан. Хөдөлмөрийн хууль дээрээ цалин хөлсөнд ордоггүй зүйл байсан. Тэгэхлээр ерөөсөө энэ чинь 3 талын асуудал байхгүй юу. Түлээ, унаа, нүүрс гэдэг бол яг ажилтанд олгож байгаа, тэгээд дээрээс нь өдөр тутмын наад захын хэрэгцээ амьжиргаанд нь дэмжлэг үзүүлдэг байгаа. Хоолны мөнгөнөөс болж дампуурдаг сан байж болохгүй шүү дээ. Хоолны мөнгөнөөс нь нийгмийн даатгал авчихлаар л тэр сан нь дампуурчихдаг юм бол дампуурчихсан гэсэн үг. Унааны хөнгөлөлт өгөнгүүт л тэр нь дампуурчихдаг юм бол дампуурчихсан гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ мөнгө чинь нийгмийн даатгалгүй ороод ирэхээр бизнес эрхлэгчид нэмээд ажилчдадаа олгох байхгүй юу. Энэ чинь өөрөө эдийн засгийн маш том сэргэлтүүдийн тухай ярьж байгаа юм. Нөгөө талын механик тооцоолол нь нь 20 мянгыг үржих нь 11 сараар үржүүлээд 22 хоногоор үржүүлээд нийт 1 сая 600-гаар үржүүлээд тэгээд тэдэн хувьтай шууд буурна гэж байгаа юм. Энэ бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Байр суурь түрүүн сонсчихсон. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн. Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгээд Түвшин гишүүн ээ яах вэ, хэлж ярихад бол их л эвтэйхэн сонсогдоод байгаа юм. Бодит үр дагавар гэдэг бол яг хэцүү дээ. Энэ дээрээ нэлээн бас бодож л олон нийтэд мессеж өгөхгүй бол өнөөдрийн манай дотоодын гол эдийн засгийн секторууд чинь өөрөө жоохон уналттай бөгөөд агшилттай. Эндэх ажил эрхлэлтийн байдал бас агших тэр тал руугаа байна шүү. Тэгээд энэ дээр улам тийм юмыг өдөөх вий дээ. Сүүлдээ энэ цалин хөлсний бүрэлдэхүүн дээр өөрчлөлт ороод, энэ хөдөлмөр 3 талын зөвшилцлийн асуудал дээр сүүлдээ маргаанууд гараад, энэ бүх зүйлүүд чинь нэг л ийм сонин байдал руу түлхээд орчих вий гэдэг зүйл байна. Тэгэхээр энийгээ бас яг анхаарахыг бас хүсэж байна. Зүгээр яах вэ, яаж шийдэх юм мэдэхгүй байна. Тэгээд Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газраас санал авсан юм байна. Өнөөдөр бол хэрэгжүүлэх наад хууль чинь батлагдвал Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар хэрэгжүүлэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Засгийн газрын байр суурийг уг нь бас ямар процессоор яах ёстой юм. Авах ёстой байхгүй юу. Авч байж энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санал. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Нийгмийн даатгалын сан тогтолцоо гэдэг зүйл өнөөдөр Монгол Улсын нийгмийн, эдийн засгийн, бизнесийн, иргэдийн тулгамдсан гэж хэлж болох асуудлын бараг хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн нэг ийм л асуудал болчихлоо л доо. Яг өнөөдрийн байдлаар энэ нийгмийн гэдэг үг, даатгал гэдэг үг, сан гэдэг үг, тэр шимтгэл гэдэг үг ямар утгатайг ч нийтээрээ бараг бид нарын ойлголт асар хол зөрүү. Энийг төлж байгаа 1 хэсэг нь шимтгэлээ төлж байгаа 1 хэсэг нь би татвар өгч байна гэж боддог. Яагаад гэвэл энэ албадлагын шинжтэй. Надад зориулагдахгүй юм, надаас төр татвар дээрэмдэж авч байна гэсэн ойлголттой. Энэ шимтгэлээс буцааж өгөөж хүртэж байгаа 1 хэсэг нь энэ миний төлсөн юм биш, энэ төр надад төр гээд нэг сайхан газраас надад хайр халамж, дэм тус өгч байгаа зүйл гээд бодчихсон. Уг зүй нь энэ ирээдүйдээ хийж байгаа хөрөнгө оруулалт. Энэ сан гэдэг зүйл чинь мэргэжлийн баг удирдаад, хуримтлалын сан нь бий болоод, манайхаар Үндэсний баялгийн сан, Ирээдүйн өв сан олон зүйлээрээ тэр менежмент олон зүйлүүд нь хийгдээд, уг нь бол шал өөр зүйлийн тухай ёстой нэг шал өөр зүйлийн тухай яриа өнөөдөр ойлголтын зөрүү гээд асар их хол болчихсон. Эцсийн дүндээ энэ утга учир, агуулга гэдэг зүйл байхгүй болчихсон асар том шинэчлэл хүлээж байгаа ийм л салбар энд байж байдаг. Бид нар нэг ийм байгаа байдлыг тал талдаа өөр арга алга гэж хаацайлах бас биш л дээ.

Тэгэхээр яг үүний цаана, үүний үрээр өнөөдөр яг юу болчихоод байна вэ гэдэг. Ер нь Монгол Улсад өнөөдөр хөдөлмөрлөсөн нь сайхан амьдрах ёстой гэдэг энэ үзэл санаа, энэ бодлого чиглэл өнөөдөр манайд байхгүй болчихлоо. Яаж ийгээд тэр халамжаа. Тэгэхдээ халамжаараа хөөрхий хүн амьдрахаар юм авагдахгүй байгаа л даа. Тэгэхдээ л хүн хөдөлмөрлөөд сайхан амьдардаг гэдэг энэ философи, үзэл санаа өнөөдөр манайд байхгүй. Байгаа тэрийг ойлгож байгаа хэсэг нь үндсэндээ Монголд биш гадагшийгаа гарахыг эрмэлзчихсэн. Одоо гадаадад үндсэндээ 200-аад мянган Монгол иргэн байгаа гэж байгаа. Ихэнх нь л хөдөлмөрийн насныхан, сурч боловсрох нь байдаг л байх. Тэгэхдээ л ихэнх нь ажил хийхээр. Энэ 200 мянга чинь манай хөдөлмөрийн насны иргэдийн 20 хувь нь гадагшийгаа гараад явчихсан. Тэр тусмаа ажил хийж байгаа идэр насны залуучуудынх нь бараг 50 хувь нь гадаадад гарчихсан ийм л улс орон болчихлоо шүү дээ. Тэгэхээр энэ бол үнэхээр

тийм эмзэглэм. Тэгээд үүний цаана бид нар яалт ч үгүй хөдөлмөр хийж байгаа иргэнийг дэмждэг бодлого, чиглэл, тогтолцоонд ач холбогдол өгөхгүйгээр яаж цаашаа урагшлах юм бэ. Тэгэхээр энэ хуулийн үзэл санааг би бол асар их дэмжиж байгаа. Энэ бол ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийг урамшуулах, дэмжих, түлхэц өгөх бодлогыг л энд оруулж ирж байгаа. Мэдээж үүний цаана тоо тооцоо, олон зүйлүүд дээр нөхцөл байдал тэр хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх олон асуудал гарах байх. Тэр Засгийн газраас орж ирсэн хувилбартай нийлүүлээд, тэгээд цааш цаашдаа хэлэлцээд явах байх.

Тэгэхдээ бид нар ямар ч байсан энэ улс оронд чинь хөдөлмөр хийдэг хүнийг дэмждэг, урамшуулдаг ганц ширхэг бодлого гарч бас болно доо энэ чинь. Баялаг бүтээж байгаа тэр шимтгэлээ тэр их сайн сайхан үгнүүдээ больё л доо. Зүгээр л энгийнээр хөдөлмөр хийсэн хүнээ бид нар яагаад дэмжиж болдоггүй, тэр чиглэлийн ганц хууль зүйл заалт энэ улс орноос чинь гарч болдоггүй ийм л байдаг юм. Улс төрийн зорилго яг үнэндээ нийгмийн даатгал гэдэг нийгмийн даатгалын сан гэдэг чинь улс төрийн зорилгоор л ашиглагддаг хоол хүнсний таланоос эхлээд хэнд өгөх вэ гэдэг нь дараагийн сонгуулийн саналтай холбоотой болчихсон нэг ийм бүр утга учраа алдчихсан л юм болоод хувирчихлаа шүү дээ. Тэгэхээр та бүхэн энэ хуулийн төслийг дэмжээд, хэлэлцэх эсэх дээр нь дэмжихээд, магадгүй эцэслэн батлах олон зүйлүүд дээр нь Засгийн газрын хувилбартай нийлүүлээд асуудлуудаа яриад явах нь яав ч энэ Монгол Улсад илүү тустай зүйл байх. Ажил хөдөлмөр хийж Монгол орондоо аятай сайхан амьдаръя гэж бодож байгаа тэр залуучууд олон хүмүүст илүү дэмтэй тустай зүйл байх л гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Тийм яг Цогтгэрэл даргын хэлж байгаа зөв л дөө. Дан хууль зүтгүүлээд ард нь гарахад бас өрөөсгөл сул талууд байна гэдгийг бас Засгийн газар талаас хэлээд байгаа учраас яг Засгийн газраас өргөн барьж байгаа хуулийн төсөлтэйгөө уялдуулаад, нийцүүлээд хамтад нь хэлэлцээд, 1 үр дүн гаргах нь л бидний хувьд чухал байх. Тэр үүднээс нь асуудалд хандаж хэлж байгаа. Өнөөдөр миний яагаад Түвшин гишүүнд хандаж хэлээд байгаа гэхээр гишүүд бүрэн дүүрэн ойлголт мэдээлэл муу байгаагаасаа болоод хэлэлцэх эсэх асуудал дээр дэмжихгүй гэдэг байр сууриудыг илэрхийлэх гээд байгаа учраас энэ хууль өөрөө агуулгаараа эрсдэлд орох вий л гэж болгоомжилж хэлээд байгаа байхгүй юу. Түвшин гишүүн үг өгье.

Б.Түвшин: Саяын тэр Сайнзориг гишүүний хэлээд байгаа яг нөхцөл байдал бол яг үнэн л дээ. Дотоодын сектор уналттай. Яг энэ цалингийн бүрэлдэхүүнд эдийн засгийн агшилттай энэ үеүдэд яг ийм арга хэмжээ авч байж, эдийн засгийн тэлэлтийг хийдэг юм. Тийм учраас энэ дээрээ бол дотоодын нийт бүтээгдэхүүнийг сэргээх тэр SVR загвар яг энэ дээр энэ төсөл бол хамгийн зөв төсөл байна гэдгийг гаргасан. Энэ тооцоолол дээр хамтарч сууж болно.

2 дугаарт цалин хөлсний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаагүй. Хөдөлмөрийн хуульд байсан цалин хөлс яг хэвээрээ. Тэр чиглэлээрээ бол нийгмийн даатгал зааж байж байгаа. Унаа тээврийн, нүүрсний хөнгөлөлт дээр бол дээд хязгаар тогтоож болно гэж байгаа. Тэгэхээр өнөөдрийн магадгүй энэ хэлэлцүүлгийг хэдүүлээ түр зогсоогоод, 2 бүлэг ч юм уу, эсвэл шинэ Засгийн газраас дахин санал авах ийм байдлаар бас энэ хэлэлцүүлгийг түр зогсоож болох юм дарга аа. Энэ дээр бас горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Горимын санал гаргасан байна. Горимын санал. Гишүүд ээ, гишүүн горимын саналаараа санал хураалгах эрхтэй. Тэрийг дэмжих эсэх нь гишүүдийн өөрсдийн байр суурийн асуудал. Гишүүд танхимд орж ирье.

Банзрагчийн Түвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүдийг дуудъя. Горимын санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Банзрагчийн Түвшин гишүүний гаргасан горимын саналаар ирэх 7 хоногт Засгийн газар хуулийн төслөө өргөн барих хүртэл Засгийн газраас өргөн баригдсан төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэх хүртэл энэ хэлэлцүүлгийг түр хойшлуулъя гэсэн горимын санал гаргасан. Санал хураалтад бэлдье. Бүртгэлд ороогүй гишүүн байна уу. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад ороогүй, амжаагүй гишүүн байна уу. 3, 4 гишүүн байна. 5 гишүүн.

Банзрагчийн Түвшин гишүүний гаргасан горимын саналаар ирэх 7 хоногт Засгийн газраас хуулийн төсөл өргөн баригдаж, хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэгдэх хүртэл энэ хэлэлцэж байгаа асуудлыг хойшлуулъя гэдэг санал гаргасан. Горимын санал дэмжигдсэнээр ирэх 7 хоногийн 1 дэх өдөр намын бүлгүүдээр 2 хуулийн төслийг хамтад нь хэлэлцээд, Засгийн газраас өргөн бариагүй ч гэсэн улс төрийн намын бүлгүүдээр өргөн барих гэж байгаа төслөө бас хамт танилцуулга хийж, мэдээллээ хийгээд, ингээд ажлаа үргэлжлүүлээд явах нь зүйтэй гэсэн ийм байр суурь байгаа. Засгийн газар ч тэр, Улсын Их Хурал ч тэр Нийгмийн даатгалын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх зорилгыг өнгөрсөн жил бүрдсэнээсээ хойш зорилго болгон тавьж ажиллаж байгаа.

Тийм учраас бид 7 хэмжиж, 1 огтлох буюу бодитой үр дүн гарахуйц хуулийн өөрчлөлтийг хийх ёстой учраас энэ асуудал ингэж зөвшилцөж явж байгаа гэдгийг бас гишүүдэд тайлбарлаж хэлье. Ингээд Банзрагчийн Түвшин гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52 гишүүн буюу 54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ингээд улс төрийн намын бүлгүүд, улс төрийн намын зөвлөл, эвслүүд Түвшин нарын гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөл Засгийн газраас өргөн барих хуулийн төслүүдийн талаар дотроо хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, мэдээллээ нэгтгээд ирэх 7 хоногт асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцье.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлье.

17.04 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ